



Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга

Газрын тос, байгалийн хий
болон ашигт малтмалын
баялгийн сайн засаглалын
Дэлхий нийтийн стандарт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН СТАНДАРТ 2023

1-р хэсэг: Зарчим ба шаардлага

2023 оны 6 дугаар сар

2023 ОҮИТБС-ын стандарт
2023 оны 6-р сарын 12-нд нийтлэгдсэн
© ОҮИТБС 2023

Энэ баримт бичгийг Үнэн зөвөөр, буруу мэдээлэл өгөлгүйгээр (логоноос бусад) ямар нэгэн формат хэлбэр эсвэл хэрэгслээр, үнэ төлбөргүйгээр хуулбарлан хэрэглэж, нийтлэн гаргаж болно.
Тухайн материалын зохиогчийн эрхийг ОҮИТБС эзэмшдэг болохыг тусгаж, гарчиг болон эх сурвалжийг заавал дурдсан байна.

Хэвлэлийн эх болон дизайны зохиогчийн эрхийг ОҮИТБС

эзэмшинэ.

ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газар
Rådhusgata 26 0151 Oslo Norway
Tel: +47 222 00 800 Website: www.citi.org E-mail: secretariat@citi.org

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН СТАНДАРТ 2023

Газрын тос, байгалийн хий болон ашигт
малтмалын баялгийн сайн засаглалын
Дэлхий нийтийн стандарт

АГУУЛГА

Өмнөх үг

ОУИТБС-ын стандартын тухай

БҮЛЭГ 1: ОУИТБС-ын зарчмууд

БҮЛЭГ 2: ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болох нь

БҮЛЭГ 3: ОУИТБС-ын шаардлагууд

ШААРДЛАГА 1: Олон талын оролцоот бүлгийн хяналт

- 1.1 Засгийн газрын оролцоо
- 1.2 Компанийн оролцоо
- 1.3 Иргэний нийгмийн байгууллагын оролцоо
- 1.4 Олон талт оролцогчдын бүлэг
- 1.5 Ажлын төлөвлөгөө, хяналт шалгалт

ШААРДЛАГА 2: Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын хамрах хүрээ, гэрээ, тусгай зөвшөөрөл

- 2.1 Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого
- 2.2 Гэрээ хийх болон тусгай зөвшөөрлийн олголт
- 2.3 Тусгай зөвшөөрлийн бүртгэл
- 2.4 Гэрээ ба тусгай зөвшөөрөл
- 2.5 Эцсийн өмчлөгч
- 2.6 Төрийн оролцоо

ШААРДЛАГА 3: Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл

- 3.1 Хайгуулын үйл ажиллагаа
- 3.2 Үйлдвэрлэлийн өгөгдөл мэдээлэл
- 3.3 Экспортын өгөгдөл мэдээлэл
- 3.4 Хүлэмжийн хийн ялгаруулалт

ШААРДЛАГА 4: Орлого төвлөрүүлэлт

- 4.1 Татвар болон орлогыг цогцоор нь ил тод болгох
- 4.2 Үйлдвэрлэлээс төрд ноогдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого.
- 4.3 Дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бартерын солилцоо.
- 4.4 Тээвэрлэлтийн орлого
- 4.5 Төрийн өмчит аж ахуйн нэгжтэй холбоотой гүйлгээ
- 4.6 Орон нутагт хийгдэж буй төлбөр
- 4.7 Мэдээллийг задлах түвшинPgg
- 4.8 Мэдээллийн хамрах хугацаа/ цаг хугацаат байдал
- 4.9 Мэдээллийн чанар ба баталгаажуулалт.
- 4.10 Төслийн зардал

ШААРДЛАГА 5: Орлогын удирдлага ба хуваарилалт

- 5.1 Орлогын хуваарилалт
- 5.2 Орон нутаг дахь шилжүүлэг
- 5.3 Орлогын удирдлага ба зарцуулалтын талаарх нэмэлт мэдээлэл

ШААРДЛАГА 6: Нийгэм, эдийн Засгийн зарцуулалт

- 6.1 Олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийгэм, байгаль орчны чиглэлийн зарцуулалт
- 6.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй/ төсвийн шинжтэй төлбөр.
- 6.3 Олборлох салбарын эдийн засагт оруулах хувь нэмэр

6.4 Олборлох үйлдвэрлэлийн салбараас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл

ШААРДЛАГА 7: Үр дүн ба нөлөө

7.1 Олон нийтийн хэлэлцүүлэг

7.2 Мэдээллийн хүртээмж болон нээлттэй мэдээлэл

7.3 ОУИТБС-ын хэрэгжилтээс гарах зөвлөмжүүд

БҮЛЭГ 4: ОУИТБС-ыг дэмжиж буй компаниудаас хүлээх хүлээлт

БҮЛЭГ 5: Протокол: Иргэний нийгмийн оролцоо

БҮЛЭГ 6: ОУИТБС-ын Ёс зүйн дүрэм

БҮЛЭГ 7: ОУИТБС-ын нээлттэй мэдээллийн бодлого

ӨМНӨХ ҮГ



ОУИТБС нь 2023 онд 20 жилийн ой, ОУИТБС-ын стандартыг нэвтрүүлсний 10 жилийн ойг хоёуланг нь тэмдэглэж байна. Улс орны байгалийн баялгаас бүх иргэд ашиг хүртэхийг баталгаажуулах ОУИТБС-ын үүрэг нь уур амьсгалын хямрал хурцдаж буй өнөө үед өндөр ач холбогдолтой хэвээр байна. Анх удаагаа эрчим хүчний томоохон шилжилттэй холбоотой нээлттэй байдлыг ОУИТБС-ын стандарт оруулсанаар эрчимтэй хөгжиж буй эрчим хүчний салбарт яриа хэлэлцээ, өөрчлөлт хийх хэрэгсэл болох боломжийг нээж өгч байна. Уур амьсгалын асуудлыг шийдвэрлэх хүрээнд цэвэр эрчим хүч рүү шилжиж байгаа онцгой нөхцөл байдал байгалийн баялгийн салбарыг өөрчлөгдөхөд хүргэж байна. Олон улс орнууд дахь байгалийн баялгийн ач холбогдлын хослол, тэдний ашиг тусыг урт хугацаанд ард иргэдэд хүртээх сорилтууд, мөн эрчим хүчний шилжилт нь шилжилтийн энэ эрин үед эдгээр нөөцийн сайн засаглал урьд өмнөхөөс илүү чухал болж байна гэсэн үг юм.

Ил тод, хүртээмжтэй, чанартай мэдээлэл нь Засгийн газар, компаниуд, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудад байгалийн нөөцийн менежментийн талаар шийдвэр гаргахад шаардлагатай хэвээр байна. ОУИТБС-ын стандарт нь зөвхөн ил тод байдал, тунгалаг байх шаардлагатай гэж үзэхээс гадна оролцоо ба хариуцлагыг чухалчилдаг. Үүнтэй холбогдуулан иргэний эрхийг хамгаалахад ОУИТБС-ын Стандартуудыг зайлшгүй хэрэгжүүлэх нь амин чухал юм. ОУИТБС-ын шинэчилсэн стандартыг хэрэгжүүлэх явцад олборлох салбарын засаглалын гүйцэтгэх үүрэг маш чухал юм. Энэ нь хөгжиж буй байгалийн нөөцийн нөхцөл байдалд хоёр янзаар хариу үйлдэл үзүүлдэг.

Нэгдүгээрт, шатах түлшнээс татгалзах зайлшгүй шаардлагад үндэслэн, нүүрстөрөгчийн татвар, үнийн механизм, хүлэмжийн хийн ялгаруулалт, үйлдвэрлэлийн зардал, нөөц ба татаас гэх мэтийг ил тод болгох зэрэгтэй холбоотой маш чухал шинэ шаардлагууд гарч ирж байна. Орлогын таамаглал болон компаниудын зардлын талаарх мэдээллийг ил болгох нь хүлээгдэж буй орлого, хөрөнгө оруулалтын шийдвэрийн талаарх олон нийтийн ойлголтыг бэхжүүлэхийн зэрэгцээ хүлэмжийн хийн ялгаруулалтын талаарх мэдээллийг бодлого боловсруулагчид, иргэд, хөрөнгө оруулагчдад чиглүүлэхэд ашиглаж болно.

Хоёрдугаарт, эрчим хүчний шилжилтийг дэмжсэн ашигт малтмалын үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор сайн засаглал, тогтвортой нийлүүлэлтэд гүйлгээний нөхцөл, тэдгээрээс хэн ашиг хүртэх талаар ил тод байх нь амин чухал юм.

Жендерийн тэгш байдал, нийгэм, байгаль орчны хяналт, нөлөөлөл, бичил уурхай, олон нийтийн хэлэлцүүлэг зэрэг гол дэд салбаруудыг ил тод болгох шинэ, чангатгасан шаардлагууд нэмэгдэж орсныг анхааралдаа аваарай.

ОУИТБС-ын хариуцах хүрээнд нийцүүлэн 2023 оны ОУИТБС-ын стандартад авлигатай тэмцэх чухал, тодорхой зорилтуудыг тайлагнуулах асуудлыг оруулсан байгаа. Олборлох салбарт ашиг сонирхлын зөрчил, улс төрд оролцож буй хүмүүсийн оролцоог илрүүлэхэд чухал ач холбогдолтой мэдээллийг ил тод болгож байна. ОУИТБС-ын шинэ стандартад ОУИТБС-ын тайланд оролцож буй бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит аж ахуйн нэгжүүд авлигатай тэмцэх бодлогоо олон нийтэд ил тод мэдээлнэ гэсэн хүлээлтийг бий оруулж өгсөн. Ерөнхийдөө ОУИТБС-ын стандартын гол гол хамрах асуудлын хүрээнд, мөн ОУИТБС-д оролцогч бүх талуудын хамтын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор ОУИТБС-ын энэхүү стандартад нь эрчим хүчний шилжилттэй холбогдсон шинэ ил тод мэдээллүүдийг хувийн болон төрийн компаниуд тайлагнах ёстойг оруулж өгсөн. Ийнхүү 2023 оны ОУИТБС-ын стандарт нь байгалийн баялгийн сайн засаглалын илүү өндөр, хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд зориулагдаж байна. Энэ нь эрчим хүчний шилжилтийг ОУИТБС-ын стандартад анх удаа нэгтгэсэн бөгөөд үндсэндээ ч тийм юм. Энэ нь үндэсний түвшний олон талт бүлгүүдэд хамгийн чухал сорилт, боломжуудыг өөрсдийн нөхцөлд авч үзэх, ОУИТБС-ын шаардлагын хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлээ тодорхойлох боломжийг нээж өгдөг. Энэ нь улс орнуудад ОУИТБС-ын хэрэгжилтийн ач холбогдлыг нэмэгдүүлж, бүх оролцогч талуудын хамтын хариуцлагын хүрээнд байгалийн нөөцийн нээлттэй, хариуцлагатай менежментийг ахиулахад тусалдаг.

РТ Хон. Хелен Кларк
ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн дарга

ОУИТБС-ын стандартын тухай

Энэхүү баримт бичиг нь ОУИТБС-ын стандартын **1-р хэсгийг** "Зарчмууд ба шаардлага" хамарч, дараах бүлгүүдээс бүрдэнэ.

- **ОУИТБС-ын зарчмууд:** ОУИТБС-ын стандарт нь 2003 онд анх үүсгэн байгуулагдах үедээ улс орнууд, компаниуд болон иргэний нийгмийн байгууллагуудын харилцан тохиролцсон олборлох үйлдвэрлэлийн орлого төлбөрийн тунгалаг байдлыг сайжруулах ОУИТБС зарчмуудаас эхтэй. (1-р бүлэг)
- **ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болох нь:** ОУИТБС-ын Стандартыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улс орнууд ОУИТБС хэрэгжүүлэгч орон болох тухай (2-р бүлэг) хэсэгт дурьдсанчлан ОУИТБС хэрэгжүүлэгч орон болохын тулд өргөдөл гаргахаас өмнө хэд хэдэн алхам хийх шаардлагатай.
- **ОУИТБС-ын шаардлагууд:** ОУИТБС-ын стандарт нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй улс орнууд болон эдгээр улсад үйл ажиллагаа явуулж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудад тавигдах ОУИТБС-ын шаардлагыг (3-р бүлэг) тодорхойлсон. Засгийн газар, аж үйлдвэр, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн үндэсний олон талт бүлэг нь ОУИТБС-ын хэрэгжилтэд хяналт тавьж, олборлох салбарын менежментийн үндэсний тэргүүлэх чиглэлийг тусгасан зорилтуудыг дэвшүүлдэг.
- **ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлт:** Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнуудад тайлагнаж, олон талт бүлгүүдэд оролцох замаар ОУИТБС-ын үйл явцад идэвхтэй оролцож, ОУИТБС-ын стандартыг мөрддөг. ОУИТБС-ыг дэмжигч компаниудыг цаашид дэмжих. ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлтийг хангах замаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх (4-р бүлэг).
- **Протокол: Иргэний нийгмийн оролцоо:** ОУИТБС-ын зорилгод хүрэхэд иргэний нийгмийн оролцоо чухал. Протокол: Иргэний нийгмийн оролцоо (5-р бүлэг) нь ОУИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгмийн бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцоог хангах тухай заалтуудыг тусгасан.
- **ОУИТБС-ын Холбооны Ёс зүйн дүрэм:** Оролцогч талууд шударга ёс, ёс суртахууны дээд хэм хэмжээг сахин мөрдөж, ОУИТБС-ын Холбооны Ёс зүйн дүрэм (6-р бүлэг)-ийн дагуу үнэнч шударга, шударга ажиллахыг шаарддаг. Энэ нь ОУИТБС-ын Холбооны гишүүд, ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүд, тэдгээрийн орлон тоглогчид, нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнууд (үндэсний болон олон улсын) болон олон талын оролцогчдын бүлгийн гишүүд зэрэг ОУИТБС-ын бүх албан тушаалтнуудад хамаарна.
- **Нээлттэй мэдээллийн бодлого:** Байгалийн нөөцийн нээлттэй, хариуцлагатай менежментийг дэмжих ОУИТБС-ын эрхэм зорилгын цөм нь нээлттэй өгөгдөл юм. Мэдээллийг хялбархан хүртээмжтэй, ойлгомжтой, ашиглах боломжтой болгосноор ОУИТБС-ын тайлан нь олон нийтийн хэлэлцүүлгийг идэвхжүүлж, шийдвэр гаргалтанд мэдээлэл өгч, байгалийн нөөцийн менежментийн талаарх олон нийтийн ойлголтыг дэмжих болно. Эдгээр зорилтууд нь ОУИТБС-ын Нээлттэй мэдээллийн бодлого (7-р бүлэг)-д тулгуурладаг.

ОУИТБС-ын Стандартын **2-р хэсэг** ("ОУИТБС-ын Зөвлөлийн хяналт ба баталгаажуулалт") нь ОУИТБС-ын стандартын хэрэгжилтэд олон улсын зөвлөл хэрхэн хяналт тавьж, үнэлдэгийг тодорхойлдог журам, шалгуурыг тодорхойлсон. **3-р хэсэг** ("ОУИТБС-ын засаглал ба удирдлага") ОУИТБС-ын холбоог хэрхэн удирддаг талаар тусгасан.

ОУИТБС-ын төрөл бүрийн асуудлуудыг хэрэгжүүлэх удирдамжийн хамт ОУИТБС-ын стандартыг бүрэн эхээр нь ОУИТБС-ын вэбсайтаас (www.eiti.org) авч ашиглаж болно.

БҮЛЭГ 1

ОУИТБС-ЫН ЗАРЧМУУД

Энэ бүлэгт ОУИТБС-ыг 2003 онд байгуулахад тохиролцсон бүх оролцогч талуудын нийтлэг зорилго, амлалтыг тусгасан болно.

Одоо ОУИТБС гэж нэрлэгддэг зүйл нь 2003 оны 6-р сард Ланкастер Хаусын бага хурлаар тохиролцсон ОУИТБС-ын зарчмуудын анхны мэдэгдлээс үүссэн. Өнөөдөр ОУИТБС-ын стандарт нь энэхүү болон ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд тавигдах бүх шаардлагыг агуулж байна. Эдгээр итгэл үнэмшил, зорилгыг ОУИТБС-ын бүх оролцогч талууд дэмжиж байна.

ОУИТБС-ын Зарчмууд нь уг санаачилгын тулгын чулуу юм. Тэдгээр нь:

1. Байгалийн нөөц баялгийг ухаалгаар ашиглах явдал нь тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг, эдийн Засгийн тогтвортой өсөлтийн чухал хөдөлгөгч хүч бөгөөд харин буруу удирдвасаас эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагаврыг үүсгэх аюултай гэдэгт бид итгэдэг бөгөөд бусдад түгээн хуваалцана.
2. Байгалийн нөөц баялгийг улс орныхоо иргэдийн сайн сайхны төлөө удирдан үндэснийхээ хөгжлийн ашиг сонирхолд нийцүүлэх нь тухайн бүрэн эрхт ЗЗасгийн газрын хэрэгжүүлэх ёстой ажил гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.
3. Байгалийн нөөц баялгаа ашиглах нь олон арван жилийн орлогын урсгал байх ба энэ нь зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байдаг гэдгийг бид хүлээн зөвшөөрдөг.
4. Улсын төсвийн орлого, зарлагын талаарх олон нийтийн ойлголт нь тогтвортой хөгжлийн төлөө бодитой, оновчтой шийдлүүдийн талаар нийтээр хэлэлцэж, мэдээлэхэд тусалдаг гэдгийг бид мэддэг.
5. Олборлох салбарт төр, компаниуд ил тод байх нь чухал бөгөөд олон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг бид онцолж байна.
6. Гэрээ болон хууль тогтоомжийг дээдэлж байж илүү ил тод байдлыг хангана гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна.
7. Санхүүгийн ил тод байдал нь дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж байгааг бид хүлээн зөвшөөрч байна.
8. Засгийн газраас бүх иргэдэд хандсан орлогын урсгал, нийгмийн зардлын эргэн тайлагнах хариуцлагатай байдлын зарчим чухал гэдэгт бид итгэлтэй байдаг.
9. Нийгмийн амьдрал, Засгийн газрын үйл ажиллагаа, бизнест ил тод байдал, хариуцлагын өндөр стандартыг бид урамшуулан дэмжих зорилготой.
10. Төлбөр, орлогыг ил тод болгох, хэрэглэх, хэрэгжүүлэхэд энгийн хялбар, өргөн хүрээнд таарч тохирохуйц, үр ашгаа өгөх аргачлал шаардлагатай гэдэгт бид үздэг.
11. Тухайн улсад төлбөрийг ил болгох үйл явц нь тухайн улс дахь олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудыг хамрах ёстой гэж бид итгэдэг.
12. Ил тод байдлыг хангахад Засгийн газар, түүний харьяа яам, агентлагууд, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, туслан гүйцэтгэгчид, олон талын оролцоотой байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагууд зэрэг бүхий л оролцогч талууд чухал үүрэг, оролцоотой байдаг гэдэгт бид итгэдэг.

ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ОРОН БОЛОХ НЬ

Энэ хэсэгт ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болох хүсэлт гаргахыг хүссэн улс орнуудын үйл явцыг тодорхойлсон.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй улс нь ОУИТБС-ыг цаашид хэрэгжүүлэх Нэр дэвшигч орон болох хүсэлт гаргахын өмнө хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь Засгийн газрын оролцоо, хүсэл эрмэлзэл (Шаардлага 1.1), Компанийн оролцоо (Шаардлага 1.2), Иргэний нийгмийн оролцоо (Шаардлага 1.3), Олон талт оролцогчдын бүлэг байгуулах нь (Шаардлага 1.4) болон ОУИТБС-ын ажлын төлөвлөгөөг зөвшилцөх, үнэлгээ хийх (Шаардлага 1.5) зэрэг байна. Тухайн улс эдгээр алхамуудыг хэрэгжүүлж дуусаад ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болохыг хүсч байвал Засгийн газар нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэлт буюу өргөдлийг ОУИТБС-ын Удирдах хороонд хүргүүлэх ёстой (Доороос үзнэ үү).

ОУИТБС-д нэгдэн орохоор бэлтгэж буй улс орнуудыг ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болох бэлтгэл ажлынхаа нэг хэсэг болгон ил тод болгох үндэслэлийг системтэй хийх эсвэл системтэйгээр ил тод болгох боломжуудыг шийдвэрлэх замаар эхнээс нь системтэйгээр ил болгоход учирч болзошгүй саад бэрхшээлийг тодорхойлохыг зөвлөж байна.

Хэрхэн ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орон болох вэ?

Тухайн улс орон нь ОУИТБС-д элсэн орох алхамуудыг бүрэн хэрэгжүүлэн, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх орон болохыг хүсч байвал Засгийн газар нь Олон талт оролцогчдын бүлгийн дэмжлэгтэйгээр батлагдсан өргөдлийн маягтыг¹ ашиглан, ОУИТБС-ын өргөдлийг өгөх ёстой. Тухайн хүсэлт буюу өргөдөлд өнөөдрийг хүртэл авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон элсэн орох явцын арга хэмжээ нэг бүрийг авч хэрэгжүүлсэн болохыг харуулсан нотолгоог дурдсан байх ёстой. Хүсэлтэд ОУИТБС-д оролцсон Засгийн газар, иргэний нийгэм болон хувийн салбарын оролцогчидтой холбоо барих мэдээллийг оруулсан байх ёстой.

Өргөдөл гаргасны дараа тухайн хүсэлтийг ОУИТБС-ын вэбсайт дээр олон нийтэд нээлттэйгээр байршуулна. ОУИТБС-ын Удирдах хороо нь өргөдлийг хянан, элсэн орох явцын урьдчилсан арга хэмжээг зохих ёсоор авч хэрэгжүүлсэн эсэхийг үнэлнэ. Олон улсын нарийн бичгийн газар нь хамаарах ямар нэгэн асуудлуудын талаар тодруулга авах зорилгоор тухайн хүсэлт гаргасан улсын Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжилтийн удирдан ажиллахаар томилогдсон албаны этгээдтэй нягт хамтран ажиллана. Үүний дагуу болон аливаа бусад боломжит мэдээлэлд тулгуурлан ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн Сурталчилгаа болон нэр дэвшүүлэх асуудал хариуцсан хороо нь бодит үндэслэлтэй хугацаанд багтаан тухайн орны хүсэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар ОУИТБС-ын Удирдах зөвлөлдхандан зөвлөмж гаргана. ОУИТБС-ын Удирдах зөвлөл эцсийн шийдвэрийг гаргана.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь хүсэлт хүлээн авснаас хойш 8 долоо хоногийн хугацаанд багтаан өргөдлийг хянан үзнэ. Удирдах зөвлөл нь өөрийн албан ёсны хурлын үеэр Нэр дэвшигч орныг хүлээн зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргахыг илүүд үздэг. Хурал хоорондын хугацаа урт байх тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөл захирамж гарган шийдвэр гаргаж болно.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Нэр дэвшигчийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ ОУИТБС-ын анхны тайланг нийтлүүлэх болон Баталгаажуулалт хийлгэх хугацааг тогтооно. Санаачилгыг хэрэгжүүлэгч орон нь ОУИТБС-ын анхны тайланг бүртгэн авснаас хойш 18 сарын хугацаанд багтаан гаргах ёстой. Нэр дэвшигч орны статустай болсноос хойш 2.5 жилийн дотор Баталгаажуулалтыг эхлүүлэхийг шаарддаг. Тайлан гаргах болон Баталгаажуулалтын эцсийн хугацаатай холбоотой мэдээлэл болон эдгээр эцсийн хугацаанд хамрах зүйлсийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг ОУИТБС-ын хэрэгжилт дэх Удирдах зөвлөлийн хяналт хэмээх хэсгийн 4 дүгээр хэсэгт заасан байдаг.

Тайлан гаргах болон Баталгаажуулах эцсийн хугацааны талаарх нэмэлт мэдээллийг (эдгээр хугацааг сунгах хамрах хүрээг оруулаад) ОУИТБС-ын Стандартын **2-р хэсгийн** “ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хяналт” хэсэгт тодорхойлсон.

¹ Стандарт өргөдлийн маягтыг ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас авах боломжтой.

БҮЛЭГ 3

ОУИТБС-ын шаардлагууд

Энэхүү хэсэгт ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнуудын заавал ханган биелүүлэх шаардлагуудын талаар дурдав.

2023 оны ОУИТБС-ын стандартад газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт эрчим хүчний шилжилтийн нөлөөллийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, бодлого боловсруулахад мэдээлэл өгөх зорилготой шаардлагуудыг нэмж оруулсан. Энэ нь авлигын эрсдэлийг арилгах, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн шаардлагуудыг улам чухал болгож байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орны олборлох салбарын засаглалын хамгийн чухал сорилтуудыг шийдвэрлэхэд ОУИТБС-ын хэрэгжилтийг хангах олон талт бүлгүүд гол үүрэг гүйцэтгэдэг. ОУИТБС-ын шаардлагууд нь заавал хангах хамгийн бага шаардлага бөгөөд оролцогчид зохистой гэж үзсэн тохиолдолд хэрэгжүүлэгч улс орнуудыг тэдгээр шаардлагуудаас илүү гарч ажиллахыг хөхиүлэн дэмждэг. Оролцогчд талуудад ОУИТБС-н шаардлагуудыг гүйцэтгэх явцад нэмэлт зөвлөмж зааварчилгааг citi.org/guide линкээс авах боломжтой.

Нэр томьёоны тайлбар

Заавал биелүүлэх шаардлага

ОУИТБС-ын стандартад дурдсан ‘ёстой’, ‘тэгэх ёстой’, ‘шаардлагатай’ (must, should, required) хэмээх нэр томьёо нь заавал биелүүлэх зүйлс гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд ОУИТБС-ын стандартын баримтлалын үнэлгээнд эдгээрийг харгалзан үздэг.

Хүлээгдэж буй шаардлага

ОУИТБС-ын стандарт дахь “хүлээгдэж буй” гэсэн нэр томьёо нь олон талт оролцогчдын бүлэг асуудлыг авч үзэж, түүний хэлэлцүүлгийг баримтжуулах, задруулах/ задруулахгүй байх үндэслэл, ил болгоход учирч буй аливаа саад бэрхшээлийг илтгэнэ. Баталгаажуулалт нь олон талт бүлгийн хэлэлцүүлгийг авч үзэж, баримтжуулна.

Хөхүүлэн дэмжсэн шаардлага

ОУИТБС-ын стандартад дурдсан ‘хөхүүлэн дэмжсэн’ мөн ‘чадах’ (encouraged, could) гэх нэр томьёо нь асуудлыг заавал биш сонголттой гэдгийг харуулна. Олон талт оролцогчдын бүлгийн хүчин чармайлтыг Баталгаажуулалтад баримтжуулах хэдий ч ОУИТБС-ын стандартын баримтлалыг ерөнхийд нь үнэлэхэд харгалзан үзэхгүй.

Системтэйгээр ил тод болгох

“Системтэйгээр ил тод болгох” гэсэн нэр томьёо нь төрийн болон компанийн вэб сайт, албан ёсны сэтгүүл, хэвлэлээр дамжуулан тогтмол, цаг тухайд нь, олон нийтэд хүртээмжтэй мэдээллийг ил тод болгохыг хэлнэ. Системтэйгээр ил тод болгож буй мэдээллийг зөвшөөрөгдсөн Засгийн газрын болон компанийн платформоор (“эх сурвалж дээр”) дамжуулан тухайн өгөгдөл мэдээллийг хариуцдаг аж ахуйн нэгж хэвлэн нийтэлнэ. Ийм мэдээлэлд тусгай зөвшөөрлийн бүртгэл, гэрээнүүд, компаниудын эцсийн өмчлөгч, төсвийн тайлан мэдээлэл, жилийн санхүүгийн тайлан, бусад нээлттэй мэдээллийн порталуудыг багтаан ойлгоно.

Системтэйгээр ил тод болгох гэдэг нь хүлээгдэж буй хүлээлт бөгөөд үүн дээр нэмээд ОУИТБС-ын Тайлан нь нөхцөл байдлын талаарх нэмэлт мэдээлэл өгч, системтэйгээр ил тод болгож буй мэдээллийн эх сурвалжийг зааж, мэдээллийн чанартай холбоотой ямар нэгэн орхигдолгүй байх эсвэл асуудлыг хамарч байх тэрхүү нөхцөл юм. ОУИТБС-ын хүрээнд цуглуулсан нийтэд нээлттэй мэдээлэл/өгөгдлийг иш татан заах байдлаар ОУИТБС-ын ил тод болгох шаардлагыг ханган биелүүлж болно.

ШААРДЛАГА 1

Олон талын оролцогчдын бүлгийн хяналт

ОУИТБС нь Засгийн газар, компаниуд болон иргэний нийгмийн бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцоог хамарсан олон талт оролцогчдын бүлгийг ажиллуулах зэрэг үр дүнтэй олон талын хяналтыг шаарддаг.

1.1 Засгийн газрын оролцоо.

Энэхүү шаардлагын зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийг бүх талаас нь идэвхжүүлэн дэмжих арга хэрэгсэл болгон улс төрийн өндөр түвшний удирдлага, үйл ажиллагааны оролцооны аль алианаар дамжуулан ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын бүрэн, идэвхтэй, үр дүнтэй удирдлагыг хангах явдал юм.

- Засгийн газар нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаарх өөрийн хүсэл эрмэлзлийг ойлгомжтой, тодорхой байдлаар олон нийтэд мэдэгдэх үүрэгтэй. Энэхүү мэдэгдлийг төрийн эсвэл гүйцэтгэх засаглалын тэргүүн эсвэл тэдний томилсон Засгийн газрын төлөөлөл хийх ёстой;
- Засгийн газар нь ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан ажиллах, өндөр албан тушаалтныг томилон ажиллуулах үүргийг хүлээнэ. Тухайн томилогдсон этгээд нь бүх оролцогч талуудын итгэлийг хүлээж, ОУИТБС-ын үйл ажиллагааг яам, агентлагуудын хүрээнд уялдуулан эрхлэн явуулах эрх мэдэл, хараат бус эрх чөлөөтэй байхын зэрэгцээ санаачилгын хэрэгжилтэд зориулан нөөц эх үүсвэрийг дайчлах эрх бүхий этгээд байх шаардлагатай;
- Засгийн газар нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох ёстой;
- Олон талт оролцогчдын бүлэгт төрийн өндөр албан тушаалтны төлөөлөл орсон байхыг Засгийн газраас баталгаажуулна.

1.2 Компанийн оролцоо.

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох компаниудыг ОУИТБС-д бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцох, мөн олон талын оролцоот бүлгийн үйл ажиллагаанд оролцох, нээлттэй байх, Засгийн газар компаниудад таатай орчныг бүрдүүлэхэд оршино. Энэ шаардлага нь ОУИТБС-д хамрагдаж буй тайлагнадаг компаниуд өөрсдийн туршлагыг ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлтэд тодорхойлсон сайн засаглалын зарчмуудтай уялдуулахад чиглэгддэг².

- Компаниуд нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох үүргийг хүлээнэ;
- Тайлан өгдөг компаниудаас авилгалтай тэмцэх тодорхой бодлогоо хэвлэн нийтлэх, авилгалын эрсдэлийг хэрхэн удирдах түүн дотороо эцсийн өмчлөгчийн мэдээллийг яаж ил тод болгох талаар хүлээж байгаа. Олон талын оролцоот бүлэгт хамрагдаж буй компаниудад нягт нямбай үнэлгээ дүгнэлт хийх ёстой.
Бусад тайлагнадаг компаниуд дээр ч мөн адил нягт нямбай шалгалтын үйл ажиллагаа явуулахыг хөхүүлэн дэмжинэ.
- Засгийн газар нь компаниудад ОУИТБС-ыг практик бодит байдал дээр хэрэгжүүлэх орчин болох холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бүрдүүлж өгөх шаардлагатай. ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй компанийн төлөөллийн үндсэн суурь эрх нь олон талын оролцоот бүлэгт орсон гишүүдээр хязгаарлагдахгүй ба тэрхүү эрхийг хүндэтгэн үзнэ.
- Компаниуд ОУИТБС-ын үйл явцад оролцоход Засгийн газраас саад учруулахгүй байх шаардлагатай.

1.3 Иргэний нийгмийн байгууллагын оролцоо.

Энэхүү шаардлагын зорилго нь ОУИТБС-ын үйл явцад иргэний нийгмийг бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцуулах, холбогдох орчин бүрдүүлэхэд оршино. ОУИТБС-ын үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцох нь ОУИТБС-аас бий болгосон ил тод байдлыг хариуцлагатай болгох, газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын засаглалыг сайжруулах гол түлхүүр юм.

Иргэний нийгмийн протоколын дагуу³:

- Иргэний нийгэм нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох ёстой;
- Засгийн газар нь холбогдох хууль тогтоомж, зохицуулалт, захиргааны хэм хэмжээ, мөн ОУИТБС-ын хэрэгжилтийн бодит үйл явц практиктай холбоотой иргэний нийгмийн

² ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлтийг үзнэ үү (ОУИТБС-ын Стандартын 1-р хэсгийн 4-р бүлэг).

³ Протокол: Иргэний нийгмийн оролцоо (ОУИТБС-ын Стандартын 1-р бүлгийн 5-р хэсэг) хэсгийг үзнэ үү.

- оролцооны орчныг бүрдүүлэх шаардлагатай. Түүнчлэн, ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцож буй иргэний нийгмийн төлөөллийн үндсэн эрх, үүнд Олон талт оролцогчдын бүлгийн гишүүнээр ажиллах болон эдгээрээр үл хязгаарлагдах бусад холбогдох эрхийг хүндэтгэн үзэх ёстой;
- c) Засгийн газар нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд иргэний нийгмийн төлөөлөл оролцоход ямар нэгэн хязгаарлалт, саад бэрхшээл учрахгүй байхыг баталгаажуулах шаардлагатай;
 - d) Засгийн газар нь ОУИТБС-ын хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг хязгаарлах, хумих зорилго бүхий ямар нэгэн үйл ажиллагаа явуулахаас татгалзах ёстой;
 - e) Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд болон тэдгээрээр үл хязгаарлагдах бусад холбогдох оролцогч тал нь:
 - i. Ил тод байдал, байгалийн нөөц баялгийн засаглалын асуудлаар өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байна;
 - ii. ОУИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд хангалттай хэмжээнд оролцдог байх ба энэ нь олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулдаг байна;
 - iii. Өөр хоорондоо хамтран ажиллах, харилцаа холбоотой байх эрхтэй;
 - iv. ОУИТБС-ын талаарх өөрийн үзэл бодлыг ямарваа хязгаарлалт, албадлага, бусдаас зөвшөөрөл авахгүйгээр илэрхийлэх чадвартай байна.
 - f) Олон талт оролцогчдын бүлэг нь Протоколыг даган мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина. Илэрсэн дутагдал, түүнийг арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой иргэний нийгмийн оролцоо, хэлэлцүүлгийг баримтжуулах.

1.4 Олон талт оролцогчдын бүлэг.

Энэхүү шаардлагын зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийн бүхий л тал дээр идэвхтэй, утга учиртай хяналт тавьж чадах бие даасан олон талт бүлгийг сонгогч гурван үндсэн оролцогч талын (Засгийн газар, аж үйлдвэр, иргэний нийгэм) ашиг сонирхлыг тэнцвэржүүлсэн байдлаар хэрэгжүүлэхэд оршино. Үүгээрээ зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрт хүрдэг байх.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болгон олон талт оролцогчдын бүлэгт нээлттэй, шударга, ил тод журмын үндсэн дээр томилогдсон гол оролцогч талуудын хангалттай төлөөлөл байх ёстой. Бүлэг цогц байдлаар шийдвэр гаргаж өргөн хүрээний тойрогт тайлагнана.

- a) Засгийн газар иргэний нийгэм, компаниудтай хамтран ажиллах, ОУИТБС-ын хэрэгжилтэд хяналт тавих олон талын оролцоотой бүлэг байгуулах ажлуудыг хариуцана. Олон талт бүлгийг байгуулахдаа Засгийн газар дараахь зүйлийг хийх ёстой. Үүнд:
 - i. Олон талын оролцоот бүлэгт орох урилгыг нээлттэй, ил тод байлган хүргүүлэх;
 - ii. Олон талын оролцоот бүлэгт оролцогч талууд хангалттай төлөөлөлтэй байх боловч энэ нь оролцогч талуудын төлөөлөл тооны хувьд заавал ижил байна гэсэн үг бус юм. Олон талт оролцогчдын бүлэг нь хувийн хэвшил, иргэний нийгэм тэр дундаа хараат бус иргэний нийгмийн бүлгүүд, хэвлэл мэдээлэл, мэргэжлийн эвсэл холбоод, мөн холбогдох төрийн байгууллагууд, парламентын гишүүдийн төлөөлөл болон эдгээрээр үл хязгаарлагдах бусад талуудын төлөөллөөс бүрдсэн байх шаардлагатай. Түүнчлэн оролцогч талын бүлэг бүр нь өөрийн төлөөллийг томилох эрхтэй байх бөгөөд олон ургалч байдал, үзэл бодлын олон талт байдлыг үүнд харгалзан үзсэн байх ёстой. Бүлгийн гишүүнд нэр дэвшүүлэх үйл явц нь хараат бус, тухайн гишүүнийг ямар нэгэн байдлаар бусдаас албадан санал болголгүйгээр явагдах шаардлагатай. ОУИТБС-ын олон талт оролцогчдын бүлгийн гишүүнээр оролцож буй иргэний нийгмийн байгууллага нь үйл ажиллагаа, бодлогын хувьд төр болон компаниудаас хараат бус байх ёстой. Олон талын оролцогчдын бүлэг болон үүнийг бүрдүүлж буй бусад бүлэг нэг бүр нь жендерийн ялгаатай байдлыг арилгахад хувь нэмэр оруулах зорилгоор жендерийн тэнцвэрийг хангах ёстой;
 - iii. Олон талт оролцогчдын бүлгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгоход анхаарал хандуулах.
- b) Олон талт оролцогчдын бүлэг нь өөрийн хийж гүйцэтгэх ажил үүргийн тодорхойлолтыг/ажлын даалгаврыг олон нийтэд нээлттэйгээр зарлах шаардлагатай. Уг ажил үүргийн тодорхойлолтод наад зах нь дараах заалтууд орсон байх ёстой. Үүнд:

Олон талт оролцогчдын бүлгийн гишүүдийн үүрэг роль, хариуцах ажил, эдлэх эрх:

- i. Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд нь өөрсдийн үүргийг гүйцэтгэх чадавхтай байх;
- ii. Олон талт оролцогчдын бүлэг нь хэвлэл мэдээлэл, цахим хуудас, захидал харилцаагаар дамжуулан өөрийн оролцогч талууд, компаниудад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх Засгийн газрын хүсэл эрмэлзэл, компани болон иргэний нийгмийн гүйцэтгэх үндсэн үүрэг ролийн талаар мэдээлж, үр дүнтэйгээр олон нийтэд хүрч ажиллах ёстой. Мөн ОУИТБС-ын үйл ажиллагааны үр дүн болон гарч буй мэдээллийг олон нийтэд өргөн хүрээтэйгээр түгээн дэлгэрүүлдэг байх;
- iii. Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд нь өөрийн сонгогдон төлөөлж буй бүлэгтэй нягт холбоотой ажиллана.

iv.

Ажлын төлөвлөгөөг батлан гаргах, хэрэгжилтэд хяналт тавих:

- v. Олон талт оролцогчдын бүлэг нь жил тутмын ажлын төлөвлөгөөг Шаардлага 1.5 дээр заасны дагуу хэлэлцэн батлах;
- vi. Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын тайлан гаргах үйл явцыг хянан, Баталгаажуулах ажилд оролцох.
- vii. Олон талт оролцогчдын бүлгээс олборлох үйлдвэрлэлийн засаглалтай холбоотой асуудлууд, тэр дундаа авлигатай тэмцэхтэй холбоотой нэмэлт үйл ажиллагаа, эрчим хүчний шилжилтийн шинэчлэл, жендэрийн тэгш байдал, бичил уурхай (боломжтой бол) асуудал зэргийг авч үзэх.

Дотоод засаглалын дүрэм, журам:

- viii. ОУИТБС нь хэрэгжилтийн бүхий л явцад оролцогч тал нэг бүрийг түнш гэдэг утгаар хандаж бүгдийн оролцоог хамарсан, хангасан байдлаар шийдвэр гаргаж байхыг шаарддаг. Олон талт оролцогчдын бүлгийн аль ч гишүүн хэлэлцүүлэх асуудал санал болгон дэвшүүлэх бүрэн эрхтэй. Олон талт оролцогчдын бүлэг нь оролцогч талын төлөөллийг нэр дэвшүүлэх, өөрчлөх, шийдвэр гаргалт, мандатын (гишүүнээр ажиллах хугацаа) эрхийн хүчинтэй хугацаа, хурлын давтамж зэрэг асуудлыг хэлэлцэн зөвшилцөлд хүрэх ёстой. Үүнд: 1.4 (а) дүгээр шаардлагад дурдсан зарчмуудтай холбоотой бүлгийг төлөөлсөн Ажлын хэсгийн гишүүдийг өөрчлөх үйл явц, журмыг гарган, оруулсан байх ёстой. Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын хуралд оролцох томилолтын зардал эсхүл олон талт оролцогчдын бүлгийн гишүүдэд олгох бусад төлбөртэй холбоотой тогтсон журамтай тохиолдолд энэхүү журам нь ил тод байх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байна.
- ix. Уулзалт хурлын товыг урьдчилан мэдэгдэх цаг хугацаа, асуудлыг хэлэлцэх, санал тавихаас өмнө баримт бичгүүдийг тараан танилцуулах цаг хугацаа хангалттай байх ёстой;
- x. Олон талт оролцогчдын бүлэг нь аливаа хэлэлцүүлэг, шийдвэрийг бичгээр баримтжуулж, тэмдэглэл хөтөлж байх ёстой.

1.5 Ажлын төлөвлөгөө, хяналт шалгалт

Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын Удирдах хорооны гаргасан тайлангийн болон Баталгаажуулах эцсийн хугацаанд нийцүүлсэн, гарах зардлыг бүрэн тусгасан ажлын төлөвлөгөөтэй байна. Ажлын төлөвлөгөө нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- a) Олон талт оролцогчидын бүлэг нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хөтлөн явуулна. Ажлын төлөвлөгөө нь олборлох салбарын үндэсний хэмжээнд эн тэргүүнд тавигдах асуудлуудыг тусгасан байна. Ажлын төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгасан байх ёстой.
 - i. ОУИТБС-ын хэрэгжилтийн зорилтууд нь үндэсний тэргүүлэх чиглэлийг тусган, авилгалтай холбоотой асуудлуудыг багтаасан, жендэрийн тэгш байдал; эрчим хүчний шилжилт; орлого төвлөрүүлэхээ; бичил уурхай (боломжтой бол); болон олборлох салбарын засаглалын бусад гол асуудлууд, түүнчлэн гол оролцогч талуудтай зөвлөлдөх зэргийг багтаасан байна.
 - ii. Хэмжигдэхүйц, цаг хугацааны холбоотой үйл ажиллагаа нь тохиролцсон зорилготой байх бөгөөд Баталгаажуулалт болон тайлангаас гарсан саналуудыг тусгана.
 - iii. ОУИТБС-ын аль шаардлагыг нэн тэргүүнд тавьж байгаа тухай үндэслэл, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ямар үйл ажиллагаа нь шаардлага бүрийг биелүүлэхэд хувь нэмрээ оруулж буйг тайлбарлана.
 - iv. Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон бүрэн өртөгтэй төсөв.
- b) Олон талын оролцогчдын бүлэг нь ажлын төлөвлөгөөний явцад жил бүр дүгнэлт хийж дараагийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулна. Явцын үнэлгээ нь дараахь зүйлийг агуулсан байх ёстой.
 - i. Ажлын төлөвлөгөөний зорилгод хүрэхэд гарсан ахиц дэвшил, бэрхшээл, эдгээр зорилгын өөрчлөлт, эдгээр зорилгодоо илүү сайн хүрэхийн тулд хэрэгжилтийг хэрхэн хийх
 - ii. ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр хүрсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тойм
 - iii. Оролцогч талуудад ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар мэдээллийг ямар механизмаар өгөхийг тодорхойлох, түүнчлэн оролцогч талуудын санал бодлыг баримтжуулах.
 - iv. Олон талт бүлэг жендэрийн асуудал, хүртээмжтэй байдлыг хэрхэн харгалзан үзсэн тухай баримт бичиг.
 - v. Ажлын төлөвлөгөөний төсөвтэй харьцуулсан бодит зардлын тайлан.
- c) Ажлын төлөвлөлт, хяналт-шинжилгээ, хяналт шалгалтын бүх үйл ажиллагааг үндэсний оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр мэдээлж, олон нийтэд нээлттэй хэлбэрээр баримтжуулсан байх ёстой.
- d) Олон талт оролцогчдын бүлэг нь үйл ажиллагааны ахиц дэвшлийг хэрхэн тогтмол хэмжих өөрөөр хэлбэл өмнөх жилийн үйл ажиллагаа нь олборлох салбарын засаглалыг сайжруулахад хувь нэмрээ хэрхэн оруулсан эсэхэд үнэлгээ өгөх талаар авч үзэх хэрэгтэй.
- e) Олон талт оролцогчдын бүлгийг тухайн жилийн тайланд улсын хэмжээнд хамааралтай олон

нийтэд мэдэгдэж байгаа авлигын хэргүүдийг хянан хэлэлцсэн эсэхээ танилцуулж, хэлэлцүүлэг, хариу арга хэмжээ, зөвлөмжийг баримтжуулахыг олон талт оролцогчид дэмжинэ.

ШААРДЛАГА 2

Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын хамрах хүрээ, гэрээ, тусгай зөвшөөрөл

ОУИТБС нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн эрх олгох, олборлох салбарт хамаарах хууль ёсны, зохицуулалтын ба гэрээт хамрах хүрээ болон тухайн салбарыг удирдахад хүлээх ЗЗасгийн газрын байгууллагын үүрэг хариуцлагатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журамтай танилцах боломжийг оролцогчдод олгон, олборлох салбар хэрхэн ажилладаг тухай журамтай холбоотой мэдээллийг ил тод болгохыг шаарддаг.

2.1 Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох үйлдвэрлэлийн зохицуулалтын хүрээ, түүний дотор хууль эрх зүйн орчны талаарх бүх талын ойлголтыг болох төсвийн дэглэм; төрийн байгууллагуудын үүрэг, шинэчлэл; түүнчлэн олборлох салбар дахь авлигын эрсдэлийг шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийг олон нийтэд хүргэх юм.

- a) Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь олборлох салбарыг зохицуулж байгаа эрх зүйн хүрээ болон төсвийн бодлогын талаарх мэдээллийг ил тод болгох ёстой. Энэхүү мэдээлэл нь төсвийн бодлогын талаарх тойм тайлбар, үүнд төсвийн эрх шилжүүлэлтийн түвшин, хамаарах хууль, журмуудын тойм, тэр дундаа олборлох салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хуулиуд, газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалыг хайгуул, олборлолтыг зохицуулж буй гэрээ, тусгай зөвшөөрлийн төрлүүд болон хамаарах төрийн байгууллагуудын үүрэг роль, чиг үүрэг зэргийг багтаасан байна.
- b) Хэрэгжүүлэгч орнууд олборлох үйлдвэрлэлд хамааралтай эрчим хүчний шилжилтийн үндэсний амлалт, бодлого, төлөвлөгөөний тоймыг ил тод болгох шаардлагатай.
- c) Хэрэгжүүлэгч орнууд нүүрстөрөгчийн үнийг тогтоох механизм эсвэл олборлох үйлдвэрүүдээс гарч буй нүүрстөрөгчийн татварын тухай тайлбарыг ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.
- d) Хэрэгжүүлэгч орнуудыг олборлох үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой төрийн татаас болон бусад хэлбэрийн дэмжлэг, түүнчлэн хийгдэж буй аливаа шинэчлэлийг ил тод болгохыг дэмжиж байна. Үүнд Дэлхийн татаасын санаачилга байгууллагын удирдамжийн дагуу үйлдвэрлэгчдэд үзүүлэх татаас, татварын өмнөх болон татварын дараах хэрэглэгчийн татаас багтаж болно. Төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ)-ын төсвийн шинжтэй зардал гэж тодорхойлсон татаасыг 6.2-р шаардлагын дагуу ил тод мэдээлнэ.
- e) Засгийн газар эрчим хүчний шилжилтийн үндэсний амлалт, бодлого, төлөвлөгөө зэрэг шинэчлэлийг хийж байгаа тохиолдолд олон талт оролцогчдын бүлэг тэдгээрийг баримтжуулахыг дэмжинэ.
- f) Боломжтой бол хэрэгжүүлэгч орнууд бичил уурхайн салбартай холбоотой бодлого, түүнчлэн төлөвлөж буй болон хийгдэж буй шинэчлэлийн талаарх мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ.

2.2 Гэрээ хийх болон тусгай зөвшөөрөл олголт.

Энэхүү шаардлагын зорилго нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн тусгай зөвшөөрлийг олгох, шилжүүлсэн тойм, тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх тухай хуулиар тогтоосон журмууд болон тэдгээр нь практикт хэрхэн мөрдөгдөж байгаа талаар олон нийтэд танилцуулах юм. Энэ нь сонирхогч талуудад тусгай зөвшөөрөл олгох үйл явцад гарч болзошгүй сул талууд, тэр дундаа эдгээр үйл явцыг авлигад өртөмтгий болгодог сул талуудыг тодорхойлж, шийдвэрлэх боломжийг олгоно.

- a) Хэрэгжүүлэгч улс орнууд нь ОУИТБС-ын тайлангийн хамрах хугацаанд ОУИТБС-ын тайланд хамрагдсан компаниудын шинээр авсан болон эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, гэрээ байгуулсан зэрэгтэй хамаарах дараах мэдээллийг ил тод болгох үүрэгтэй ба үүнд мөн нийт төлсөн төлбөрийн хэмжээ нь тогтоосон материаллаг босго дүнгээс доогуур байгаа компаниуд ч мөн ил тод болгоно:
 - i. Тусгай зөвшөөрөл шилжүүлэх эсхүл олгох явцын тухай танилцуулга;
 - ii. Ашигласан техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт буюу үнэ төлбөргүй, урьдчилсан болон мэдээлэлтэй зөвшилцөлтэй холбоотой аливаа шаардлагыг багтаасан болно. Тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх үйл явц нь нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх шаардлагатай бол хэрэгжүүлэгч улс орнууд болон компаниуд зөвлөлдөх үйл явц хэрхэн явагдсан тухай тайлбарыг ил тод болгох ёстой. Үүнд зөвлөлдсөн хүмүүсийн тоо, хүйсээр нь ангилсан, төслийн нөлөөллийн талаарх үзэл бодлыг хэрхэн цуглуулж, авч үзсэн талаарх хураангуй мэдээллийг багтааж болно.
 - iii. Хамааралтай бол консорциумын гишүүдийг оруулаад тусгай зөвшөөрөл шинээр эсвэл шилжүүлэн хүлээн авсан этгээдийн тухай мэдээлэл;

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлагууд

- iv. Тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой хууль зүй, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, материаллаг байдлаар мөрдөөгүй тохиолдлууд.

Засгийн газрын зүгээс тусгай зөвшөөрөл олгох эсвэл гэрээ хийхдээ өөр аргачлалыг сонгон хэрэглэж буй бол (жишээ нь сонгон шалгаруулалтаар эсвэл шууд хэлэлцээр хийх замаар) тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэхтэй холбоотой танилцуулгад ямар процедурыг үүнд ашигладаг, яагаад тодорхой нэг процедурыг сонгон ашигладаг тухай заасан байна. Үүнд Засгийн газрууд түргэвчилсэн байдлаар "хурдан мөрддөг" тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх үйл явцыг ашигладаг тохиолдлууд орно. Олон талын оролцогчдын бүлэг энэ сонголтын үндэслэл, өргөдөл гаргах процесс, тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц зэргийг тодорхой баримтжуулах ёстой. Олон нийтэд нээлттэй мэдээлэлд ямар нэг зөрүү байгаа тохиолдолд тэдгээрийг тодорхой зааж өгөх ёстой. Дээр заасан мэдээллийг иж бүрнээр ил тод болгоход тулгарах эрх зүйн болон практик саад тотгорыг баримтжуулан, тайлбарлах ба үүнд Засгийн газрын зүгээс тухайн саад тотгорыг арилгах төлөвлөгөө, үүнийг биелүүлэх цаг хугацааг заасан байна.

- b) ОУИТБС-ын хэрэгжилтэд хамаарах хугацаанаас өмнө тусгай зөвшөөрөл авсан компаниуд ОУИТБС-ын тайланд орсон бол санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд боломжтой бол эдгээр тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой 2.2(a) дээр заасан мэдээллийг ил тод болгох нь зүйтэй байна.
- c) Тусгай зөвшөөрлийг тендер шалгаруулалтаар олгосон бол Засгийн газар нь тендерт оролцогчдын жагсаалт, эцсийн өмчлөгчдийн мэдээлэл болон тендерийн шалгууруудыг ил тод болгосон байх ёстой;
- d) Олон талт оролцогчдын бүлэг нь тусгай зөвшөөрөл олголтын хуваарлалтын тухай нэмэлт мэдээллийг ОУИТБС-ын хүрээнд ил тод болгоно. Үүнд тусгай зөвшөөрөл олгох үйл явцын үр дүнтэй, үр ашигтай байдал, бодит хэрэгжиж буй практик үйл ажиллагаа/процедур, гэрээ, тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам, бодит үйл ажиллагаа, үндэслэлийн тодорхойлолт, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын дийлэнх эзэмшлийн өөрчлөлттэй холбоотой мэдээллийн талаархи тайлбар зэрэг багтаж болно.

2.3 Тусгай зөвшөөрлийн бүртгэл.

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох орд, төсөлтэй холбоотой өмчийн эрхийн талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байлгахад оршино.

Нэр томьёоны тайлбар

- a) “Тусгай зөвшөөрөл” буюу тусгай зөвшөөрөл гэдгийг Засгийн газраас ашигт малтмал, газрын тос болон/эсвэл байгалийн хий хайх болон олборлох зорилгоор аж ахуйн нэгж, хувь хүмүүст олгосон бүх төрлийн тусгай зөвшөөрөл, түрээсийн эрх, зөвшөөрөл, гэрээ, концессыг багтаан ойлгоно;
- b) Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь олон нийтэд нээлттэй кадастр, тусгай зөвшөөрлийн бүртгэлийн мэдээллийн сантай байх шаардлагатай. Энэхүү мэдээллийн санд ОУИТБС-ын зөвшилцсон цар хүрээнд хамаарах бүх компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл нэг бүрийн тухай мэдээллийг оруулсан байх бөгөөд мэдээллийг тогтмол байнга шинэчилж, иж бүрнээр оруулсан байх шаардлагатай:
- тусгай зөвшөөрөл эзэмшигч(ид);
 - тусгай зөвшөөрлийн талбайн солбицол. Солбицлуудыг нийтлүүлээгүй тохиолдолд Засгийн газраас тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ болон байрлалыг тусгай зөвшөөрлийн бүртгэлд ил тод болгох ба олон нийт солбицлуудын талаарх мэдээллийг үндэслэлгүй төлбөр болон хязгаарлалтгүйгээр төрийн холбогдох байгууллагаас авах боломжийг хангахыг шаарддаг. Ил тод мэдээлэл нь тусгай зөвшөөрлийн солбилцол уруу хэрхэн нэвтрэх, өгөгдөл мэдээлэлрүү нэвтрэхэд ямар нэгэн зардал байгаа бол мэдээлэлд хэрхэн нэвтрэх талаарх удирдамжийг оруулж өгөх ёстой. Түүнчлэн, Засгийн газар тусгай зөвшөөрлийн бүртгэлээр дамжуулан энэхүү мэдээллийг үнэ төлбөргүй, цахимаар авах төлөвлөгөө болон хугацааг баримтжуулах ёстой;
 - тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан болон тусгай зөвшөөрөл олгосон огноо, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа;
 - олборлолт/ашиглалтын тусгай зөвшөөрлийг хувьд олборлож буй бүтээгдэхүүний тухай мэдээлэл тус тус орсон байна.

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлагууд

Тусгай зөвшөөрлийн бүртгэл, кадастрын систем нь тусгай зөвшөөрөл эзэмшиж буй бүх аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн талаарх мэдээллийг багтаасан байх бөгөөд үүнд ОУИТБС-ын тайланд хамрагдаагүй аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийг ч (тэдний төлж буй төлбөр нь босго хэмжээнд хүрээгүйн улмаас тайланд ороогүй) багтаан оруулна. Хэрэв ямар нэг эрх зүйн болон бусад шалтгааны улмаас хүчин төгөлдөр байгаа бүх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг ил тод болгох боломжгүй бол энэ талаарх тайлбарыг оруулна. Түүнчлэн, Засгийн газрын зүгээс энэхүү саад бэрхшээлийг арилгах талаар төлөвлөж буй ажлууд болон тухайн ажлыг хийж дуусах эцсийн хугацааг тодорхой дурдсан байх шаардлагатай.

- с) Хэрэв ийм тусгай зөвшөөрлийн бүртгэл, кадастрын тухай мэдээлэл байхгүй эсвэл хагас дутуу байгаа бол олон талт оролцогчдын бүлэг дутуу байгаа мэдээлэл баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгон, эдгээр системийг бэхжүүлэх хүчин чармайлтыг гаргана.
- д) Хэрэгжүүлэгч улс орнууд олон нийтэд нээлттэй тусгай зөвшөөрлийн бүртгэлийг газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудын хууль ёсны болон ашиг хүртэгч эзэмшигчдийн талаарх 2.5-р шаардлагын дагуу мэдээллийг ил тод болгосон болон хадгалдаг төрийн бусад платформтой холбохыг зөвлөж байна.

2.4 Гэрээ ба тусгай зөвшөөрөл

Энэхүү шаардлагын зорилго нь тус улсын олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын гэрээний эрх, үүргийн талаар олон нийтэд ойлголт өгөх үндэс болгон олборлох үйл ажиллагааг үндэслэсэн бүх тусгай зөвшөөрөл, гэрээг (ядахад 2021 оноос хойш) олон нийтэд хүртээмжтэй байлгахад оршино. Энэхүү шаардлага нь гэрээг ил тод болгоход оролцогч талуудын гэрээний үүргийн биелэлтийг хянах чадамжид хувь нэмэр оруулахад чиглэгддэг.

- а) Хэрэгжүүлэгч улс орнууд нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн олгогдсон тусгай зөвшөөрөл, хийсэн гэрээ эсвэл нэмэлт өөрчлөлт орсон гэрээ, тусгай зөвшөөрөлийг ил тод болгох үүргийг хүлээнэ. Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлох нөхцөл бүхий хийсэн бүх гэрээ, гэрээний нөхцөлийн талаарх мэдээллийг ил тод болгоход хүчин чармайлт гарган ажиллана;
- б) Олон талын оролцоот бүлэг нь гэрээг ил тод болгохоор харилцан зөвшилцож, баталсан төлөвлөгөөг тодорхой хугацаа болон иж бүрэн хэмжээнд ил тод болгоход тулгарах саад тотгорыг арилгах үйл ажиллагааг тодорхой заан бэлтгэн гаргах үүргийг хүлээнэ. Энэхүү төлөвлөгөө нь 2020 оноос эхлэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан, нэг хэсэг нь болсон байна.
- с) Олон талын оролцоот бүлэг нь Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын хайгуул болон олборлолтын асуудлыг зохицуулсан гэрээ болон тусгай зөвшөөрлийг ил тод болгох чиглэлээр төр засгаас баримталж буй бодлогыг баримтжуулах үүргийг хүлээнэ. Үүнд дараах зүйлс багтсан байна:
 - i. Хууль эсвэл төрийн бодлого нь гэрээ болон тусгай зөвшөөрлийг ил тод болгох асуудлыг хөндсөн эсэх, үүнд хууль тогтоомж болон бодлого нь гэрээ, тусгай зөвшөөрлийг ил тод болгон мэдээлэхийг шаардсан эсвэл хориглосон эсэхийг тодорхой заасан байна. Хэрэв үүнд хамаарах ямар нэгэн хууль тогтоомж байхгүй бол энэ талаар бодлогын баримт бичигт хэрхэн заасан, хэрхэн төлөвлөж буй болохыг тайлбарлах, мөн Олон талын оролцоот бүлэг нь гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлого нь юунаас бүрдэх талаар хэлэлцсэнийг баримтжуулсан байна. Гэрээ болон тусгай зөвшөөрлийн ил тод байдлын талаар төлөвлөж буй шинэчлэлийн талаар мөн баримтжуулан оруулсан байна.
 - ii. Ямар гэрээ, тусгай зөвшөөрөл олон нийтэд нээлттэй буй талаарх тойм мэдээлэл. Санаачилгыг хэрэгжүүлэгч улсууд нь хүчин төгөлдөр бүх гэрээ, тусгай зөвшөөрлийн жагсаалтыг нийтэлж, үүнд эдгээрийн аль ч олон нийтэд ил тод, аль нь хаалттай буй талаар мэдээлнэ. Нээлттэй хэвлэн нийтэлсэн гэрээ, тусгай зөвшөөрлийн хувьд тухайн гэрээ, тусгай зөвшөөрөл нь хаана байршсан буй холбоос/лавлах эх сурвалжийг заавал заасан байна. Хэрэв гэрээ эсвэл тусгай зөвшөөрлийг ил тод болгоогүй бол үүнд тулгарч буй эрх зүйн болон практик үйл ажиллагааны саад тотгоруудыг баримтжуулан, тайлбарласан байна.
 - iii. Ил тод болгох үйл ажиллагаа нь гэрээ, тусгай зөвшөөрлийн ил тод байдалд хамаарах хууль эсвэл төрийн бодлогод тусгагдсан шаардлагуудыг зөрчсөн, өөр байдлаар хийгдсэн бол олон талын оролцоот бүлэг энэ талаарх тайлбарыг гаргах ёстой.

- д) Шаардлага 2.4(а)-т дурдсан **Гэрээ** хэмээх нэр томъёог дор дурдсан утгаар хэрэглэнэ:
 - i. Засгийн газрын зүгээс газрын тос, ашигт малтмал болон байгалийн хий олборлохоор тодорхой нөхцөлтэйгөөр олгосон аливаа гэрээ хэлцэл, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ, бусад гэрээний бүрэн эх хувилбар; Олон талын оролцогчдын бүлэг материаллаг байдал, бодит байдалд тулгуурлан хайгуулын ямар гэрээг ил болгохоо тодорхойлох ёстой.
 - ii. Шаардлага 2.4(d)(i)-т дурдсан бүх төрлийн гэрээний ашиглах эрх, гүйцэтгэлтэй холбоотой ямар нэгэн хавсралт, нэмэлт өөрчлөлт, нөхцөлүүдийн бүрэн эх хувилбар;
 - iii. Шаардлага 2.4(d)(i) болон 2.4(d)(ii)-т дурдсан баримт бичгүүдэд оруулсан ямар нэгэн өөрчлөлт, нэмэлтийн бүрэн эх хувилбар.
- е) Шаардлага 2.4(а)-т дурдсан “тусгай зөвшөөрөл” хэмээх нэр томъёог дор дурдсан утгаар хэрэглэнэ:
 - i. Засгийн газрын зүгээс газрын тос, ашигт малтмал болон байгалийн хий олборлохоор тодорхой нөхцөлтэйгөөр олгосон аливаа гэрээ хэлцэл, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ, бусад гэрээний бүрэн эх хувилбар; Олон талын оролцогчдын бүлэг материаллаг байдал, бодит байдалд тулгуурлан хайгуулын ямар тусгай зөвшөөрлөө ил болгохоо тодорхойлох ёстой.

- ii. Шаардлага 2.4(е)(i)-т дурдсан бүх төрлийн гэрээний ашиглах эрх, гүйцэтгэлтэй холбоотой ямар нэгэн хавсралт, нэмэлт өөрчлөлт, нөхцөлүүдийн бүрэн эх хувилбар;
- iii. Шаардлага 2.4(е)(i) болон 2.4(е)(ii)-т дурдсан баримт бичгүүдэд оруулсан ямар нэгэн өөрчлөлт, нэмэлтийн бүрэн эх хувилбар

2.5 Эцсийн өмчлөгч

Энэхүү шаардлагын зорилго нь тухайн улсын олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд, ялангуяа олон талын оролцогчдын бүлэг өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон компаниудыг эцсийн дүндээ хэн эзэмшиж, хянадаг болохыг олон нийтэд мэдээлэх, менежментийн захисгүй, авлигын үйлдлээс урьдчилан сэргийлэхэд оршино. Олборлох баялгийн талаар болон улс төрд нөлөө бүхий хүмүүсийн өмчлөлийг хянахад туслана.

- a) Хэрэгжүүлэгч улс орнууд газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эсвэл гэрээг эзэмших хүсэлт гаргасан аж ахуйн нэгж түүний эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй болгохыг дэмжинэ. Үүнд эцсийн өмчлөгч нь хэн бэ, өмчлөлийн түвшин, өмчлөх эрх, хяналт хэрхэн хэрэгждэг талаарх дэлгэрэнгүй мэдээлэл орно. Боломжтой бол хэрэгжүүлэгч улс орнууд эцсийн өмчлөгчийн мэдээллийг хөрөнгийн биржүүд эсвэл олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрлийг зохицуулдаг агентлагт өгсөн мэдүүлэгтээ мэдээллийг тусгах нь зүйтэй. Хэрэв ийм төрлийн мэдээлэл нь олон нийтэд хэдийн нээлттэй болсон байвал ОУИТБС-ын тайланд энэхүү мэдээллийг хэрхэн олж авах тухай зааврыг оруулсан байх шаардлагатай;
- b) Олон талт оролцогчдын бүлэг Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг ил тод болгох талаарх төрийн бодлого, хэлэлцүүлгийг баримтжуулсан байх үүргийг хүлээнэ. Үүнд холбогдох хуулийн заалтууд, ил тод болгох бодит үйл ажиллагаа, Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг ил тод болгохтой холбоотой төлөвлөсөн эсхүл хэрэгжүүлж буй шинэчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл орно.
- c) Компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгохыг хэрэгжүүлэгч улс орнуудаас шаардана. Энэ нь газрын тос, байгалийн хий, ашиглалтын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл, гэрээнд эзэмших хүсэлт гаргасан буюу оролцогчийн хувь эзэмшиж буй аж ахуйн нэгж(үүд)-д хамаарах бөгөөд тэдгээрийн ашиг хүртэгч эцсийн өмчлөгч(үүд)-ийн хувийн мэдээллийг агуулсан байх ёстой; Үүнд өмчлөлийн түвшин; өмчлөх эрх, хяналт хэрхэн хэрэгждэг талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байх ёстой. Олон талын оролцоот бүлэг Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг огт ирүүлээгүй эсхүл дутуу ирүүлсэн аж ахуйн нэгжийг нэрлэх зэргээр Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн тайлагнал дахь аливаа дутагдал эсхүл сул талыг ил тод болгон мэдээлэх ёстой.
- d) Эцсийн өмчлөгчийн тухай мэдээлэлд тухайн Эцсийн өмчлөгчийн нэр, үндэс угсаа, оршин суугаа улс орны нэр, мөн түүнчлэн улс төрд нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээллийг оруулах ёстой. Түүнчлэн, үндэсний биений байцаалтын дугаар/регистрийн дугаар, төрсөн огноо, оршин суух газрын эсхүл ажлын хаяг, гэрээний төрлийг ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ;
- e) Олон талт оролцогчдын бүлэг нь Эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах боломжит механизмуудад үнэлгээ хийж, компаниудын зүгээс гарган ирүүлсэн Эцсийн өмчлөгчийн тухай мэдээлэл үнэн зөв болохоо баталгаажуулахад компаниудын хэрэгжүүлэх арга зам/хандлагын талаар хэлэлцэн, 2.5(с) хэсэгт заасны хэмжээнд үнэн зөв байдлыг зөвшөөрсөн байх ёстой. Үүнд ахлах удирдлагын багийн гишүүн эсхүл ахлах хуулийн зөвлөхөөр гарын үсэг зуруулах эсхүл холбогдох баримт бичгийг хүргүүлэх байдлаар компаниудаас Эцсийн өмчлөгчийн мэдүүлгийн маягтыг баталгаажуулах гэх мэт багтаж болно;
- f) Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт:
 - i. Компанийн хувьд “Эцсийн өмчлөгч” гэдэг нь тухайн аж ахуйн нэгжийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг хувь хүнийг хэлнэ;
 - ii. Олон талт оролцогчдын бүлэг нь “Эцсийн өмчлөгч”-ийн асуудлыг авч үзэхдээ тухайн этгээдийн тухай тодорхойлолт дээр зөвшилцөлд хүрсэн байна. Энэхүү тодорхойлолтыг дээр дурдсан Шаардлага 2.5 (f) болон (i) дээр заасан шалгуур болон олон улсын хэм хэмжээ, өөрийн орны холбогдох хууль тогтоомжийг харгалзан боловсруулсан байх бөгөөд эзэмшлийн босго хэмжээг оруулах ёстой. Тодорхойлолт нь тухайн улсын нөхцөл байдал, тухайн улс шийдвэрлэхээр зорьж буй эрсдэлийн төрөл, түвшингээс хамаарч мэдээлэл өгөх ёстой өмчлөлийн босго(ууд)-ыг багтаасан байх ёстой. Хэрэгжүүлэгч орнуудыг эцсийн өмчлөгчийг тайлагнах босго хувийг 10% ба түүнээс доош өмчлөлийн босго тогтоохыг зөвлөж байна. Тодорхойлолтонд улс төрд нөлөө бүхий хүмүүсийн тайлагнах үүргийг мөн зааж өгөх ёстой. Хэрэгжүүлэгч орнууд нь өмчийн түвшингээс үл хамааран эцсийн өмчлөлийн талаар мэдээллийг бүрэн ил тод болгох шаардлагатай.
 - iii. Олон нийтэд нээлттэй хөрөнгийн зах зээл дээр гарсан компани, тэдний бүрэн эзэмшлийн салбар компанийн тухайн хөрөнгийн биржийн нэрийг мэдээлж, эцсийн

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлагууд

өмчлөгчийн тухай мэдээллийг нь олон нийтэд зориулж нийтэлсэн хөрөнгийн биржийн мэдээллийн холбоосыг ил тод болгон мэдээнэ. Хөрөнгийн биржийн мэдүүлэгт ил болсон өмчлөлийн мэдээллийн иж бүрэн, найдвартай байдлыг шалгах ажлыг олон талт бүлэг хийхийг хөхүүлэн дэмжинэ.

- iv. Хамтарсан аж ахуйн нэгжийн хувьд тухайн хамтарсан нэгж дэх аж ахуйн нэгж бүр нь өөрийн Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг ил тод болгоно. Харин тухайн аж ахуйн нэгж нь олон нийтэд нээлттэй, хөрөнгийн зах зээл дээр гарсан компанийн бүрэн эзэмшилд байдаг салбар нэгж бол энэхүү шаардлагад хамаарахгүй. Аж ахуйн нэгж бүр нь өөрийн гарган өгсөн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.
- v. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьд түүнийг эзэмшиж байгаа эсвэл хянаж байгаа Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн нэр, эзэмшлийн түвшин, эзэмшил, хяналт хэрхэн хэрэгжиж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгох шаардлагатай. Хэрэв төрийн өмчийн аж ахуйн нэгжийг төрийн мэдэлд бүрэн эзэмшдэггүй бол Шаардлага 2.5(с) дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох ёстой.
- g) Хэрэгжүүлэгч орнууд Шаардлага 2.5(с) дагуу тэдгээр компаниудын хууль ёсны эзэмшигч, аж ахуйн нэгж болон тэдгээрийн эзэмшлийн хувь хэмжээг ил тод болгох шаардлагатай. Компаниуд өөрсдийн өмчлөлийн бүтцээ, түүний дотор ашиг хүртэгч эзэмшигч рүү чиглэсэн хуулийн этгээдийн бүрэн сүлжээг ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.

2.6 Төрийн оролцоо.

Энэхүү шаардлагын зорилго нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн менежментийг холбогдох зохицуулалтын хүрээнд хийж байгаа эсэх талаар олон нийтэд ойлгуулах замаар төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн (ТӨК) ил тод, хариуцлагатай байх, төрийн оролцоог илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх үр дүнтэй механизмыг хангахад оршино. Энэхүү мэдээлэл нь ТӨК-ийн улсын эдийн засагт оруулах хувь нэмрийг санхүү, эдийн засаг, нийгмийн хувьд тасралтгүй сайжруулах үндэс суурь болж, ТӨК-ийн хөрөнгө оруулалтын шийдвэр нь урт хугацааны нийтийн ашиг сонирхолд хэр нийцэж байгаа талаарх ойлголтыг бэхжүүлдэг.

- a) Олборлох салбар дахь төрийн оролцоо нь материаллаг орлогын төлбөрийг нэмэгдүүлдэг санаачилгын хэрэгжүүлэгч улс орнууд нь дараах мэдээллийг ил тод болгох ёстой:
 - i. Салбар дахь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүрэг роль, Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хоорондын санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн журам, практикийн тухай дэлгэрэнгүй тайлбарлана. Жишээ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд болон Засгийн газар хооронд санхүүжилт шилжүүлэх журам, хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт гэх мэт асуудал. Үүнд төрийн өмчит аж ахуйн нэгжийн бусадтай хамтарсан үйлдвэрийн газар, салбарын шилжүүлэг, хуримтлагдсан ашиг, дахин хийсэн хөрөнгө оруулалт болон гуравдагч талын санхүүжилт зэрэг багтан ил тод болсон байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит аж ахуйн нэгж нь Засгийн газрыг төлөөлөн олборлох үйл ажиллагаа эрхэлдэг бүхэлдээ эсхүл ихэнх нь төрийн эзэмшлийн компани хэмээн тодорхойлогдоно. Үүний дагуу олон талт оролцогчдын бүлгүүдийг үндэсний хууль тогтоомж, Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтыг харгалзан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн тодорхойлолтыг хэлэлцэн, баримтжуулахыг хөхүүлэн дэмжинэ.

- ii. Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн түвшнийг ил тод болгоно. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн салбар болон хамтарсан аж ахуйн нэгжид бас хамааралтай бөгөөд тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг ил тод болгох ёстой.

Энэхүү мэдээлэл нь эзэмшлийн хувь хэмжээ, үүнд төслийн хэрэгжилтийн үе шатуудад эрсдэлийн зардал, зардлыг даахаар хүлээсэн үүрэг (жишээ нь бүрэн хэмжээгээр мөнгийг нь төлөн эзэмшсэн өмч, үнэ төлбөргүй авсан эзэмшил, шилжүүлсэн ашиг) зэргийг хамруулна. ОУИТБС-ын тайлант хугацаанд Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн эзэмшилд ямар нэгэн өөрчлөлт гарсан бол тухайн шилжүүлгийн нөхцөл, үүнд үнэлгээ болон орлогын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ил тод зарласан байх ёстой. Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад зээл олгосон, баталгаа гаргасан бол үүний тухай дэлгэрэнгүй мэдээллийг ОУИТБС-ын тайланд тусгасан байх ёстой (эргэн төлөх хуваарь болон хүү гэх мэт). Олон талын оролцоот бүлэг нь тухайн олгосон зээлийн нөхцөлийг арилжааны зээлийн нөхцөлтэй харьцуулан судалж болно.

- b) Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан боломжгүй бол өөрийн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг (баланс, ашиг/алдагдлын тайлан, мөнгөн урсгал гэх мэт) олон нийтэд ил тод болгох арга хэмжээ авна.

Нэр томьёоны тайлбар

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлага

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг цаг тухайд нь ил болгоход саад учруулж буй хууль эрх зүйн болон зохицуулалтын саад бэрхшээлийг тайлагнагч байгууллага тодорхой баримтжуулсан байх ёстой.

- с) Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, капитал зардал, худалдан авалт, туслан гүйцэтгэгч ажиллуулах болон компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон практик үйл ажиллагааг тайлбарлан мэдээлэхийг дэмжин ажиллах ба жишээ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, ёс зүйн дүрэм зэрэг байж болно. ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлт 7-ын дагуу ТӨК-иуд авлигатай тэмцэх бодлогоо нийтэлж, нарийн шалгалтын үйл явцад оролцохыг уриалж байна.
- d) Боломжтой тохиолдолд ТӨК-г олборлох салбарт оруулсан хөрөнгө оруулалтаа (хөрөнгө, өр төлбөрийг оруулаад) ил тод болгохыг дэмжинэ. Мөн ТӨК-ийн хөрөнгө оруулалтын шийдвэрүүд нь эрчим хүчний шилжилт болон уур амьсгалын эрсдэлтэй хэрхэн уялдаж байгааг ил тод болгохыг уриалж байна.
- e) Боломжтой бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг материаллаг гүйлгээ хийх төлөөлөгч, зуучлагч, ханган нийлүүлэгч, гүйцэтгэгчийнхээ хэн болохыг болон ашиг тусыг нь ил болгохыг дэмжинэ.

ШААРДЛАГА 3

Хайгуул ба бүтээгдэхүүн үйлдвэрлэл

ОУИТБС нь оролцогчдод тухайн салбарын боломжийн талаарх ойлголтыг өгөх үүднээс хайгуул болон бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг ил тод болгохыг шаарддаг.

3.1 Хайгуулын үйл ажиллагаа.

Энэхүү шаардлагын зорилго нь тус улсын олборлох салбар, түүний чадавхи, тэр дундаа сүүлийн үед хийгдэж буй болон төлөвлөгдсөн томоохон хайгуулын үйл ажиллагааны талаарх тоймыг олон нийтэд хүргэхэд оршино.

- Хэрэгжүүлэгч орнууд олборлох үйлдвэрлэлийн ерөнхий тойм, түүний дотор хайгуулын томоохон үйл ажиллагаануудыг ил тод болгох шаардлагатай.
- Хэрэгжүүлэгч улс орнууд болон компаниуд боломжтой бол эдийн засгийн батлагдсан газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөцийн талаарх мэдээллийг ил болгохыг зөвлөж байна.

3.2 Үйлдвэрлэлийн мэдээлэл

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох үйлдвэрлэлээс хүлээгдэж буй Засгийн газрын орлого, дутуу тайлагнасангай холбоотой төсвийн орлого алдагдуулах боломжийг үнэлэх үндэс болгон олборлох түүхий эдийн үйлдвэрлэлийн түвшин, олборлох түүхий эдийн бүтээгдэхүүний үнэлгээний талаарх олон нийтийн ойлголтыг хангахад оршино.

- Хэрэгжүүлэгч улс орнууд үйлдвэрлэлийн тухай мэдээллийг цаг тухайд нь ил тод болгох ёстой бөгөөд үүнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээгдэхүүн нэг бүрийн хэмжээ болон үнэ зэрэг байна. Энэхүү мэдээллийг төслөөр нь задална. Боломжтой бол гар аргаар болон бичил уурхай эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тооцоог ил болгох хэрэгтэй.
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ болон үнэ өртгийг хэрхэн тооцсон тухай мэдээлэл, эх сурвалжийг ил болгох ёстой. Хэрэгжүүлэгч улс орнууд үйлдвэрлэлийн мэдээлэл, баримт бичгийн үнэн зөвийг хянах, баталгаажуулах одоо байгаа механизм, түүний дотор нийтэд нээлттэй үйлдвэрлэлийн мэдээллийн иж бүрэн, найдвартай байдалтай холбоотой аливаа сул талыг ил тод болгох шаардлагатай.
- Хэрэгжүүлэгч орнууд үндэсний болон олон улсын түүхий эдийн ангиллын стандартыг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний мэдээллийг танилцуулах ёстой.
- Компаниуд борлуулалтын хэмжээ, үнэ цэнийг төслөөр нь ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.

3.3 Экспортын өгөгдөл мэдээлэл

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох үйлдвэрлэлээс хүлээгдэж буй Засгийн газрын орлого, дутуу тайлагнасангай холбоотой төсвийн орлого алдагдах боломжийг үнэлэх үндэс болгон олборлох түүхий эдийн экспортын түвшин болон олборлох түүхий эдийн экспортын үнэлгээний талаарх олон нийтийн ойлголтыг хангахад оршино.

- Хэрэгжүүлэгч орнууд экспортын хэмжээ, түүхий эд, экспортлогч компанийн үнэ цэнийг багтаасан экспортын мэдээллийг цаг тухайд нь ил тод болгох шаардлагатай. Хэрэгжүүлэгч орнууд экспортын мэдээллийг гүйлгээ тус бүрээр задалж харуулах нь хүлээгдэж байна. Гар аргаар болон бичил уурхай эрхэлэгчдийн экспортолсон бүтээгдэхүүний тооцоог боломжтой тохиолдолд ил болгох ёстой.
- Экспортын хэмжээ, үнийн дүнгийн эх үүсвэр, тооцох аргачлалыг ил тод болгох ёстой. Хэрэгжүүлэгч орнууд экспортын мэдээлэл, баримт бичгийн үр дүнгийн үнэн зөвийг хянах, баталгаажуулах одоо байгаа механизмуудыг ил тод болгох ёстой. Үүнд экспортын мэдээллийн иж бүрэн, найдвартай байдалтай холбоотой аливаа сул талыг байвал ил болгоно. Үүнд экспортын үнэ болон зах зээлийн үнэ ба/эсвэл зорьсон орны мэдээлсэн импортын үнэ цэнийн хоорондох болзошгүй хазайлтад дүн шинжилгээ хийх шаардлагатай.
- Хэрэгжүүлэгч орнууд экспортын мэдээллийг үндэсний болон олон улсын түүхий эдийн ангиллын стандартыг ашиглан танилцуулах нь хүлээлт юм.
- Экспортлогч компаниуд болон түүхий эд худалдан авагчид, тэр дундаа түүхий эдийн худалдаа эрхлэгчид борлуулалтын хэмжээ, үнэ цэнийг төсөл тус бүрээр ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.
- Хэрэгжүүлэгч орнууд экспортын мэдээллийг бүс нутаг, очих газар, худалдан авагчаар нь танилцуулахыг дэмжинэ. Экспортлогч компаниуд болон хэрэгжүүлэгч орнууд худалдан авагчаа ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.

3.4 Хүлэмжийн хийн ялгаруулалт

Компаниуд хүлэмжийн хийн ялгаруулалтыг одоо мөрдөж буй ил тод байдлын тэргүүлэх стандарттай уялдуулан ил болгохыг хөхүүлэн дэмжинэ. Боломжтой бол олон талын оролцоот бүлэг нээлттэй мэдээллийг улам дэлгэрэнгүй болгохыг шаардаж болно.

- а) Газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын үйлдвэрлэсэн нөөцөөс төрд хамаарах хэсгийг борлуулсан эсвэл мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан бусад орлого нь материаллаг бол Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгж нь төрийн хүлээн авсан хэмжээ, төрийн (эсвэл төрийг төлөөлөн гуравдагч талын хийсэн) борлуулсан хэмжээ, борлуулалтын орлого, борлуулсан газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын орлогоос төрд шилжүүлсэн хэмжээ зэргийг ил тод болгон мэдээлэх үүргийг хүлээнэ. Боломжтой тохиолдолд үүнд мөн своп гэрээ болон нөөцөөр баталгаажсан зээлтийг холбоотой төлбөрийг (мөнгөн ба мөнгөн бус) багтаасан байх ёстой. (Шаардлага 4.3-н тодорхойлолтыг үзнэ үү)

Ийнхүү ил тод болгосон мэдээлэл нь бусад төрлийн төлбөр, орлогын талаар тайлагнаж буйтай ижил хэмжээний задаргаатайгаар, худалдан авсан компани нэг бүрээр задаргаатай нийтлэгдсэн байх ёстой (Шаардлага 4.7). Худалдан авагч компанитай зөвлөлдөн Олон талын оролцоот бүлэг нь тухайн ил тод болгож мэдээллийг борлуулалт, бүтээгдэхүүний төрөл, үнээр нь дэлгэрэнгүй задаргаатайгаар ил тод болгох эсэхийг судлан үзнэ.

Үүнд мөн борлуулсан бүтээгдэхүүний өмчлөл болон борлуулах гэрээний нөхцөл (spot эсвэл хугацаат нөхцөлөөр) зэргийг багтаасан байхыг хөхүүлэн дэмжинэ.

- b) Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд, тухайн орнуудын төрийн өмчит аж ахуйн нэгж нь өөрийн бүтээгдэхүүнийг худалдан авагч компанийг сонгох үйл явцын тухай тайлбар, сонгон шалгаруулалтад ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд, сонгон авсан худалдан авагч компаниудын жагсаалт, тэдгээрийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл (боломжтой бол), зуучлагч эсвэл агентийн хувийн мэдээлэл (боломжтой бол); худалдан авагч компанийг сонгохтой холбоотой эрх зүй, зохицуулалтын хүрээлээс материаллаг байдлаар гажсан ямар нэгэн нөхцөл, хамаарах борлуулалтын гэрээ зэргийг ил тод болгох нь зөв.
- c) Хэрэгжүүлэгч орнуудыг худалдан авагч компаниудтай хийсэн борлуулалтын гэрээг ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.
- d) Засгийн газраас, тэр дундаа төрийн өмчит компаниудаас (эсвэл борлуулалт хийх эрхийг төрөөс авсан гуравдагч этгээдээс) газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал худалдан авч буй компаниуд нь төр эсвэл төрийн өмчит компаниудаас худалдан авсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмал худалдан авсны төлбөрийн хэмжээг ил тод болгоход хүчин чармайлт гаргана. Үүнд swap хэлцэл болон нөөцөөр баталгаажсан зээлийн төлбөр (мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр) багтана.

Компаниудыг бие даасан борлуулагч, гэрээ эсвэл борлуулалтаар нь ангилсан өгөгдөл мэдээллийг нийтлэхийг дэмжинэ. Худалдан авалт нэг бүрийн ил тод болгож буй мэдээлэл нь хамаарах гэрээ болон ачилт хийсэн боомтын талаар (жишээ нь spot эсвэл хугацаат нөхцөл) мэдээлсэн байна.

- e) Мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлын талаар ямар нэгэн асуудал буй, практик дээр хэрэгжих боломжтой бол Олон талын оролцоот бүлэг нь ил тод болгосон мэдээлэлд буй ямар нэгэн орхигдол, үл нийцэл, хэвийн бус байдлыг цаашид судлан үзэхэд хүчин чармайлтыг гаргах ёстой.

4.3 Дэд бүтцэд хөрөнгө оруулах болон бартерын солилцоо.

Энэхүү шаардлагын зорилго нь дэд бүтцийн байгууламжууд болон бартер хэлбэрийн зохицуулалтууд, тэр дундаа олборлох үйлдвэрлэлийн төрийн өмчийн эзэмшлийн хувиар баталгаажсан зээлийн талаар олон нийтэд ойлголт өгөх юм. Энэ нь бусад бэлэн мөнгөн дээр суурилсан компанийн төлбөр нь газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас олсон Засгийн газрын орлоготой дүйцэхүйц байх бөгөөд ердийн гэрээ хэлцлүүдтэй харьцуулах үндэслэл болно.

- a) Олон талт оролцогчдын бүлэг нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл, концесс олгон үүний төлбөр болгон бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцоогоор ханган нийлүүлэх, (зээл, тусламж, дэд бүтэц барих гэх мэт) үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ хэлэлцээр/ эсвэл биечлэн нийлүүлэх багц гэрээ хэлэлцээр байгаа эсэхийг авч үзнэ. Үүнд ОУВС-гийн барьцаат улсын өрийн тодорхойлолтод нийцсэн байгалийн баялгаас олох ирээдүйн орлогын урсгалаар баталгаажсан бараа, үйлчилгээ үзүүлэх зэрэг багтана. Үүний тулд Олон талт оролцогчдын бүлэг нь холбогдох гэрээ хэлцлийн нөхцөл, оролцогч талууд, Засгийн газраас дэнчинд тавьсан нөөц баялаг, тухайн орлогын урсгалын баланст эзлэх үнэ цэнэ, (Дэд бүтцийн ажил гэх мэт), ба эдгээр гэрээ нь уламжлалт гэрээтэй харьцуулахад хэр материаллаг нөхцөлтэй болох талаар бүрэн ойлголтыг олж авах хэрэгтэй.
- b) Олон талт оролцогчдын бүлэг нь тухайн гэрээ хэлцлийг материаллаг хэмээн дүгнэлт гаргавал Олон талт оролцогчдын бүлэг нь ийм төрлийн гэрээг олон нийтэд тайлбарлах бөгөөд бусад төрлийн төлбөр, орлогын урсгалын нэгэн адил түвшний нарийвчилсан мэдээлэл байна. Хэрэгжүүлэгч орнууд үндсэн бартер буюу дэд бүтцийн гэрээ, түүний дотор нөөц баялгаар баталгаажсан зээлийн гэрээг нийтлэхийг дэмжинэ.
- c) Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээллийн чанар, дээр заасан мэдээллийн баталгаажуулалттай холбоотой журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу гарган, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.

4.4 Тээвэрлэлтийн орлого.

Энэхүү шаардлагын зорилго нь төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжсийн (ТӨҮГ) газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын тээвэрлэлтээс олсон орлогын ил тод байдлыг хангахад төрийн болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор олборлох түүхий эдийг тээвэрлэх зохицуулалтын хариуцлагыг нэмэгдүүлэхэд оршино.

- a) Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал тээвэрлэсний улмаас олсон орлого нь материаллаг бол

Засгийн газар болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нь өөрийн хүлээн авсан орлогыг ил тод болгох шаардлагатай. Хэвлэн нийтэлсэн мэдээлэл нь өөр бусад орлогын урсгал, төлбөрийн урсгалын нэгэн адил хэмжээнд задаргаатай байх шаардлагатай (Шаардлага 4.7).

- b) Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь дараах мэдээллийг ил болгохыг хөхүүлэн дэмжинэ. Үүнд:
- Тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл, үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани болон төрийн байгууллага (төрийн өмчит аж ахуйн нэгж мөн хамаарна);
 - Тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар;
 - Тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг ил тод болгон тайлагнах;
 - Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлогыг ил тод болгон тайлагнах.

4.5 Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гүйлгээ.

Энэхүү шаардлагын зорилго нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн (ТӨК) төлбөр, шилжүүлгийг хянах, түүнчлэн улсад төвлөрүүлэх орлогыг үр дүнтэй шилжүүлж байгаа эсэх, ТӨК-д төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх түвшиний талаарх олон нийтийн ойлголтыг бэхжүүлэхэд оршино.

- a) Олон талт оролцогчдын бүлгээс тайлангийн үйл явцад төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨК)-ийн үүрэг хариуцлагыг цогцоор нь тусгах, үүнд компаниас ТӨК-д төлсөн материаллаг төлбөр, ТӨК-аас төрийн байгууллагууд уруу хийсэн шилжүүлэг, Засгийн газраас төрийн өмчит аж ахуйн нэгжид шилжүүлсэн шилжүүлэг зэргийг иж бүрэн, найдвартай тодруулахыг шаардана.

4.6 Орон нутагт хийгдэж буй төлбөр.

Энэхүү шаардлагын зорилго нь аж ахуйн нэгжүүд орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд шууд төлөх төлбөрийг ил тод болгох замаар нутгийн засаг захиргааны байгууллагын хүртэх үр өгөөжийн талаарх ойлголтыг сонирхогч талуудад олгох, нутгийн засаг захиргааны байгууллага дотооддоо бий болгосон олборлох үйдвэрлэлийн орлогын удирдлагад тавих олон нийтийн хяналтыг бэхжүүлэхэд оршино.

- a) Олон талт оролцогчдын бүлэг нь харилцан зөвшилцсон орлогын урсгалын цар хүрээнд багтаан компаниудаас нутгийн засаг захиргааны байгууллагад төлсөн төлбөр нь материаллаг эсэхийн тогтоох шаардлагатай. Хэрэв ийм төрлийн төлбөрийг материаллаг хэмээн тооцвол компаниас орон нутгийн засаг захиргаанд төлж буй төлбөр, орон нутгийн хүлээн авч буй орлогыг ил тод болгох үүргийг Олон талын оролцоот бүлэг хүлээнэ. Олон талт оролцогчдын бүлэг нь орон нутагт хийгдэж буй төлбөртэй хамаарах мэдээллийн чанар, дээр заасан мэдээллийн баталгаажуулалттай холбоотой журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу гарган, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ.

4.7 Мэдээллийг задлах түвшин.

Энэхүү шаардлагын зорилго нь компанийн төлбөр болон газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас орж ирэх төрийн орлогыг олон нийтэд ил тод мэдээлэх байдлыг хангах, ингэснээр Засгийн газар өөрийн хууль эрх зүй, төсвийн хүрээгээр тодорхойлсон орлогоо хир зэрэг хяналт тавьж чадаж байгааг олон нийтэд үнэлэх боломжийг бүрдүүлдэг. Засгийн газар олборлох төсөл бүрээс авах ёстой зүйлээ авдаг байх явдал юм.

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлагууд

- a) ОУИТБС-ын мэдээлэл нь төсөл нэг бүрээр, компани, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь дэлгэрүүлэн задлан харуулах боломжтой байх ёстой.

Нэр томьёоны
тайлбар

Төсөл гэдэг нь нэг гэрээ, тусгай зөвшөөрөл, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрээр зохицуулагдан, төртэй хамаарах төлбөрийн үүрэг хариуцлагын үндсийг бүрдүүлж буй үйл ажиллагаа хэмээн тодорхойлогдоно. Гэвч хэд хэдэн тооны ийм төрлийн гэрээ хэлэлцээр харилцан холбоотой байвал Олон талт оролцогчдын бүлэг нь ямар тохиолдолд нэг төсөл хэмээн үзэхийг тодорхойлон, баримтжуулсан байна. Агуулгын хувьд харилцан холбоотой гэрээ гэдэг нь үйл ажиллагаа болон газар зүйн хувьд уялдмал гэрээ, тусгай зөвшөөрөл, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрүүд эсвэл Засгийн газартай байгуулж, төлбөрийн үүргийг тусгасан, агуулгын хувьд ижил нөхцөл бүхий хамаарах гэрээнүүдийг хэлнэ. Ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг нэг гэрээ, хамтарсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн хуваах гэрээ эсвэл бусад нийтлэг зохицуулах эрх зүйн гэрээ зэргээр ерөнхийлөн зохицуулсан байж болно. ОУИТБС-ын ил тод болгох цар хүрээнд хамаарах төлбөрийг төслийн бус харин аж ахуйн нэгжийн түвшинд ноогдуулж буй бол компани нь тухайн төлбөрийн компанийн түвшинд ил тод болгож болно.

4.8 Мэдээллийн хамрах хугацаа/ цаг хугацаат байдал

Энэхүү шаардлагын зорилго нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудын төлсөн төлбөр болон

Засгийн газрын тэднээс авсан орлогыг олон нийтэд ил тод мэдээлэх нь олон нийтийн хэлэлцүүлэг, бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой байх ёстой.

- a) Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь жил тутам ОУИТБС-ын Стандарт болон талуудын баталсан ажлын төлөвлөгөөний (Шаардлага 1.5 болон Шаардлага 7.2 (b-c)) дагуу мэдээллийг байнга, цаг хугацаанд нь ил тод болгон нийтэлж байна. Олон талт оролцогчдын бүлэг нь ОУИТБС-ын ил тод болгох хугацаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийн хугацааг тохиролцон батална.
- b) Ил тод болгож буй мэдээлэл нь нягтлан бодох бүртгэлийн хамгийн сүүлийн жилийн өмнөх жилээс илүүгүй хоцролттой байх ба жишээ нь 2023 оны санхүүгийн жилийн мэдээлэл хамгийн оройдоо 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнөх ил тод болж, нийтлэгдэж байх ёстой.

4.9 Мэдээллийн чанар ба баталгаажуулалт.

Энэхүү шаардлагын зорилго нь компанийн төлбөр ба/эсвэл газрын тос, байгалийн хий, уул уурхайгаас олсон төрийн орлогыг ил тод болгохын тулд зохих арга хэмжээг авсан эсэхийг баталгаажуулах явдал юм. ОУИТБС нь төрийн болон компанийн аудит, баталгаажуулалтын тогтолцоо, үйл ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилготой бөгөөд ингэснээр оролцогч талууд төлбөр, орлогын талаарх санхүүгийн мэдээлэл болон олборлох салбарын бусад мэдээллийн найдвартай байдалд итгэлтэй байх боломжтой болно.

- a) Олон талын оролцогчдын бүлэг нь олон улсын аудитын стандартыг мөрдөж, улсын төсвийн орлого найдвартай, хараат бус аудитад хамрагдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх үүрэгтэй.
- b) 4 дүгээр шаардлагын хүрээнд Засгийн газар болон компанийн зүгээс ил тод болгож буй мэдээлэл нь олон улсын аудитын стандартыг ашиглан найдвартай, хараат бус аудитад хамрагдах ёстой. Олон талын оролцогчдын бүлэг нь баталгаажуулсан аудитын талаарх тайлбар, тухайн мэдээлэлд хийгдсэн баталгаажуулалтын үйл явцын талаарх тайлбарыг багтааж, бусад дэмжих баримт бичгүүдийг олон нийтэд нээлттэй ил болгоно.
- c) Олон талын оролцоот бүлэг нь ОУИТБС-ын Удирдах хорооны баталсан стандарт журмын дагуу мэдээллийн чанар, баталгаажуулалтын журмыг зөвшилцөн батлах үүргийг хүлээнэ. Олон талын оролцоот бүлэг нь стандарт журмыг ямар нэгэн байдлаар материаллаг зөрчилгүйгээр даган мөрдөх үүргийг хүлээнэ.
Олон талт оролцогчдын бүлгийг ОУИТБС-ын 2, 3, 5, 6-р шаардлагын дагуу орлогын бус мэдээллийг ил тод болгох мэдээллийн найдвартай байдалд хандах хандлагыг зөвшилцөхийг зөвлөж байна.
Олон талын оролцоот бүлэг нь стандарт журмаас гадуур үйл ажиллагаа явуулах тохиолдолд ОУИТБС-ын Удирдах хорооноос урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Олон талын оролцоот бүлгээс гаргаж буй хүсэлтэд: ОУИТБС-ын стандартаар шаардсан мэдээллийг байнга, шаардсан дэлгэрэнгүй хэлбэрээр ил тод болгож буй эсэх; санхүүгийн мэдээлэл нь олон улсын стандартын дагуу, хариуцлагатай, хараат бус аудитад хамрагдсан эсэх, болон өмнөх түүхэн мэдээллийг хангалттай хэмжээнд хадгалж буй эсэх зэргийг багтаасан байна.

4.10 Төслийн зардал

Энэхүү шаардлагын зорилго нь тус улсын олборлох салбарын хайгуул, олборлолтын зардал болон компаниудын зардалд хяналт тавих төрийн бодлого, үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

- a) Хэрэгжүүлэгч орнууд газрын тос, байгалийн хий, уул уурхайн төслийн зардлыг хянах, орлого алдах эрсдэлийг удирдах төрийн бодлого, туршлагыг ил тод болгох шаардлагатай. Үүнд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, бодлогыг ил тод болгох, түүнчлэн зардлыг хянах чиглэлээр авсан арга хэмжээг багтаасан байх ёстой.
- b) Хэрэгжүүлэгч орнууд эцсийн зардал, татварын аудитын тайлан, эсвэл нөхөх боломжгүй гэж үзсэн зардал, хасагдахгүй гэж үзсэн зардал, үр дүнд нь хураах аливаа нэмэлт орлогыг багтаасан тайлангийн хураангуйг ил тод болгох нь зүйтэй.
- c) Компаниуд болон хэрэгжүүлэгч орнууд зарласан зардлаа төсөл, үйл ажиллагааны болон хөрөнгийн зардалтай холбоотой зардлаар ангилан ил тод болгохыг дэмжинэ. Тайлант онд зарласан үйл ажиллагааны зардалд өмнөх жилүүдэд гарсан зардлын хорогдлыг тооцож болно. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш гарсан зардлаа ил болгохыг компаниуд болон хэрэгжүүлэгч орнуудад уриалж байна.

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 3: ОУИТБС-ын шаардлагууд

ШААРДЛАГА 5

Орлогын удирдлага ба хуваарилалт

ОУИТБС нь оролцогчдод орлогыг улсын, боломжтой бол орон нутгийн төсөвт хэрхэн бүртгэх болон компаниудын нийгмийн зарцуулалтыг хэрхэн хөтлөх талаар ойлголт өгч буй орлогын хуваарилалттай холбоотой мэдээллийг, мөн компаниудын нийгмийн чиглэлтэй зарцуулалтыг ил тод болгохыг шаарддаг.

5.1 Орлогын хуваарилалт.

Энэхүү шаардлагын зорилго нь улсын төсөвт төвлөрүүлэх олборлох салбарын орлогыг нийтлэх, улсын төсөвт тусгагдаагүй олборлох салбарын орлогын ил тод, хариуцлагатай байдлыг хангахад оришино.

- a) Хэрэгжүүлэгч орнууд нь олборлох салбараас олж буй орлогын хуваарилалтын талаарх мэдээлэл, тайлбарыг ил тод болгох үүрэгтэй.
- b) Хэрэгжүүлэгч орнууд нь олборлох салбараас орж ирж буй бэлэн болон бэлэн бус орлогын аль нь улсын төсөвт бүртгэгдэж буй талаар ил тод байдлын мэдээлэлд дурдсан байх ёстой. Олборлох салбараас орж ирсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдолд энэхүү орлогын зарцуулалтын тухай тайлбарласан байна. Ийнхүү тайлбарлахдаа энэхүү зарцуулалттай холбогдох байгууллага болох баялгийн сан, хөгжлийн сан, орон нутгийн засаг захиргаа, төрийн өмчит компани, төсвөөс гадуурх бусад аж ахуйн нэгж гэх мэт тэдгээрийн санхүүгийн тайлан мэдээлэлтэй холбогдох холбоосыг мэдээлсэн байх шаардлагатай;
- c) Олон талт оролцогчдын бүлгүүдийг дотоодын орлогын ангиллын систем, ОУВС-гийн Засгийн газрын санхүүгийн статистикийн заавар зэрэг олон улсын стандартаас иш татахыг хөхиүлэн дэмжинэ.

5.2 Орон нутаг дахь шилжүүлэг.

Энэхүү шаардлагын зорилго нь орон нутгийн түвшинд оролцогч талуудад олборлох орлогын шилжүүлэг, менежмент нь хуулиар олгогдсон эрхэд нийцэж байгаа эсэхийг үнэлэх боломжийг олгох явдал юм.

- a) Тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журам, орлого хуваах бусад арга механизмын хүрээнд олборлох салбараас орсон орлогыг төв болон нутгийн захиргааны байгууллага хоорондоо шилжүүлбэл ийм төрлийн материаллаг төлбөрийг ил тод болгохыг Олон талын оролцоот бүлэг баталгаажуулах үүрэгтэй. Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь орлого хуваах тогтолцоо, томъёо түүнчлэн төв Засгийн газар, агентлагууд болон орон нутгийн хамаарах нэгжүүдийн хоорондын төлбөрийн шилжүүлгийг тухайн томъёог ашиглан тооцсон орлого болон бодит шилжүүлсэн орлогын зөрүүг мөн ил тод болгох ёстой. Аливаа зөрчлийн талаар Засгийн газар тайлбар өгөх шаардлагатай. Олон талт оролцогчдын бүлэг нь орон нутаг дахь шилжүүлгийн мэдээлэлд хамаарах мэдээллийн чанар, баталгаажуулалтад хамаарах журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу батлан гаргана.
- b) Олон талт оролцогчдын бүлгээс аливаа материаллаг зөрүү эсхүл түр/нэг удаагийн шилжүүлгийг ил тод болгох ба мэдээлэлд хамаарах мэдээллийн чанар, баталгаажуулалтад хамаарах журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу батлан гаргана.
- c) Олон талын оролцоот бүлэг нь олборлох үйлдвэрлэлийн салбараас төвлөрүүлсэн орлогыг зарцуулахаар тусгайлан заасан орон нутгийн түвшин дэх хөтөлбөр эсвэл хөрөнгө оруулалтыг хэрхэн удирдан хэрэгжүүлж буй болон бодитоор хуваарилсан дүн зэргийг ил тод тайлагнахыг хөхиүлэн дэмжинэ.

5.3 Орлогын удирдлага ба зарцуулалтын талаар нэмэлт мэдээлэл

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох салбарын орлогын удирдлагад тавих олон нийтийн хяналтыг бэхжүүлэх; олборлох салбарын орлогыг төсвийн тодорхой зардлыг санхүүжүүлэхэд ашиглах; төсвийн үйл явцын үндэс болсон таамаглалууд, түүний дотор орлогын тогтвортой байдалтай холбоотой анхаарах зүйлс зэргийг мэдэх юм.

- a) Олон талт оролцогчдын бүлгээс орлогын менежмент болон зарцуулалтын талаарх дараах нэмэлт мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ. Үүнд:
 - i. Олборлох салбараас олсон орлогыг ямар нэг тусгай хөтөлбөр түүний дотор жендер эсвэл бүс нутагт хуваарилсан бол энэ талаар тайлбарлах. Үүнд, тухайн орлогыг үр дүнтэй хариуцлагатай, үр ашигтай зарцуулахын тулд авсан арга хэмжээний талаар тайлбар хийх шаардлага.
 - ii. Тухайн улс орны төсөв, аудитын үйл ажиллагааны тухай тайлбар мэдээлэлд олон улсын боловсруулах, зарцуулах, аудитын тайлангийн тухай олон нийт нээлттэй мэдээлэл авч болох эх үүсвэр, тодорхой холбоосыг дурдах;
 - iii. Засгийн газар олборлох салбарын талаар холбогдох мэдээллийг тогтмол өгч байх нь орлогын тогтвортой байдал, байгалийн баялгаас хамааралтай байдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмэр оруулна. Үүнд, ирээдүйд төсвийн мөчлөгт

гарах өөрчлөлтүүдийн талаарх таамаглал, олборлох салбарын орлогын улсын төсөвт эзлэх урьдчилан таамаглаж буй хувь хэмжээ зэрэг мэдээлэл байж болно

- b) Хэрэгжүүлэгч орнууд олборлох салбараас олох ирээдүйн орлоготой холбоотой аливаа таамаглал, түүний дотор үйлдвэрлэлийн төлөвлөсөн түвшин, төслийн өртөг, түүхий эдийн таамагласан үнэ зэрэгтэй холбоотой суурь таамаглалыг ил тод болгох төлөвтэй байна. Орлогын таамаглалд эрчим хүчний шилжилт болон уур амьсгалын эрсдэлийг хэрхэн харгалзан үзсэн талаар Засгийн газар тайлбарлахыг дэмжиж байна.
- c) Олон талт оролцогчидын бүлгийн хүсэлтийн дагуу газрын тос, байгалийн хийн болон уул уурхайн компаниуд төслийн үйлдвэрлэлийн төлөвлөсөн түвшин, зардлаа нөхөхтэй холбоотой тооцоолсон хугацааг ил тод болгохыг дэмжинэ.

ШААРДЛАГА 6

Нийгэм, эдийн засгийн зардал

ОУИТБС нь орлогын менежмент болон зарлагатай холбоотой мэдээллийг ил тод болгохыг дэмжин, олборлох салбар нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр дагавар, үр дагаварт хүргэж байгаа эсэхийг үнэлэхэд оролцогч талуудад тусалдаг.

6.1 Олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийгэм, байгаль орчны чиглэлийн зарцуулалт

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох компаниудын нийгэм, байгаль орчинд оруулж буй хувь нэмрийг олон нийтэд ойлгуулах, олборлох компаниудын нийгэм, байгаль орчны зардалд хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг үнэлэх үндэслэлийг бий болгоход оршино.

- a) Олборлох үйлдвэрийн компаниудын материаллаг нийгмийн хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжоор үүрэг болгосон эсхүл Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтыг зохицуулах гэрээгээр зөвшөөрсөн тохиолдолд хэрэгжүүлэгч улс орнууд эдгээр шилжүүлгийг ил тод болгох ёстой. Тэрхүү шилжүүлэг нь мөнгөн бус хэлбэрээр хийсэн бол хэрэгжүүлэгч улс орнууд тухайн хөрөнгө оруулалтын нөхцөл байдал болон үнийн дүнг мөнгөн дүнгээр тооцон мэдээлнэ. Хэрэв компанийн хийсэн нийгмийн хөрөнгө оруулалтыг төрийн байгууллага биш харин гуравдагч этгээд хүлээн авсан бол тухайн этгээдийн нэр, үндсэн чиг үүрэг зэргийг нээлттэй тайлагнана. Хэрэгжүүлэгч орнууд боломжтой бол ашиг хүртэгчдийн талаарх жендэрээр ангилсан мэдээллийг ил тод болгох шаардлагатай. Хэрэв тухайн нийгмийн хөрөнгө оруулалтыг нэгтгэлд хамруулах боломжгүй бол хэрэгжүүлэгч улс орнууд хоёр талын компани ба/эсвэл Засгийн газраас энэхүү төлбөрийн тухай мэдээллийг дангаар ил тод болгохыг шаардана. Хэрэгжүүлэгч орнууд нийгэмд зайлшгүй шаардлагатай материаллаг зардлын түвшин, хуваарилалтыг тодорхойлсон гэрээ болон хуульд заасан бусад баримт бичгийг ил тод болгох ёстой.
- b) Олборлох үйлдвэрийн компаниудын төрд хийсэн материаллаг байгаль орчны чиглэлийн нийгмийн хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжоор үүрэг болгосон эсхүл Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтыг зохицуулдаг гэрээгээр зөвшөөрсөн тохиолдолд хэрэгжүүлэгч улс орнууд эдгээр шилжүүлгийг ил тод болгох ёстой. Байгаль орчинтой холбоотой төлбөрүүдийг гэрээнд заасан тохиолдолд хэрэгжүүлэгч орнууд эдгээр гэрээг ил тод болгох хүлээлт юм.
- c) Шаардлагын 4.9-д заасны дагуу нийгмийн болон байгаль орчны зардлын талаарх мэдээллийн чанар, мэдээллийн баталгааг шийдвэрлэх журмыг олон талт оролцогч талууд тохиролцох шаардлагатай. Нийгэм, байгаль орчны зардал, төлбөрийн талаар хууль ёсны болон гэрээгээр хүлээсэн үүргээ бодит амьдрал дээр мөрдөж байгаа эсэх талаарх үнэлгээг олон талт оролцогчдын бүлгээс энэхүү журамд оруулахыг хөхүүлэн дэмжинэ.
- d) Олон талт оролцогчдын бүлгээс тухайн нийгмийн болон байгаль орчны хөрөнгө оруулалт, шилжүүлгийг материаллаг хэмээн үзвэл үүнийг төрийн байгууллагад хийж буй бусад төлбөрийн нэгэн адил хэмжээнд ил тод болгох, тайлагнах үйл явцыг авч хэрэгжүүлэхийг дэмжинэ. Мөн боломжтой бол тэдгээр зардал, шилжүүлгийн үр шимийг хүртэгчдийн талаарх жендэрийн ангилсан өгөгдлийг ил болгоно. Олон талт оролцогчдын бүлгээс дээр дурдсантай холбоотой мэдээлэлд хамаарах мэдээллийн чанар, баталгаажуулалтад баримтлах журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу батлан гаргана.

6.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй/ төсвийн шинжтэй зардал.

Энэхүү шаардлагын зорилго нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд улсын төсөвт тусгагдаагүй, Засгийн газрын нэрийн өмнөөс олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зардлуудыг ил тод болгож, удирдлагадаа хариуцлага тооцоход оршино.

- a) Олборлох салбарт төр оролцон улмаар эрдэс баялгийн материаллаг төлбөр, орлогын хэмжээ нэмэгдэж буй бол санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийнхөө талаар төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс хүлээн авсан мэдээллийг ил тод болгох ёстой. Олон талт оролцогчдын бүлгээс бусад төлбөр болон орлогын урсгалын нэгэн адил хэмжээ, түвшинд хүрэх зорилготойгоор тайлагнах явцыг хэрэгжүүлэхийг шаардах бөгөөд энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн салбар болон хамтарсан компаниуд мөн хамаарна.

Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, Засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд орно. Хэрэгжүүлэгч улс орнууд болон Олон талын оролцоот бүлэг нь ямар нэгэн зарцуулалт нь төсвийн шинжтэй эсэхийг тогтоохдоо ОУВС-аас гаргасан төсвийг шинжтэй зардлын тодорхойлолтыг харгалзан үзэж болно.

6.3 Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулах хувь нэмэр.

Энэхүү шаардлагын зорилго нь олборлох үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр, эдийн засаг дахь байгалийн баялгийн хараат байдлын түвшинг олон нийтэд ойлгуулах явдал юм.

- a) ОУИТБС-ын хэрэгжилтэд хамрагдсан санхүүгийн жилд олборлох үйлдвэрүүдийн эдийн засагт оруулах хувь нэмрийн талаарх мэдээллийг хэрэгжүүлэгч орнууд ил тод болгох шаардлагатай. Үүнд дараах мэдээллүүд заавал багтсан байна:
 - i. Олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээ үнэмлэхүй дүнгээр болон түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээгээр илэрхийлэх ба албан бус салбарын үйл ажиллагааны тойм тооцоог багтаасан байх. Бичил болон жижиг уурхай үүнд орох ба эдгээрээр үл хязгаарлагдана;
 - ii. Олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын (татвар, нөөцийн төлбөр, шагнал урамшуулал, хураамж болон бусад төлбөрүүд оролцуулан) хэмжээг үнэмлэхүй дүнгээр ба улсын төсөвт эзлэх хувь хэмжээгээр;
 - iii. Олборлох салбарын хийж буй экспортын хэмжээг үнэмлэхүй дүнгээр болон нийт экспортод эзлэх хувь хэмжээгээр;
 - iv. Олборлох салбарт бий болгосон ажлын байрны нийт тоог үнэмлэхүй дүнгээр болон нийт ажил эрхлэлтэд эзлэх хувь хэмжээгээр. Энэхүү мэдээллийг хүйс ба ажлын байрны түвшингээр заавал задлан оруулах ба боломжтой бол цаашид компани, төслөөр задлах ба гадаад дотоодын ажилчдын задаргааг оруулбал маш сайн.
Компаниудын цалингийн зөрүүг гендерээр гаргахыг уриална.
 - v. Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа төвлөрөн явагдаж буй гол бүс нутгийн тухай.

6.4 Олборлох үйлдвэрлэлийн салбараас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл

Энэхүү шаардлагын зорилго нь холбогдох талуудыг олборлох үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг зохицуулах зохицуулалтын тогтолцоо, хяналт-шинжилгээний хүчин чармайлтын хүрэлцээг үнэлэх, олборлох компаниуд байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг үнэлэх үндэслэлийг бий болгоход оршино.

- a) Хэрэгжүүлэгч орнууд олборлох салбар дахь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн удирдлага, хяналтыг зохицуулах эрх зүйн холбогдох заалт, захиргааны дүрмийн тоймыг ил тод болгох шаардлагатай. Үүнд нийгэм, хүйс, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөхөн сэргээлт, ашиглалтаас гаргах, хаах хөтөлбөр зэрэг байгаль орчны зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой дүрэм журмын талаарх мэдээллийг багтаасан байх ёстой. Мөн дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагын талаарх мэдээллийг тусгах ёстой.
Олон талт оролцогчдын бүлэг төлөвлөж буй болон хийгдэж буй аливаа шинэчлэлийн талаарх мэдээллийг оруулахыг дэмжинэ.
- b) Хэрэгжүүлэгч улс орнууд болон тайлагнадаг компаниудаас хууль, гэрээнд заасан олон нийтийн байгаль орчин, нийгэм, гендерийн нөлөөллийн үнэлгээ, мониторингийн тайлан, зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг олон нийтэд нээлттэй байлгахыг шаарддаг.
- c) Компаниуд нийгэм, гендер, байгаль орчны менежмент, нөлөөллийн талаарх нэмэлт мэдээллийг ил тод болгохыг хөхүүлэн дэмжинэ.
- d) Хэрэгжүүлэгч орнуудыг олборлох үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой хяналт-шинжилгээ, хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ. Үүнд ус, газар, утаа, хүний эрхийн асуудалтай холбоотой байгаль орчин, нийгмийн мониторингийн үйл ажиллагаа, эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл багтаж болно.
- e) Хэрэгжүүлэгч орнууд байгаль орчны хориг арга хэмжээний үйл явц, тэр дундаа хэрэглэсэн аливаа хориг арга хэмжээний талаарх мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ.

ШААРДЛАГА 7

Үр дүн ба нөлөөлөл

Олборлох салбарын мэдээллийг тогтмол ил тод болгосон ч энэ талаарх олон нийтийн мэдлэг бага, тайлангийн тоо баримт юу илэрхийлж байгааг мэддэггүй, олборлох салбарын засаглалын талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхгүйгээр бол энэ мэдээлэл практик ач холбогдол багатай. Үр дүн, нөлөөлөлтэй холбоотой ОУИТБС-ын шаардлагууд нь байгалийн нөөцийн орлогын удирдлагын талаар оролцогч талууд харилцан яриа өрнүүлэхэд чиглэдэг. ОУИТБС-ын ил тод мэдээлэл нь өргөн хүрээний олон нийтийн хэлэлцүүлгийг бий болгон, үүнд хувь нэмрээ оруулах замаар ОУИТБС-ын зарчмуудыг биелүүлэхэд хүргэдэг. Иймд санаачилгын хэрэгжилтийн үеэр авсан сургамжууд дээр үндэслэн үйл ажиллагаа явуулан, ОУИТБС-ын тайлангаар илэрсэн зөрүүг тайлбарлаж, шаардлагатай бол зөрөөг бууруулах, арилгах арга хэмжээ авч, ОУИТБС-ын хэрэгжилтийг тогтвортой, тулх суурьтай болгох нь чухал.

7.1 Олон нийтийн хэлэлцүүлэг.

Энэхүү шаардлагын зорилго нь холбогдох өгөгдлийг гол оролцогч талуудад хүртээмжтэй, оролцогч талуудын хэрэгцээг тусгах арга замаар авлигын эрсдэл, эрчим хүчний шилжилт, жендэр, орлогын бүрдүүлэлт зэрэг олборлох үйлдвэрлэлийн засаглалын талаарх нотолгоонд суурилсан олон нийтийн хэлэлцүүлгийг явуулахад оршино.

- a) Олон талт оролцогчдын бүлэг нь Засгийн газар болон компаниудын ил тод болгож буй мэдээлэл нь иж бүрэн, ойлгомжтой байж, үүнийг идэвхтэйгээр түгээн сурталчилж, олон нийтэд нээлтэй байлгаж, олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулж буйг баталгаажуулж байх ёстой. Энэ зорилгоор хандах гол зорилтот бүлэг нь Засгийн газар, хууль тогтоогч нар, иргэний нийгэм, компаниуд болон хэвлэл мэдээллийн байгууллага байна.
- b) Олон талт оролцогчдын бүлэг нь доорх ажлуудыг хийх шаардлагатай:
 - i. ОУИТБС-ын мэдээлэл нь олон нийтэд өргөн хүрээнд түгээгдэж, хүртээмжтэй буйг баталгаажуулах.
 - ii. Ил тод болгож буй мэдээлэл нь иж бүрэн, ялангуяа тодорхой, хүртээмжтэй хэлбэрээр бичигдсэн, хамаарах хэл дээр бэлтгэгдсэн, төрөл бүрийн хүйс болон иргэдийн дэд бүлгийн ялгаатай хэрэгцээ болон хүртээмжийн саад тотгоруудыг харгалзан үзсэн байдлаар ил тод болж буйг баталгаажуулах;
 - iii. Олборлох үйлдвэрлэлийн салбарын засаглалын сэдвээр мэдлэг нэмэгдүүлэх, яриа хэлэлцүүлгийг хангах зорилгоор мэдээлэл түгээх арга хэмжээ төр, иргэний нийгэм, компаниудын зүгээс зохион байгуулахыг баталгаажуулан хэрэгжүүлэх.
- c) Олон талын оролцоот бүлгийг дараах үйл ажиллагааг явуулахыг хөхиүлэн дэмжинэ:
 - i. Тайлангуудын товч тоймыг, мэдээллийн тодорхой, тэнцвэртэй дүн шинжилгээтэйгээр бэлтгэн гаргаж, мэдээллийн эх сурвалж, зохиогчийг тодорхой дурдаж байх;
 - ii. Олборлох салбарын менежментийн тодорхой чиглэлийн сэдэвчилсэн тайланг гаргаж, тэдгээрийг онлайн ашиглах боломжтой болгоно.
 - iii. ОУИТБС-г хэрэгжүүлэхэд ОУИТБС-н шаардлагуудын дагуу мэдээллийг ил тод болгосноор олон талын оролцогчдын бүлгийн тодорхойлсон олборлох салбарын засаглал, тэр дундаа авлигын эрсдэл, жендэрийн тэгш байдал, орлогын бүрдүүлэлт, эрчим хүчний шилжилтийн нөлөөлөл, бичил уурхайн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг идэвхжүүлэх болно.
 - iv. Орлогын тод болгоход урсгал нэг бүрийн төрийн захиргааны шат бүр дээр хуримтлагдаж буй нийт орлогод эзлэх хувь хэмжээг тоймлон гаргах;
 - v. Чадавч бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ялангуяа иргэний нийгэмд зориулан, иргэний нийгмээр дамжуулан хийж тайлангийн мэдээлэл, онлайн ил тод мэдээллийн талаарх ойлголтыг сайжруулж, иргэд, хэвлэл мэдээлэл болон бусад талууд тухайн мэдээллийг ашиглахыг хөхиүлэн дэмжих.

7.2 Мэдээллийн хүртээмж болон нээлттэй мэдээлэл

Энэхүү шаардлагын зорилго нь нээлттэй мэдээлэл, харилцан ажиллах боломжтой форматаар нийтлэх замаар олборлох үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг илүү өргөн хүрээнд ашиглах, дүн шинжилгээ хийх боломжийг олгох явдал юм.

- a) Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь ОУИТБС-ын мэдээлэл, тайланг олон нийтэд нээлттэй байлгана. Олон талын оролцоот бүлэг нь дараах үүргийг хүлээнэ:
 - i. ОУИТБС-ын мэдээллийн хүртээмж, түгээлт болон дахин ашиглалтын талаарх нээлттэй мэдээллийг бодлогыг зөвшилцөн гаргах. Төрийн байгууллагууд болон компаниуд нь ОУИТБС-ын мэдээллийг нээлттэй тусгай зөвшөөрөлтэйгээ ил тод нийтэлж, тухайн мэдээллийг урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ашиглах боломжтойг хэрэглэгчдэд мэдээлэх ёстой.
 - ii. ОУИТБС-ын мэдээллийг нээлттэй мэдээллийн форматаар ил тод болгож, ийнхүү ил тод

болгосон тухайгаа мэдээлж байх. Нээлттэй мэдээллийн формат нь CSV эсвэл Excel форматаар буй мэдээллийг хэлэх бүх хамаарах бүх хүснэгт, график, зургуудыг багтаасан байна.

- iii. ОУИТБС-ын мэдээллийн хамрах санхүүгийн жил бүрийн дата файлуудын иж бүрэн тоймыг ОУИТБС-ын Удирдах хорооны гаргасан маягтын дагуу бэлтгэн гаргах⁴.
- b) Хэрэгжүүлэгч орон нь мэдээллийн машинд уншигдахуйц, харилцан холбогдож ажиллахуйц байдлаар системтэйгээр ил болгож, ОУИТБС-ын болон бусад дата файлд код эсвэл нэр өгч тухайн мэдээллийг олон нийтэд нээлттэй бусад мэдээлэлтэй харьцуулах боломжийг хангана.

7.3 ОУИТБС-ын хэрэгжилтээс гарах зөвлөмжүүд

Энэхүү шаардлагын зорилго нь олон талт оролцогч талууд ОУИТБС-ын үйл явцаас гарсан үр дүн, зөвлөмжийг тогтмол авч үзэж, нэн тэргүүний зорилт гэж үзсэн зөвлөмжийн дагуу үйл ажиллагаа явуулах замаар ОУИТБС-ын хэрэгжилт нь бодлого боловсруулахад хувь нэмэр оруулдаг тасралтгүй суралцах үйл явц мөн гэдгийг баталгаажуулах явдал юм (Шаардлага харна уу). 1.5).

- a) Байгалийн баялгийн засаглалд үзүүлэх ОУИТБС-ын хэрэгжилтийн нөлөөллийг бэхжүүлэх зорилготойгоор Олон талт оролцогчдын бүлэг нь авсан сургамжууддаа суурилан үйл ажиллагаа явуулж, тайланд гарч буй зөрүүний учир шалтгааныг тогтоон арга хэмжээ авч, ОУИТБС-ын тайлангаас гаргасан зөвлөмжүүдийг анхааран шаардлагатай арга хэмжээг авч байх үүрэгтэй. Олон талын оролцоот бүлэг нь төрийн систем болон байгалийн баялгийн засаглалыг бэхжүүлэх зөвлөмжүүдийг зөвшилцөн гаргаж болно. Боломжтой бол санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь тухайн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хянан үзэж байх нь зөв.

⁴ ОУИТБС-ын хураангуй мэдээллийн загварыг citi.org/guide дээрээс үзнэ үү.

БҮЛЭГ 4

ОУИТБС-ыг дэмжиж буй компаниудаас хүлээх хүлээлт

Энэ хэсэгт компаниуд ОУИТБС-ыг дэмжих үедээ мөрдөх үүрэгтэй хүлээлтүүдийг тодорхойлсон.

ОУИТБС-ыг дэмжигч компаниуд ил тод байдлыг нэмэгдүүлэх нь байгалийн нөөцийн менежментийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх төрийн болон компанийн засаглалыг бэхжүүлэх, авлигыг бууруулах, газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангах үүднээс мэдээллээр хангах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Дэмждэг компаниуд нь Засгийн газар, иргэдтэй хамтран байгалийн баялгийг нийгэм, нийгэмд ашигтай байдлаар хүргэхийг зорьдог.

Дэмждэг компаниуд өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнуудад ОУИТБС-ын стандартыг мөрдөж тайлагнадаг. Мөн дэмжигч компаниуд нь олон талын оролцоот бүлэгт орж, хэрэгжүүлэгч орнуудад ОУИТБС-ын үйл явцад идэвхтэй оролцохыг уриалж байна.

ОУИТБС-ыг дэмжигч компаниуд ОУИТБС-ын хэрэгжилтийг ОУИТБС-ын Холбооны гишүүн болсоноор дамжуулан дэмжиж энэхүү хүлээлтийг хангаж, ОУИТБС-ын олон улсын менежментэд жил бүр санхүүгийн хувь нэмрээ оруулдаг.

ОУИТБС-ыг дэмжиж буй бүх компаниудаас дараах зүйлсийг хүлээнэ.

Хүлээлт 1

ОУИТБС-ыг дэмжиж буйгаа олон нийтэд нээлттэй зарлаж, нийтлэх, ОУИТБС-ын Зарчмууд болон ОУИТБС-ын Стандартыг газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын ил тод байдлын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болгох

Хүлээлт 2

ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч бүх улс оронд ОУИТБС-ын стандартын дагуу Компани эсвэл түүний хяналтад байгаа охин компаниудын үйл ажиллагаа иж бүрэн ил тод болгох. Бусад Компанийн тайландаа тусгаагүй тохиолдолд ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнууд дахь газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн хяналтанд байдаг охин компаниудын жагсаалтыг нийтэд ил болгоно.

Хүлээлт 3

Компани өөрийн үйл ажиллагаа явуулж буй хэрэгжүүлэгч бус орнуудад ил болгох боломжгүйгээс бусад тохиолдолд ОУИТБС-ын стандартын дагуу Засгийн газарт төлж буй татвар, төлбөрийг төслийн түвшинд ил тод болгож олон нийтэд мэдээллэнэ. Боломжгүй тохиолдолд ил болгоход тухайн улс орны хууль эрх зүйн болон практик саад бэрхшээлийг олон нийтэд тайлбарлах ёстой.

Хүлээлт 4

ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын төрөөс газрын тос, байгалийн хий болон/эсвэл ашигт малтмалын нөөцийг худалдан авч буй компаниудын хувьд ОУИТБС-ын стандарт болон Засгийн газраас газрын тос, хий, ашигт малтмал худалдаж авч буй компаниудын ОУИТБС-ын тайлангийн удирдамжийн дагуу хүлээн авсан хэмжээ, төлсөн төлбөрөө ил тод болгоно.

Хүлээлт 5

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 4: ОУИТБС-ыг дэмжиж буй компаниудаас хүлээх хүлээлт

нийтэд мэдээлэх.

Хүлээлт 6

ОУИТБС-ын стандартын дагуу эцсийн өмчлөлийн ил тод байдлыг дэмжих талаар олон нийтэд зарлаж, хэвлэн нийтлэх, эцсийн өмчлөгчийг олон нийтэд мэдээлэх, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд хөрөнгийн бирж(үүд)-ийн нэрийг ил болгож, бүртгэлтэй байгаа хөрөнгийн биржийн мэдүүлэгт бүртгэлтэй байгаа холбоос(ууд)-ыг оруулах ба холбогдох дүрэм журам болон бүртгэлийн шаардлагад заасан зүйлийг

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 4: ОУИТБС-ыг дэмжиж буй компаниудаас хүлээх хүлээлт

хийх болно гэдгийг хүлээн зөвшөөрнө.

Хүлээлт 7

Компанийн зүгээс авлигын эрсдэлийг хэрхэн удирдаж буйг тодорхойлсон авлигын эсрэг бодлогыг хэвлэн нийтлэх, нягтлан шалгах үйл явцад оролцох, тэр дундаа хамтарсан үйлдвэрийн түншүүд, гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчдийн талаарх ашигтай өмчлөлийн мэдээллийг хэрхэн цуглуулж, эрсдэлд суурилсан алхмуудыг өөрийн үйл явцад ашиглах зэрэг орно.

Хүлээлт 8

ОУИТБС-ын стандартын дагуу газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, ашиглалтыг зохицуулах гэрээ, тусгай зөвшөөрлийг олон нийтэд мэдээлэх Засгийн газрын хүчин чармайлтыг олон нийтэд зарлаж, нийтлэх, ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудад Засгийн газрын журамд нийцүүлэн гэрээ, тусгай зөвшөөрлийг олон нийтэд ил тод болгоход хувь нэмэр оруулна.

Хүлээлт 9

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын жендэрийн олон талт байдлын талаарх амлалт ба/эсвэл бодлогыг нийтэлж, ОУИТБС-ын стандартын дагуу ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын тайлагналыг жендэрээр нь ангилсан салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг ил тод болгох замаар дэмжих.

ОУИТБС-ыг дэмжигч компаниудын хүлээлтийн үнэлгээ

ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газар нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлийг сонгох үүрэгтэй ОУИТБС-ын Дэлхийн бага хуралтай холбогдуулан ерөнхийдөө гурван жил тутамд зохион байгуулдаг ОУИТБС-ын Холбооны гишүүдийн хурлын өмнө дэмжлэг үзүүлж буй компаниуд хүлээлтийг хангаж байгаа эсэхийг үнэлдэг. Үнэлгээний үр дүнг тухайн компанийг хянан үзсэний дараа нийтэлдэг.

ОУИТБС-ыг дэмжигч бүх компаниуд хүлээлтийг биелүүлэх төлөвтэй байна. Хүлээлтийг бүрэн хангаагүй гэж үнэлэгдсэн компаниудыг дагаж мөрдөх журмын зөрүүг арилгахыг дэмжих ба ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэж, дахин үнэлгээ хийсний дараа дутагдлыг арилгасны дараа хүлээлтийг бүрэн хангасан гэж үнэлнэ.

ОУИТБС-ын Үндсэн дүрмийн 5, 8 дугаар зүйлд заасны дагуу ОУИТБС-ын Холбооны оролцогч тал бүр ОУИТБС-ын Холбооны гишүүдийг томилох, ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүн болон орон гүйцэтгэгчийг нэр дэвшүүлэх асуудлыг зохицуулах дүрмээ шийдвэрлэдэг. Эдгээр дүрмийг Компанийн сонгуулийн тойргийн удирдамжид тусгасан болно.

Компаниудын сонгуулийн тойргийн удирдамжид нийцүүлэн ОУИТБС-ын Удирдах зөвлөлд нэр дэвшүүлсэн хүмүүсийг сонгохдоо хамгийн түрүүнд анхаарах зүйл бол ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газрын үнэлгээгээр дэмжигч компаниуд хүлээлтийг хангаж байгаа эсэхийг авч үзэх үүрэг хүлээдэг. Компаниудын сонгуулийн тойрог нь өөрийн салбар тойргуудаараа дамжуулан юуны өмнө хүлээлтийг бүрэн хангасан дэмжигч компаниудаас ОУИТБС-ын Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийг авч үздэг. Анх удаа үнэлэгдсэн, хүлээлтийг бүрэн хангаагүй шинэ дэмжигч компаниудын нэр дэвшигчдийг хэрэв компани дагаж мөрдөх дутагдлыг арилгах төлөвлөгөөг танилцуулсан бол авч үзэж болно.

ОУИТБС-ын Холбооны гишүүнээр томилогдсон ОУИТБС-ыг дэмжигч компанийн төлөөлөгчид хэрэгжүүлэгч орнуудын тойрог, Компаниудын тойрог, Иргэний нийгмийн байгууллагын тойргийн бусад гишүүдийн нэгэн адил ОУИТБС-ын дүрэм, ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө.

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 5: Протокол: Иргэний нийгмийн оролцоо

БҮЛЭГ 5

Протокол: Иргэний нийгмийн оролцоо

Энэ хэсэгт ОУИТБС-ын үйл явцад иргэний нийгмийн бүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцоог хангах протоколыг

тусгасан болно.

1. Танилцуулга

Иргэний нийгмийн оролцоо нь Зарчим 4: “Улсын төсвийн орлого, зарлагын талаарх олон нийтийн ойлголт нь тогтвортой хөгжлийн төлөө бодитой, оновчтой шийдлүүдийн талаар нийтээр хэлэлцэж, мэдээлэхэд тусалж чадна” гэх ОУИТБС-ын зорилтуудад хүрэхэд чухал үүрэгтэй. ОУИТБС-ын ажиллагаанд оролцох иргэний нийгмийн идэвхтэй оролцоо нь ОУИТБС-ын бий болсон ил тод байдал нь илүү их хариуцлага хүлээхэд хүргэснийг батлах түлхүүр юм. ОУИТБС-ын стандартыг амьдралд нэвтрүүлэх тэмүүлэл нь илүү холбоотой, илүү найдвартай бөгөөд илүү ашиглаж болохуйц мэдээллийн бий болгох хүсэл бөгөөд олборлох салбарын засаглал эсхүл олон нийтийн хариуцлагын менежмент ба орлогын менежмент дэх илүү өргөн хүрээг хамруулан шинэчлэхэд энэхүү мэдээллийг холбох холбоос болгох явдал юм. Түүнчлэн, ОУИТБС-ын бий болгосон мэдээллийг ашигладаг болгохоор идэвхтэй ажиллах иргэдийн чадвар нь ОУИТБС-ын хэрэгжилт болон ОУИТБС-д оролцох иргэний нийгмийн оролцооны чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох иргэний нийгмийн оролцоог албан ёсоор ОУИТБС-ын хэрэгжилтийн 2 үе шатанд үнэлдэг: нэр дэвшигчийн үнэлгээ ба баталгаажуулах явцад. Түүнчлэн, зарим нэг хэрэгжүүлэгч улс орнууд дахь нөхцөл байдлын талаар Удирдах зөвлөлд тусгайлан танилцуулсан асуудлуудыг шийдвэрлэхээр түр хэлбэрээр иргэний нийгмийн оролцоог үнэлж болно. Энэхүү протоколд ОУИТБС-ын Удирдах зөвлөл (салбар хороод орно) болон баталгаажуулагчид иргэний нийгмийн оролцоо (Шаардлага 1.3)-тай холбоотой шаардлагууд хангагдсан эсэх, түүнчлэн тэдгээр асуултад хариулахад ашиглах нотолгооны төрлийг үнэлэхдээ анхаарах асуултуудыг заасан. ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох иргэний нийгмийн оролцоотой холбоотой шаардлагууд нь ОУИТБС-ын хэрэгжилтийн бүх шатанд тогтмол хэвээр байх бөгөөд ОУИТБС-ын Удирдах хороо хэрэгцээтэй шаардлагуудыг үнэлэхдээ ашигладаг нотолгоо нь тухайн улс орны нөхцөл байдал, хэрэгжилтийн үе шат, мэдээллийн хүртээмжээс хамааран өөр өөр байна. Тавигдсан асуултууд болон доорх 2.1-2.5 дугаар зүйлд дурдсан санал болгосон нотолгооны төрлүүд нь шаардлагуудыг орлохгүй бөгөөд бүхнийг хамарсан жагсаалт биш. Гэхдээ энэ нь иргэний нийгэмтэй холбоотой шаардлагуудын үнэлгээний хамрах хүрээгээр хангадаг.

2. ОУИТБС иргэний нийгмийг тайлбарлах нь

Энэхүү протоколын зорилгоор ‘иргэний нийгмийн төлөөлөгчид’ гэдэгт Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд орно гэхдээ тэдгээрээр хязгаарлагдахгүй, ОУИТБС-ын үйл ажиллагаанд бодитойгоор оролцдог иргэний нийгмийн төлөөлөгчид орно. “ОУИТБС-ын үйл ажиллагаа” гэдэгт ОУИТБС-д нэгдэн орох хүсэлт буюу өргөдөл гаргахад бэлтгэх, Олон талт оролцогчдын бүлгийн хурлууд, Олон талт оролцогчдын бүлгийн төлөөлөгчидтэй хийх уулзалт зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын ОУИТБС-ын талаарх ИНБ-уудын өөрийн сонгуулийн хурал буюу уулзалтууд, ОУИТБС-ын тайлан гаргах, ОУИТБС-ын тайлангийн материал бэлдэх, дүн шинжилгээ өгөх, ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой санал бодлоо илэрхийлэх, байгалийн баялагийн засаглалтай холбоотой санал бодлоо илэрхийлэх зэрэг үйл ажиллагаанууд орно.

Иргэний нийгмийн нөхцөл байдлыг үнэлэхдээ Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид нь дараах шалгуурыг ашиглана:

2.1 Үзэл бодлоо илэрхийлэх:

Иргэний нийгмийн төлөөлөгчид ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох болон ямар нэгэн хяналт, эсэргүүцэл, цэрлэлгүйгээр ОУИТБС-ын үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх боломжтой байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид дараах зүйлийг анхааралдаа авна. Үүнд:

- Иргэний нийгмийн төлөөлөгчид Олон талт оролцогчдын бүлгийн хурлууд, ОУИТБС-ын тайланг түгээхийг оролцуулаад ОУИТБС-ын үйл явдал, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр зэргээр ОУИТБС-ын үйл ажиллагааны талаар олон нийтэд хандан чөлөөтэй ярих боломжтой байна.
- Олон янзын оролцогчийн үзэл бодол эсхүл хараат бус гуравлагч талуудын гаргаж өгсөн үндэслэл бүхий нотолгоог оруулаад бодит практик нь иргэний нийгмийн төлөөлөгчдийн өөрсдийнхөө эрх зүйн СТАНДАРТ эсхүл өөрсдөө тавьсан хориг нь шийтгэл хүлээнэ гэсэн айдас болон тэрхүү эрх зүйн ба шаардлага иргэний нийгмийн төлөөлөгчдийн мэдээллийг түгээлт, ОУИТБС-ын үйл ажиллагааны талаар олон нийт санал бодлоо илэрхийлэхэд нөлөөлсөн эсэх зэргийн улмаас ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжсэн болохыг харуулдаг.

2.2 Үйл ажиллагаа:

Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломжтой байна. ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид нь эрх зүйн, зохицуулалтын, захиргааны болон бодит орчин нь иргэний нийгмийн төлөөлөгчдийн ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох боломжид сөргөөр нөлөөлж байгаа эсэхийг анхааралдаа авна. Жишээлбэл:

- Иргэний нийгмийн төлөөлөгчдийн ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох боломжид нөлөөлж

буй эрх зүйн, зохицуулалтын эсхүл захиргааны саад бэрхшээл. Үүнд иргэний нийгмийн байгууллагуудын ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох боломжид сөргөөр нөлөөлсөн тэдний бүртгэлтэй холбоотой эрх зүйн эсхүл захиргааны ажиллагаа, ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой ажил гүйцэтгэхэд иргэний нийгмийн байгууллагуудад саад болсон санхүүжилт авах боломжид тавих эрх зүйн эсхүл захиргааны хориг, ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбоотой хурал, уулзалт зохион байгуулахад иргэний нийгмийн байгууллагуудад саад болж буй эрх зүйн эсхүл захиргааны асуудлууд, ОУИТБС-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, санал гаргахад учрах эрх зүйн эсхүл захиргааны саад бэрхшээл гэх мэт орно.

- Санал бодлоо илэрхийлэх эсхүл шилжин суурьших эрх чөлөөг хязгаарлах зэргээр иргэний нийгмийн төлөөлөгчдийн үндсэн эрхийг ОУИТБС-ын үйл ажиллагааны хэрэгжилттэй холбогдуулан хязгаарласан болохыг сануулж байгаа аливаа нотолгоо.

2.3 Холбоо

Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ОУИТБС-ын үйл ажиллагаатай холбогдуулан бие биетэйгээ харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах боломжтой байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид дараах зүйлийг анхааралдаа авна:

- Иргэний нийгмийн Олон талт оролцогчдын бүлгийн төлөөлөгчид нь Олон талт оролцогчдын бүлгийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулах, бүлгийн тайлангийн үр дүнг хэлэлцэх зэргээр Олон талт оролцогчдын бүлэгт багтаагүй бусад иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг хайх болон тэрхүү боломжийг нь хязгаарлахгүй.
- Иргэний нийгмийн Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд болон илүү өргөн хүрээг хамарсан иргэний нийгмийн төлөөлөл сонгох тойрог хоорондын албан эсхүл албан бус харилцаа холбооны суваг чөлөөтэй байх.
- Иргэний нийгмийн Олон талт оролцогчдын бүлгийн төлөөлөгчид нь Олон талт оролцогчдын бүлгийн төлөөлөл болон ОУИТБС-ын үйл ажиллагааны талаарх хэлэлцүүлэгтэй холбоотой байх зэрэг илүү өргөн хүрээний иргэний нийгэмд чөлөөтэй хүрч ажиллах.

2.4 Оролцоо:

Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ОУИТБС-ын үйл ажиллагааны төсөл, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэйгээр оролцох боломжтой байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид нь дараахийг анхаарна:

- Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах боломжтой байна. Үүнд жишээлбэл, ажлын төлөвлөгөөний зорилт, үйл ажиллагаа, ОУИТБС-ын тайлагнах ажиллагааны хамрах хүрээ, ОУИТБС-ын тайланг батлах, ОУИТБС-ын үйл ажиллагааны жилийн өөрийн үнэлгээг жилийн ажлын тайлангаар дамжуулан хийх, баталгаажуулалт гэх мэт асуудлаар Олон талт оролцогчдын бүлгийн гол тайлан, мэдээтэй холбоотой хувь нэмэр, өмгөөллийн нотолгоо орно. Түүнчлэн, иргэний нийгэм нь Олон талт оролцогчдын бүлгийн хурал, Олон талт оролцогчдын бүлгийн ажлын хэсэг болон ОУИТБС-ын бусад үйл явдлуудад тогтмол оролцож байгааг болон иргэний нийгмийн байгууллагуудын санал бодлыг анхааралдаа аван, Олон талт оролцогчдын бүлгийн хурлын тэмдэглэлд баримтжуулсан болохыг нотлох нотолгоо орно.
- Иргэний нийгмийн төлөөлөгчид нь тэдэнд ОУИТБС-д оролцох хангалттай боломж байдгийг анхаарна. Үүнд иргэний нийгэмд нөлөөлж буй техникийн, санхүүгийн эсхүл бусад саад бэрхшээлийг анхааралдаа авсан болохыг түүнчлэн, чадавхижуулах эсхүл нөөцөд нэвтрэх боломжийг хангах зэргээр тэрхүү саад бэрхшээлийг шийдвэрлэх төлөвлөгөөг хэлэлцэн зөвшилцөх болон/эсхүл хэрэгжүүлсэн болохыг нотлох нотолгоо орно.

2.5 Олон нийтийн шийдвэр гаргахад оролцох:

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 5: Протокол: Иргэний нийгмийн оролцоо

Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ил тод байдал болон байгалийн баялгийн засаглалын асуудлаар чөлөөтэй ярих, ОУИТБС-ын олон нийтийн хэлэлцүүлэгт оруулсан хувь нэмрийг баталгаажуулах боломжтой байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл болон баталгаажуулагчид нь дараах зүйлийг анхаарна:

- Иргэний нийгмийн төлөөлөгчид нь ОУИТБС-ын үйл ажиллагаа болон үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэхээр иргэний нийгмээс зохион байгуулсан эсхүл оролцоотой олон нийтийг хамарсан үйл явдлууд, сургалт семинар, бага хурлаар дамжуулан олон нийтийн хэлэлцүүлгийг хөхүүлэн дэмжих зорилгоор ОУИТБС-ын үйл ажиллагааг ашиглах боломжтой байх.
- Иргэний нийгмийн төлөөлөгчид нь байгалийн баялгийн асуудлаар дүгнэлт, өмгөөлөл гаргах, ОУИТБС-ын мэдээллийг ашиглах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, ОУИТБС-ын тайлангийн үр дүнг түгээх хэрэгслийг хөгжүүлэх гэх мэт байгалийн баялгийн засаглалын талаарх үйл ажиллагаа болон хэлэлцүүлэгт оролцох боломжтой байх.

2.6 Баримт бичиг

ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцсон Олон талт оролцогчдын бүлэг болон иргэний нийгмийн байгууллагуудаас баримт бичиг болон холбогдох оролцогчидтой, Олон талт оролцогчдын бүлгийн гишүүд орно гэхдээ тэдгээрээр хязгаарлагдахгүй, хийсэн шууд зөвлөгөөний үр дүнг авах боломжийг дээр дурдсан нотолгоог цуглуулах явцад анхааралдаа авна. Агуулгын зорилгоор ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь дээр дурдсан 2.1-2.5 дугаар заалтад дурдсан асуудлуудад хамаатай үзүүлэлт эсхүл бусад төрлийн үнэлгээ гэх мэт ОУИТБС үйл ажиллагаа явуулдаг өргөн хүрээг хамарсан орчинг хянан шалгана.

3. Иргэний нийгмийн төлөөлөгчид тавих түр хориг

- 3.1 ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнууд дахь иргэний нийгмийн төлөөлөгчдөд өгөх түр мэдэгдэл, тавьж болзошгүй эсхүл тавих хоригийг эхлээд Олон талт оролцогчдын бүлэг хэлэлцэн, анхааралдаа авах ёстой. Ийнхүү хийхдээ дотооддоо тэрхүү асуудлыг шууд гаргаж тавихтай холбогдуулан нөлөөлөлд өртсөн талд учирч болох аюулгүй байдлыг хангана.
- 3.2 Өөрийн Шуурхай хариу арга хэмжээний хороогоороо дамжуулан тусгай хэргүүдийг хянан шалгах, ОУИТБС-ын зарчмууд болон зохистой бол шаардлагуудын зөрчсөн тохиолдолд анхаарлаа хандуулахыг ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс шаардах буюу хүсэж болно. ОУИТБС-ын Удирдах зөвлөл тэрхүү хүсэлт буюу шаардлагыг тухайн тохиолдол эсхүл хэргийн бодит баримт, ОУИТБС-ын зарчмуудыг хөхүүлэн дэмжих хэрэгцээ шаардлага, улс орнууд хоорондын тогтмол харьцааны зарчимтай холбон анхаарна. Хэсэг 4, зүйл 8.(а) дээр “ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн орны хувьд санаачилгын зарчим, шаардлагыг даган мөрдөх дээр асуудал үүссэн хэмээн үзвэл тухайн орны хэрэгжилтийн нөхцөл байдлын тухай мэдээлэл цуглуулан, ОУИТБС-ын Удирдах зөвлөлд тайлагнахыг Олон улсын нарийн бичгийн газарт даалгаж болно”. Иргэний нийгмийн оролцоотой холбоотой асуудлыг гаргаж тавих тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын үйл ажиллагаанд шууд нэвтрэх холбоос байгаа эсэхийг олж тогтоохыг эрмэлзэнэ. Үүнд (i) тухайн хэргийн бодит байдлыг баримтжуулах; (ii) оролцогчдын санал бодлыг авах; (iii) дээрх 2 дугаар хэсэгт дурдсан шалгуурыг ашиглах орно.
- 3.3 Гаргаж тавьсан асуудлууд болон ОУИТБС-ын үйл ажиллагаа хооронд шууд холбоос байгааг олж тогтоох боломжтой байхыг оролцуулаад тухайн нөхцөл байдлыг харгалзан Удирдах зөвлөл нь тохирох хариуг өгнө. Үүнд ОУИТБС-ын Тэргүүн эсхүл Удирдах зөвлөлөөс холбогдох Засгийн газар, тухайн улс орны ОУИТБС-ын Удирдах хороо эсхүл Олон улсын нарийн бичгийн газрын суурин төлөөлөгчийн газарт албан бичиг хүргүүлэх, хараат бус үнэлгээг хийх ажлыг хариуцуулах, Удирдах зөвлөлийн мэдэгдлийг гаргах, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг авах засаж залруулах арга хэмжээг тохиролцох, улс орон нь холбогдох шаардлагыг хангасан болохыг баталгаажуулах гэх мэт орно.
- Хэсэг 4, 8.а дээр заасны дагуу буюу хэрэгжүүлэгч орон нь ОУИТБС-ын үндсэн зарчим, шаардлагын ач холбогдол бүхий талыг даган мөрдөөгүй болох нь тодорхой болсон тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн орныг эрхийг түдгэлзүүлэх эсвэл жагсаалтаас хасна.
- Удирдах зөвлөл нь ажиглагдсан асуудлууд нь шаардлагыг зөрчөөгүй эсхүл ОУИТБС-ын үйл ажиллагаатай хангалттай холбогдоогүй гэж үзвэл Удирдах зөвлөл нь өөрийн үзэмжээр ОУИТБС-ын зарчмуудыг хөхүүлэн дэмжих хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавин арга хэмжээ авах болон улс орнууд хоорондын тогтмол харьцааг хангах эсэхээ шийднэ.

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 6: ОУИТБС-ын холбооны ёс зүйн дүрэм

БҮЛЭГ 6

ОУИТБС-ЫН ХОЛБООНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Энэ хэсэгт ОУИТБС-ын албаны хүмүүсийн зан үйлийг удирдан чиглүүлдэг зарчим, стандартуудыг тусгасан болно.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл 2014 оны гуравдугаар сард Ёс зүйн дүрмийг баталж, 2022 оны арванхоёрдугаар сард

шинэчилсэн найруулгыг баталсан.

Энэхүү Ёс зүйн дүрэм нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн бүх гишүүд, тэдгээрийн орлогчид, ОУИТБС-ын Холбооны гишүүд, нарийн бичгийн газрын ажилтнууд (үндэсний болон олон улсын), олон талт бүлгийн гишүүдэд хамаарна.

1-р зүйл: Хамрах хүрээ

Бүх ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүд, тэдний орлогчид, ОУИТБС-ын Холбооны гишүүд, Ажлын албаны ажилтнууд (үндэсний болон олон улсын), Олон талт оролцогчдын бүлгүүдийн гишүүд (цаашид “ОУИТБС-ын албан ажилтнууд” гэх) нь энэхүү Ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.

2-р зүйл: Хувийн зан чанар, шударга байдал ба үнэ цэнэ

ОУИТБС-ын албан ажилтнууд нь үнэнч байдал, ёс зүйн дүрмийн өндөр стандартыг мөрдөж ажиллах ба шударга бөгөөд эелдэг байна. ОУИТБС-ын албан ажилтнуудын хувийн болон мэргэжлийн байдал нь ямагт хүндэтгэлтэй хандах болон ил тод байдал, хариуцлагын олон улсын стандартыг хөхүүлэн дэмждэг. Холбооны албан ажилтнуудын хувьд статустаа итгэлтэй байхыг шаарддаг бөгөөд ОУИТБС-ын сайн засаглалд хувь нэмрээ оруулах ёстой. ОУИТБС-ын албан ажилтнууд нь үлгэр жишээ үзүүлэх замаар өөрсдийгөө зориулах ба ОУИТБС-ын ашиг сонирхол, эрхэм зорилгыг үнэнчээр, тууштайгаар, хичээнгүйгээр болон тэдний шударга байдал болон ОУИТБС-ын шударга байдалд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалах, сайжруулах байдлаар итгэлтэйгээр болон ОУИТБС-тай тогтоосон холбоо нь ямагт нэр төртэй байхыг баталгаажуулан төлөөлөх ёстой.

ОУИТБС-ын албан ажилтанууд ОУИТБС-ыг төлөөлөх, түүнчлэн Засгийн газар, үйлдвэрлэл, иргэний нийгмийн тус тусын ашиг сонирхлыг илэрхийлэх хоёрдмол үүрэг гүйцэтгэдэг болохыг хүлээн зөвшөөрч, олборлох салбарын засаглалын талаар олон нийтэд мэдээлэлтэй мэтгэлцээн явуулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, ОУИТБС-ын Төлөөлөгчид лоббидох үйл ажиллагаа зэрэг аливаа үйлдлээс татгалзах нь зүйтэй доорх 3 дугаар зүйлийг зөрчсөн

3-р зүйл: Даган мөрдөлт

ОУИТБС-ын албан ажилтанууд ОУИТБС-ын дүрэм, ОУИТБС-ын Зарчмууд, ОУИТБС-ын Стандарт болон ОУИТБС-ын бодлогод нийцүүлэн холбогдох үндэсний хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ОУИТБС-ын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ.

4-р зүйл: Бусдыг хүндэтгэх

ОУИТБС-ын албан ажилтнууд нь нэр хүнд, ОУИТБС-тай холбоотой хэрэгцээ шаардлага болон бусдыг хувийн амьдралыг хүндэтгэх бөгөөд хамт олон, ОУИТБС-ын бусад удирдах байгууллагын гишүүд, ажилтан гишүүд, олон нийт болон ОУИТБС-д ажил үүрэг гүйцэтгэх хугацаанд тэдэнтэй холбоо тогтоосон аливаа этгээдтэй зүй зохистой, ухаалаг харьцана.

5-р зүйл: Мэргэшсэн байх

ОУИТБС-ын албан ажилтнууд нь ажил үүргээ мэргэжлийн түвшинд болон цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх бөгөөд ур чадвараа хөгжүүлэх, ОУИТБС-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг дэмжих үйл ажиллагаанд тогтмол оролцоход өөрсдийн бүх хүчин чармайлтаа дайчлах ёстой.

6-р зүйл: Үл ялгаварлах

ОУИТБС-ын албан ажилтнууд нь ОУИТБС-д хөдөлмөр эрхлэх хугацаандаа тэдэнтэй холбоо тогтоосон хувьд түүнд задруулсан болон олон нийтэд ил тод болгоогүй аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр ашиглахгүй. ОУИТБС-ын албан ажилтанууд ОУИТБС-ын Нээлттэй байдлын бодлого болон ОУИТБС-ын хороодын ОУИТБС-ын Ажиглагчийн бодлогод заасан нууцлалыг хүндэтгэх ёстой. ОУИТБС-ын албан ажилтнуудын хувьд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш 2 жилийн хугацаанд энэхүү үүрэг нь заавал биелүүлэх хуулийн хүчинтэй хэвээр байна.

7-р зүйл: Нууцыг хадгалах

ОУИТБС-ын албан ажилтнууд нь түүний ажил үүрэгт дэмжлэг болохоос бусад тохиолдолд албанажилтны хувьд түүнд задруулсан болон олон нийтэд ил тод болгоогүй аливаа мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр ашиглахгүй. ОУИТБС-ын албан ажилтанууд ОУИТБС-ын Нээлттэй байдлын бодлого болон ОУИТБС-ын хороодын ОУИТБС-ын Ажиглагчийн бодлогод заасан нууцлалыг хүндэтгэх ёстой. ОУИТБС-ын албан ажилтнуудын хувьд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш 2 жилийн хугацаанд энэхүү үүрэг нь заавал биелүүлэх хуулийн хүчинтэй хэвээр байна.

8-р зүйл: ОУИТБС-ын нөөцийн зарцуулалт, өмч хөрөнгийн ашиглалт

ОУИТБС-ын албан ажилтнууд нь мөнгөний үнэ цэнийн зарчмыг хүндэтгэх бөгөөд ОУИТБС-д зориулах санхүүжилтийн зарцуулалтыг хариуцана. Ямар ч ОУИТБС-ын албан ажилтан ОУИТБС-ын өмч хөрөнгө эсхүл нөөцийг урвуулан ашиглахгүй бөгөөд ямагт ОУИТБС-ын өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж ажиллан, зохих ёсоор эрх олгогдоогүй аливаа этгээдэд тэрхүү өмч хөрөнгийг эзэмших, ашиглахыг зөвшөөрөхгүй.

ОУИТБС-ын албан ажилтнууд нь зөвхөн аялалын бодит зардал, үйл ажиллагааны эсхүл ОУИТБС-ын албан ажилтны хувьд ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой гарах бусад зардлыг нэхэмжилнэ. Өдөр тутмын төлбөр бус бодит зардлаар тооцохыг илүүд үздэг. ОУИТБС-ын албан ажилтнууд нь зөвхөн бүрэн ил тод болгон, ОУИТБС-ын Удирдах зөвлөл эсхүл ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг урьдчилан зөвшөөрсний дараа ОУИТБС-ын төлбөрт ханган нийлүүлэгчийн хувиар ОУИТБС-д бараа бүтэгдэхүүн нийлүүлэх эсхүл, үйлчилгээ үзүүлнэ.

9-р зүйл: Ашиг сонирхлын зөрчил, албан тушаалаа урвуулан ашиглах

ОУИТБС-ын албан ажилтнууд нь ямагт хувийн чанартай ашиг тус, санхүүгийн дэвшил гэх мэт ашиг сонирхлын төлөө бус ОУИТБС-ын ашиг сонирхлын төлөө ажиллана.

ОУИТБС-ын албан ажилтнууд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийнэ. Энэхүү дүрмийн зорилгоор ашиг сонирхлын зөрчил гэдэг нь ОУИТБС-ын албан ажилтнуудын ашиг сонирхол нь тэдний ОУИТБС-ын албан ёсны ажил үүргийн зорилго болон хараат бус гүйцэтгэлд нөлөөлөх эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг хэлнэ. Үүнтэй холбогдуулан хувийн ашиг сонирхолд тэдний өөрсдийн, гэр бүлийн эсхүл хувийн шугамаар мэдэх танил талуудын олж авах давуу тал орно. ОУИТБС-ын албан ажилтнууд тэрхүү нөхцөл байдалд орсон бол өөрсдөө татгалзах бөгөөд ОУИТБС-ын Удирдах зөвлөл эсхүл Олон талт оролцогчдын бүлэгт тэрхүү татгалзалын талаар мэдэгдэх ёстой. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүдийн хувьд ОУИТБС-ын Дүрмийн 5.6 дугаар зүйлд дурдсан журам хамаарна.

Ялангуяа, ОУИТБС-ын албан ажилтнууд нь эдгээр удирдамжийг мөрдөнө:

- Өөрийн хувийн ашиг сонирхол эсхүл гуравдагч талын ашиг сонирхлыг ОУИТБС-с дээгүүр тавихаас зайлсхийх (болон тавьсан харагдахаас зайлсхийх). Хүлээн авсан хувийн эсхүл гуравдагч талын тохиолдлын шинжтэй ашиг тус нь зарим нэг ОУИТБС-тай холбоотой үйл ажиллагаанаас ирсэн бол тэрхүү ашиг тус нь зөвхөн ОУИТБС болон түүний зорилгын хувьд чухал ашиг тус болох ёстой. Тогтоосон, төлсөн, хүлээн авсан аливаа томилолтын зардал нь үндэслэлтэй бодит зардал болон олон улсын шилдэг практикт тулгуурласан байна
- Олгогдсон эрх мэдлийг хэтрүүлэн ашиглахаас зайлсхийх. Хэрэг эрхлэх газрын ажилтнууд нь хувийн эсхүл гуравдагч этгээдийн сэтгэл ханамж, ашиг сонирхлын зорилгоор ОУИТБС-ын Холбоо эсхүл ОУИТБС-ын ажилтнууд, үйлчилгээ, тоног төхөөрөмж, нөөц, өмч хөрөнгийг зүй бусаар ашиглан ОУИТБС-ын албыг урвуулан ашиглахгүй. ОУИТБС-ын албан газрын ажилтнууд нь тус газрын ажилтны хувьд олгогдсон эрх мэдлийг хэтрүүлэн гуравдагч талуудад төлөөлөхгүй;
- ОУИТБС-д шууд, шууд бусаар материаллаг сөрөг нөлөө үзүүлэхүйц аливаа гадны хувийн чанартай үйл ажиллагаанд оролцохгүй.

10-р зүйл: Бэлэг сэлт, аялал зугаалга, үзвэр үйлчилгээ

ОУИТБС-ын ажилтнууд нь аливаа этгээд эсхүл аж ахуйн нэгжийг ОУИТБС-тай холбоотой асуулалтай холбогдуулан тэрхүү донорыг тусгайлан авч үзэх шууд, шууд бус хээл хахууль, авчирч болох эсхүл тэгж ойлгогдох бэлэг сэлт, талархал, үнэ төлбөргүй аялал, мөнгөн шагнал, хувийн эд зүйлс, бусад үнэт зүйлсийг өгөхийг ятгахгүй эсхүл хүлээн авахгүй.

ОУИТБС-ын ажил үүргийг гүйцэтгэхтэй шууд, шууд бус холбоотой бэлэг сэлт авах, санал болгох, үнэ төлбөргүй аялал эсхүл 100 ам.доллараас илүү гарсан үнийн дүнтэй бусад нөхөн олговрыг ОУИТБС-ын Удирдах зөвлөл эсхүл холбогдох ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг (олон улсын эсхүл үндэсний нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан)-т мэдэгдэх ёстой. Их хэмжээний бэлэг сэлт санал болгох, хүлээн авахаас татгалзана. Бэлэг сэлт их хэмжээтэй эсэх талаар эргэлзээ төрөх үед ОУИТБС-ын Нарийн бичгийн газар эсхүл Олон талт оролцогчдын бүлэгтэй зөвлөлдөнө. Ялангуяа, тэрхүү татгалзал нь донорыг эвгүй байдалд оруулж болох нь батлагдсан тохиолдолд саналаас татгалзах нь зохисгүй үйлдэл. Иймд бэлэг сэлтээс ОУИТБС-ын Нарийн бичгийн газар эсхүл Олон талт оролцогчдын бүлэг татгалзана.

11-р зүйл: Хэрэгжилт

ОУИТБС-ын Удирдах зөвлөл, холбогдох ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг, олон улсын эсхүл үндэсний ажлын албад нь ОУИТБС-ын албанажилтнуудад энэхүү Ёс зүйн дүрмийг танилцуулах, шаардлагатай бол зөвлөгөө өгөх, Дүрмийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах үүрэгтэй. ОУИТБС-ын Олон талт оролцогчдын бүлгүүдийг оролцуулаад ОУИТБС-ын албан ажилтнуудад энэхүү Дүрмийг танилцуулах үүрэгтэй этгээдүүд нь жил бүр ОУИТБС-ын албан ажилтнууд нь Дүрэмтэй танилцсан тухай болон хэрэгжилтийн талаар Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарар дамжуулан

2023 ОУИТБС-ын СТАНДАРТ
ХЭС 1: Зарчим ба шаардлага
Бүлэг 6: ОУИТБС-ын холбооны ёс зүйн дүрэм

ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд танилцуулна.

12-р зүйл: Тайлагнах/мэдээлэх

Энэхүү Дүрмийг тайлбарлах, хэрэгжүүлэх, зөрчихэй холбоотой асуудлыг хариуцан ажилладаг ОҮИТБС-ын албан ажилтнууд болон оролцогч талууд тэрхүү асуудлуудыг санаа зовнилоо илэрхийлэх тухай ОҮИТБС-ын бодлогын дагуу ОҮИТБС-ын удирдлагад даруй танилцуулна. Санаа зовнилоо илэрхийлэх бодлогын дагуу асуудлыг ОҮИТБС-ын Удирдах зөвлөлийн анхааралд оруулсан тохиолдолд ОҮИТБС-ын Удирдах зөвлөл нь нөхцөл байдлыг авч үзэж, ОҮИТБС-ын дүрэм, ОҮИТБС-ын зарчим, ОҮИТБС-ын стандарт, ОҮИТБС-ын бодлогын дагуу арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг авч үзнэ.

Тэрхүү асуудлуудыг ОҮИТБС-ын удирдлагад даруй танилцуулах нь асуудал үүсгээд байгаа аливаа этгээдийн хувьд асуудлуудыг өөрсдийн Засаглалын хороо болон хорооны даргаар дамжуулан ОҮИТБС-ын Удирдах зөвлөлд санаа зовнилоо илэрхийлэх талаар ОҮИТБС-ын бодлогод нийцүүлэн танилцуулж болно.

2023 ОҮИТБС-ын СТАНДАРТ

ХЭСЭГ 1: Зарчим ба шаардлага

Бүлэг 6: ОҮИТБС-ын холбооны ёс зүйн дүрэм

БҮЛЭГ 7

Нээлттэй мэдээллийн бодлого

Энэ хэсэгт ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын нээлттэй мэдээллийг нийтлэх зөвлөмжийг тусгасан болно.

Удиртгал

1. Энэхүү бодлого нь үндэсний хэмжээнд ОҮИТБС-ын хэрэгжилтийн харилцан тохирсон цар хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан. Энэхүү бодлого нь Шаардлага 7 дээрх нээлттэй мэдээлэлтэй хамаарах шаардлагуудыг нэмэлтээр нөхвөрлөж өгнө. Бодлого нь

- үндэсний хэмжээний хэрэгжилтээс гарсан сургамжууд болон олон улсын сайн туршлага⁵ дээр суурилсан бөгөөд, системтэй ил тод болгохыг хөхиүлэн дэмждэг.
2. ОУИТБС-ын зарчимд “Улсын төсвийн орлого, зарлагын талаарх олон нийтийн ойлголт нь тогтвортой хөгжлийн төлөө бодитой, оновчтой шийдлүүдийн талаар нийтээр хэлэлцэж, мэдээлэхэд тусалж чадна” (Зарчим 4) гэж тунхагладаг. Иймд ОУИТБС-ын стандарт нь ОУИТБС-ын тайлангуудыг иж бүрэн, ойлгомжтой байж, үүнийг идэвхтэйгээр түгээн сурталчилж, олон нийтэд нээлтэй байлгаж, олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулж байхыг шаарддаг (ОУИТБС-ын 7.1 дүгээр шаардлага). ОУИТБС-ын мэдээллийн хүртээмж, найдвартай байдал, цаг хугацаат байдал, хамааралтай байдал болон харьцуулагдах байдал нь эдгээр зорилтуудад хүрэхэд чухал үүрэгтэй.
 3. ОУИТБС-ын зарчмуудыг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд туслахын тулд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь Засгийн газар болон компанийн үйл ажиллагааны хүрээнд, тэдний системээр дамжуулан мэдээллийг ил тод болгох нь хамгийн доод шаардлага хэмээн тогтоосон. ОУИТБС нь тайлан гаргагч байгууллагуудын зүгээс үндэсний хэмжээнд, нээлттэй форматаар, ОУИТБС-ын хэрэгжилтийн харилцан тохирсон байнгын үйл ажиллагааны хүрээнд ил тод болгохыг хөхиүлэн дэмждэг.
 4. ОУИТБС нь хэрэгжүүлэгч улс орон бүхийн нөхцөл байдал ялгаатай болохыг хүлээн зөвшөөрч, улс бүр ижил хурдтайгаар нээлттэй мэдээлэлд шилжих боломжгүй, санхүүгийн нөлөөллийг богино болон урт хугацаанд нь харгалзан үзэх шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрдөг. Олон нийтийн зүгээс ирж буй шахалт болон төрийн бодлогын асуудлуудад дата өгөгдөл ашиглах хэрэгцээг харгалзан үзэх ёстой⁶. Хүртээмжид тулгарч буй сорилтууд болон төрөл бүрийн жендер болон иргэдийн дэд бүлгийн мэдээллийн хэрэгцээг мөн харгалзах ёстой.

Нээлттэй мэдээллийн зорилтууд

5. ОУИТБС-ын хэрэгжилтийн нээлттэй мэдээлэл нь төр болон бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, тухайн улс орны байгалийн баялгийг хэрхэни удирдаж буй талаарх мэдлэгийг нэмэгдүүлдэг. Энэ нь мөн олборлох салбарыг хэн эзэмшиж буй, хэн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй, хамаарах санхүүгийн нөхцөл нь ямар болох, олборлох үйл ажиллагаанаас ямар орлогыг олж, зарцуулж буй тухай мэдээлэлд гэрэл тусган өгдөг. Ийнхүү ил тод болгох нь мөнгө хөрөнгийг хамгийн өндөр үр дүнтэй ашиглах, зарцуулахад түлхэц болж өгдөг.
6. Цаг хугацаандаа гарсан, сайн чанартай, оролцогч талуудын хэрэгцээ болон хүлээлтэд нийцсэн буй үедээ нээлттэй мэдээлэл нь үр дүнтэй, ашигтай байдаг. ОУИТБС-ын хэрэгжилт нь хариуцлагатай байдал болон сайн засаглалыг дэмжиж, төрийн хариуцлагатай байдлыг сайжруулах замаар авлигатай тэмцэж, төрийн үйлчилгээг сайжруулдаг. Иж бүрэн мэдээллийн хүртээмжийг хангах нь хувь хүмүүс, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, болон бизнес эрхлэгчдийг хүчирхэгжүүлж, өөрийн хүлээн авч буй үйлчилгээ, хүлээх стандартын талаар мэдээлэлтэйгээр шийдвэр гаргахад илүү тустай байдаг. Нээлттэй мэдээлэл нь мөн бодлого боловсруулах үйл ажиллагаа, салбарын удирдлагыг сайжруулахад төр, үнэ цэнтэй арга зүй болж өгнө.
7. Мэдээллийн чөлөөтэй хүртээмж, дахин ашиглах боломж нь нээлттэй мэдээллийг нийгэм болон эдийн засагт ихээхэн үр цэнтэй зүйл болгож байдаг. Энэ нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй орнуудад Олон талын оролцоот бүлэгт мэдээллийн үнэ цэнтэй эх сурвалж байна.
8. Шинээр гарч буй өгөгдлийн стандарт нь өгөгдлийг харилцан дэмжиж ажиллах боломжтой болгоход хувь нэмэр оруулна. Мэдээллийн/өгөгдлийн стандартыг⁷ батлан гаргах нь мэдээллийг хэвлэн нийтлэх үйл ажиллагааны тогтвортой байдалд хувь нэмэр оруулж, төр, иргэний нийгэм болон салбарын одоогийн арга хэрэгсэл, эх сурвалжаар дамжуулан өгөгдлийг бэлтгэх, нийтлэх чадавхад дэмжлэг үзүүлж, мөн стандартуудыг нарийн тогтоосон, үүнийг дагаад хэрэглэгчид үүсэн бий болсон бол мэдээллийн хэрэглээ болон дүн шинжилгээ хийхэд ч дэмжлэг болдог.

ОУИТБС-ын хэрэгжилт дэх нээлттэй мэдээлэл/өгөгдөл

9. ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнууд нь дараах зүйлсийн даган мөрдөхийг дэмжинэ:
 - a) Нээлттэй мэдээллийн бодлого болон стратегийн дагуу ОУИТБС-ын хүрээнд тайлан гаргаж буй байгууллагуудын мэдээллийг системтэйгээр, цаг тухайд нь, иж бүрнээр ил тод болгох, мэдээлэл түгээх зардлын үр ашигт байдал болон хүртээмжийг хангах;
 - b) Хэрэглэгчидтэй⁸ хамтран ажиллаж тэргүүлэн ач холбогдол бүхий багц дата болон түгээлтийн хэлбэрийг тогтоон гаргах;
 - c) Олон янзын хэрэглэгчдийн хэрэгцээг, хүртээмжийн саад сорилтуудыг жендер, үндэснийбүлэг,

⁵ Үүнд Нээлттэй Засгийн түншлэл, G8-ын нээлттэй мэдээллийн дүрэм ба техникийн хавсралт, Нээлттэй мэдээллийн дүрэм, Нээлттэй тодорхойлолт, мэдээллийн стандартыг боловсруулахад зориулсан World Wide Web Consortium (W3C) багтана.

⁶ Хамгийн гол нь "зорилготойгоор нийтлэх" нь мэдээллийн нийтлэлийг бодлогын тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд шингээх ёстой гэсэн үг.

⁷ Жишээ нь Нээлттэй өмчлөх эрх (огноогүй), <https://standard.openownership.org/en/0.3.0/> сайтаас авсан "Бенефициар өмчлөлийн мэдээллийн стандарт"-ыг үзнэ үү; Нээлттэй гэрээ (огноогүй), "Нээлттэй гэрээний мэдээллийн стандарт", <https://standard.open-contracting.org> сайтаас авсан.

⁸ Хэрэглэгчид өөр агентлагийн мэдээллийг өөрийн үйлчилгээнд ашигладаг иргэд, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага болон бусад төрийн байгууллагуудад хандаж болно.

газар зүйн тархац зэргээр нь харгалзан үзэж байх;

d) Өгөгдөл мэдээллийг багцалсан байдлаар, машинд уншигдах форматаар, иж бүрэн тайлбартайгаар гарган өгснөөр хэрэглэгчид нь тухайн мэдээллийг давуу талууд, сул талууд, аналитик шинжилгээ хийхэд тулгарах хязгаарлалтууд, аюулгүй байдлыг шаардлагууд болон хэрхэн боловсруулалт хийх талаар хангалттай мэдээлэл авах боломжийг ханган өгөх;

e) Мэдээлэл өгөгдлийг аль болох эрт түгээж, хэрэглэгчид өөрийн саналыг ирүүлэх боломжийг хангах, улмаар нээлттэй мэдээллийн чанарын өндөр стандартыг хангахын тулд эргэн өөрчлөлт оруулж, сайжруулж байх;

f) Мэдээллийг нээлттэй тусгай зөвшөөрлийн хүрээнд боломжтой бол CC 4.0 тусгай зөвшөөрөлтэйгээр гарган хэрэглэгчид үнэ төлбөргүй авах, дахин ашиглах боломжийг хангах⁹;

g) Техникийн мэдлэг болон туршлагыг бусад оронтой хуваалцаж, нийгмийн хүртээмжтэй байдлаар нээлттэй мэдээллийн боломжийг нэмэгдүүлэх;

h) Нээлттэй мэдээллийн талаарх боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, аппликейшн хөгжүүлэгчид болон иргэний нийгмийн байгууллага зэрэг талууд, хүмүүсийг нээлттэй мэдээллийн хэрэгцээг түгээн дэлгэрүүлэх, нээлттэй мэдээллийн үнэ цэнийг бий болгох чиглэлээр ажиллахын урамшуулан дэмжих;

i) Мэдээлэл өгөгдөл нь үндэсний болон олон улсын стандарттай нийцэн, харилцан ажиллах боломжтой, үүнд ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн баталсан мэдээллийг стандартыг¹⁰, Олон улсын нарийн бичгийн газрын гаргасан нэмэлт зааварчилгааг баримтлах;

j) Боломжтой бүхий л тохиолдолд арилжааны болон төрийн байгууллага хоорондын мэдээллийг өвөрмөц, боломжит, нээлттэй үзүүлэлтээр харьцуулан шалгаж байх боломжийг хангах;

k) Нээлттэй мэдээллийг¹¹ түгээх болон ашиглах техникийн дэд бүтцийг харгалзан үзэх;

l) Нээлттэй мэдээллийн бодлогын засаглал болон тогтвортой байдлыг харгалзан, тайлан гаргаж буй байгууллагууд нь мэдээллийг хадгалах, ашиглах, аюулгүй байдлыг хангах бүтцийг нь бий болгох.

Нээлттэй мэдээллийн салбарыг оролцуулах, хамтран ажиллах

10. Төрийн нээлттэй мэдээллээс суралцах болон сайн туршлагыг бий болгох зорилгоор ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улсууд нь Нээлттэй мэдээллийн дүрэм¹² болон хамаарах бусад санаачилгуудыг батлан хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.
11. ОУИТБС-ын улс орнуудаас авсан сургамжуудаа дамжуулах, олон улсын туршлагаас суралцах



Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга


Улс орны байгалийн баялаг иргэдийнх гэдэгт
бид итгэдэг.

Бидний эрхэм зорилго бол байгалийн баялгийн
менежментийн талаарх ойлголтыг сурталчлах, төрийн
болон компанийн засаглалыг бэхжүүлэх, олборлох
салбарын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд
шаардлагатай мэдээллээр хангах явдал юм.



Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга

Газрын тос, байгалийн хий
болон ашигт малтмалын
баялгийн сайн засаглалын
дэлхий нийтийн стандарт



2023 ОҮИТБС-ын стандарт (Хэсэг 2)
2023 оны 6-р сарын 12-нд нийтлэгдсэн
© ОҮИТБС 2023

Энэ баримт бичгийг Үнэн зөвөөр, буруу мэдээлэл өгөлгүйгээр (логоноос бусад) ямар нэгэн формат хэлбэр эсвэл хэрэгслээр, үнэ төлбөргүйгээр хуулбарлан хэрэглэж, нийтлэн гаргаж болно. Тухайн материалын зохиогчийн эрхийг ОҮИТБС эзэмшдэг болохыг тусгаж, гарчиг болон эх сурвалжийг заавал дурдсан байна.

Хэвлэлийн эх болон дизайны зохиогчийн эрхийг ОҮИТБС
ЭЗЭМШИНЭ.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН СТАНДАРТ 2023

Газрын тос, байгалийн хий болон ашигт
малтмалын баялгийн сайн засаглалын
Дэлхий нийтийн стандарт

АГУУЛГА

Оршил

БҮЛЭГ 1: ОУИТБС-ын хэрэгжилт дэх Удирдах Зөвлөлийн хяналт

- 1-р зүйл: Тохируулан өөрчилсөн хэрэгжилт
- 2-р зүйл: Ил тод болгох болон тайлагнах тогтоосон хугацаа.
- 3-р зүйл: Анхдагч баталгаажуулалтын хугацаа
- 4-р зүйл: ОУИТБС-ын баталгаажуулалтын үйл явц
- 5-р зүйл: Хамгаалалт
- 6-р зүйл: Баталгаажуулалтын үр дүн
- 7-р зүйл: Сунгалт
- 8-р зүйл: Түдгэлзүүлэх
- 9-р зүйл: Жагсаалтаас (гишүүнчлэлээс) хасах
- 10-р зүйл: Давж заалдах

БҮЛЭГ 2: Баталгаажуулалтын тойм

- 1-р зүйл: Баталгаажуулалтын зорилго
- 2-р зүйл: Баталгаажуулах аргачлал
- 3-р зүйл: Баталгаажуулах журам

Оршил

Энэхүү баримт бичиг нь ОУИТБС-ын Стандартын 2-р хэсгийг ("ОУИТБС-ын Зөвлөлийн хяналт ба баталгаажуулалт") багтаасан бөгөөд ОУИТБС-ын олон улсын зөвлөл ОУИТБС-ын стандартын хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж, үнэлдэгийг тодорхойлдог журам, шалгуурыг тодорхойлсон.

ОУИТБС-ын олон улсын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын шийдвэр гаргах гол байгууллага юм. Энэ нь байгууллагын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, ОУИТБС-ын стандартад нийцсэн улс орнуудын ахиц дэвшлийг үнэлдэг. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь улс орнууд (хэрэгжүүлж, дэмжигч), дэмжигч компаниуд болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл болсон 20 төлөөлөгч, тэдгээрийн орлогч болон УЗ- даргаас бүрдсэн олон талын оролцоот бүлэг юм. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн шийдвэр нь зөвшилцөлд тулгуурладаг. Аливаа шийдвэрийг Удирдах зөвлөл жилд хоёроос дөрвөн удаа хуралдаж байж мөн Удирдах зөвлөлөөр дамжуулан гаргадаг. ОУИТБС нь хэрэгжүүлэгч дэлхийн бүх улс орнуудад нэгэн ижил стандартыг баримталдаг. ОУИТБС-ын чанарын баталгаажуулалтын механизм болох Баталгаажуулалтаар дамжуулан хэрэгжүүлэгч улс орнууд ОУИТБС-ын стандартын заалтуудыг хангаж чадаж буй эсэхийг үнэлдэг. Баталгаажуулалт нь улс орны түвшинд яриа хэлэлцээ, суралцах үйл ажиллагааг дэмжин, улс орнуудад ахиц дэвшлийг мэдээлэх, ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх боломжийг олгодог. Энэ нь оролцогч талуудын санаа бодлыг тусган авч, ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, тогтвортой байдлын талаарх өөрсдийн хэтийн төлөвийг тодруулах боломжийг улс орнуудад олгодог. Улс орнууд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд өөр өөр эхлэх цэгүүдтэй бөгөөд янз бүрийн сорилтуудтай тулгардаг бөгөөд олборлох салбарын засаглалыг сайжруулахад хамгийн тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхийн тулд ОУИТБС-ыг ашиглах болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

ОУИТБС-ын стандартын 1-р хэсэг ("Зарчмууд ба шаардлага") нь ОУИТБС-ын үндсэн зарчмууд, түүнчлэн ОУИТБС-д оролцогч талуудад тавигдах шаардлага, хүлээлтийг тодорхойлсон. 3-р хэсэг ("ОУИТБС-ын засаглал ба удирдлага") нь ОУИТБС-ын холбоог хэрхэн удирддаг талаар тусгасан болно.

ОУИТБС-ын төрөл бүрийн асуудлуудыг хэрэгжүүлэх удирдамжийн хамт ОУИТБС-ын стандартыг бүрэн эхээр нь авахын тулд ОУИТБС-ын вэбсайтыг (www.eiti.org) ашиглаж болно.

БҮЛЭГ 1

ОУИТБС-ын хэрэгжилт дэх Удирдах Зөвлөлийн хяналт

Энэхүү бүлэгт ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь санаачилгын хэрэгжилтэд хяналт тавих эсвэл баталгаажуулах зорилгоор ашигладаг журам болон шалгууруудыг багтаасан. Үүнд ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн тогтоосон ОУИТБС-ын мэдээллийг хэвлэн нийтлэх хугацаа болон болон баталгаажуулалтын үйл явцын хяналт багтана.

1 дүгээр зүйл: Тохируулан өөрчилсөн хэрэгжилт.

Олон талт оролцогчдын бүлэг нь зайлшгүй нөхцөл байдлын улмаас ОУИТБС-ын стандарт шаардлагыг дагаж мөрдөх боломжгүй эсвэл өөрчлөлт хийх хэрэгтэй гэж үзвэл юуны өмнө ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хандан хэрэгжилтийг тохируулан өөрчлөх зөвшөөрөл авах ёстой. Уг хүсэлтийг Олон талт оролцогчдын бүлгээр батлуулсан байх бөгөөд ажлын төлөвлөгөөнд тусгасан байх ёстой. Мөн түүнчлэн энэхүү хүсэлтэд хэрэгжилтийг тохируулан өөрчлөх болсон шалтгааныг тайлбарласан байх ёстой.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь зөвхөн онцгой нөхцөл байдалд уг өөрчлөлтийг хийхийг зөвшөөрөх боломжийг судлан үзнэ. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ийм хүсэлтийг авч үзэхдээ нь улс орнуудыг харьцуулах байдлаар судлах ба ингэхдээ ОУИТБС-ын зарчмуудыг хангалттай баримталсан эсэх, ОУИТБС-ын тайлан нь иж бүрэн, тайланд орсон мэдээлэл нь үнэн зөв эсэх, тайлан нь олон нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулах эсэхийг харгалзан үзэж шийднэ.

2 дугаар зүйл. Ил тод болгох болон тайлагнах тогтоосон хугацаа.

Хэрэгжүүлэгч улс орнууд нь тайлан, мэдээллийг цаг тухайд нь (Шаардлага 4.8) хэвлэн нийтэлж байх үүргийг хүлээнэ. Хэрэгжүүлэгч орнууд нь ОУИТБС-д нэгдсэн орон болсноос хойш 18 сарын дотор шаардсан мэдээллийг хэвлэн нийтлэх (үндсэндээ ОУИТБС-ын тайлан байдлаар) үүргийг хүлээнэ. Энэ хугацаанаас хойш ил тод болгон нийтэлж буй мэдээлэл нь хамгийн сүүлийн санхүүгийн тайланг өмнөх хоёр жилийн оройтоогүй мэдээллийг багтаасан ОУИТБС-ын тайланг хэвлэснийг буюу жишээ нь 2023 оны 12 дугаар сарын 31-ээр төгсгөл болж буй санхүүгийн жилийн мэдээлэл хамгийн оройдоо 2025 оны 12 дугаар сарын 31-ээс өмнө нийтлэгдсэн байна.

Хэрэв мэдээллийг тогтоосон хугацаанд багтаан ил тод болгоогүй бол тухайн орны гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ. Хэрэв тухайн мэдээллийг хугацаанаас хойш 6 сарын дотор ил тод болгосон нь хангалттай хэмээн үзвэл Удирдах зөвлөл нь түдгэлзүүлснийг зогсооно. Хэрэв мэдээллийг энэхүү зургаан сарын дотор хэвлэн нийтлэхгүй бол тухайн улс нь Шаардлага 4.8 дээр заасны дагуу мэдээллийг ил тод болгон нийтэлсэн хэмээн Удирдах зөвлөл үзэх хүртэл түдгэлзүүлсэн статус хэвээр үргэлжилнэ. Түдгэлзүүлсэн статус нэг жилээс дээш хугацаанд үргэлжлэх тохиолдолд Удирдах хороо нь тухайн улсыг гишүүнчлэлийн жагсаалтаас хасна.

3 дугаар зүйл. Анхдагч баталгаажуулалтын хугацаа.


ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь аль нэг улсыг элсүүлэн авахдаа 2.5 жилийн дотор баталгаажуулалтад хамрагдах хугацааг тогтоож өгнө. Энэхүү баталгаажуулалтын үр дүнгээс хамааран Удирдах зөвлөл нь дараагийн баталгаажуулалт хийгдсэн байх эцсийн хугацааг тогтооно (5 дугаар зүйл).

4 дүгээр зүйл. ОУИТБС-ын Баталгаажуулалтын үйл явц.

1. ОУИТБС-ын Шаардлага нэг бүрийн биелэлтийн үнэлгээ.

Хэрэгжүүлэгч улс орнуудын хэрэгжилт ОУИТБС-ын шаардлага тус бүрийг хангаж буй эсэхийг тогтоох зорилгоор Баталгаажуулалтыг хийнэ. Шаардлага тус бүрийг хангаж байгаа эсэхийг үнэлэхэд шаардагдах нотолгоо, үзүүлэлтийн төрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Баталгаажуулалтын удирдамжид дүрдсэн. ОУИТБС-ын шаардлага тус бүрийн хэрэгжилтийн түвшин болон баримтлалыг дараах тодорхойлолтын алинд хамаарахаар нь тодорхойлно: ОУИТБС-ын шаардлага бүрийг хангах ахиц дэвшлийг дараах хуваарийг

ашиглан үнэлж, холбогдох оноог өгнө.



Хүлээлтээс давсан (100 оноо). ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тухайн улс ОУИТБС-ын шаардлагыг хүлээлтээс давсан гэсэн дүгнэлт гаргахын тулд Баталгаажуулалтаар ОУИТБС шаардлагын “Хүлээгдэж буй” мөн “Урамшуулан дэмжинэ” хэмээх бүх хэсгийг хангасан болон шаардлагын өргөн хүрээг хамарсан зорилтуудыг Засгийн газрын болон компанийн систем тогтолцооны хүрээнд ил тод болгох замаар хангасан гэдгийг харуулсан байх шаардлагатай.

Бүрэн хангасан (90 оноо). Тухайн улс ОУИТБС-ын шаардлагыг бүрэн хангасан гэж ОУИТБС-ын Удирдах зөвлөл дүгнэхийн тулд уг шаардлагын өргөн хүрээний зорилт биелсэн, шаардлагаар нэхэгдсэн бүх асуудлыг шийдвэрлэсэн гэдгийг харуулах ёстой.

Дийлэнхийг хангасан (60 оноо). ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн улс орон ОУИТБС-н шаардлагын дийлэнхийг хангасан гэсэн дүгнэлт гаргахын тулд Баталгаажуулалтаар шаардлагын бүх томоохон хэсгүүдийг хангасан, шаардлагуудын өргөн хүрээг хамарсан зорилтууд биелэгдэж байгаа гэдгийг харуулах хэрэгтэй.

Дийлэнх сайжруулалтыг хангасан (75 оноо). ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тухайн улсыг сайжруулах замаар ОУИТБС-ын шаардлагын дийлэнх сайжруулалтыг хангасан гэж дүгнэхийн тулд тухайн улс ОУИТБС-ын шаардлагын дийлэнхийг хангасан гэж үнэлэгдсэн өмнөх Баталгаажуулалтаас хойш ахиц дэвшил гаргасан гэдгээ харуулах шаардлагатай.

Хэсэгчилэн хангасан (30 оноо). ОУИТБС-ын Удирдах зөвлөл тухайн улс ОУИТБС-ын шаардлагыг хэсэгчлэн хангасан гэж дүгнэхийн тулд Баталгаажуулалтаас уг шаардлагын чухал талууд хэрэгжээгүй, мөн уг шаардлагын өргөн хүрээний зорилго биелээгүй гэдгийг нотлох шаардлагатай.

Сайжруулалттай хэсэгчлэн хангасан (45 оноо). Тухайн улс ОУИТБС-ын шаардлагыг сайжруулалттай хэсэгчлэн хангасан гэж дүгнэхийн тулд ОУИТБС-ын шаардлагыг хэсэгчлэн хангасан гэж үнэлэгдсэн өмнөх Баталгаажуулалтаас хойш ахиц дэвшил гаргаснаа харуулах шаардлагатай.

Хангаагүй (0 оноо). ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн улс орон шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргахын тулд Баталгаажуулалтаар ОУИТБС-н шаардлагын бүх эсхүл бараг бүх хэсгүүдийг хангаагүй болон шаардлагын өргөн хүрээг хамарсан зорилтууд биелэгдээгүй гэдгийг харуулах хэрэгтэй.

2. Үр ашиг, тогтвортой байдлын үнэлгээ

ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, тогтвортой байдлын үүднээс нэг улсад нийтдээ тав хүртэлх нэмэлт оноо өгч болно. Үүнийг дараах таван үзүүлэлтээр хэмждэг.

- ОУИТБС-ын хэрэгжилт нь үндэсний хэмжээнд хамааралтай олборлох салбарын засаглалын сорилтуудыг шийддэг. Энэ үзүүлэлт нь ОУИТБС-ын стандартаас давсан хүчин чармайлтыг мөн хүлээн зөвшөөрдөг.
- Олборлох салбарын мэдээллийг нь Засгийн газар болон компанийн тайлангуудаар системтэйгээр ил тод болгодог.
- Олборлох салбарын засаглалд иргэдийн оролцоо, тэр дундаа нөлөөлөлд өртсөн ард иргэдийн оролцоог хангах таатай орчин бүрдэж байна.
- Олборлох салбарын мэдээлэл хүртээмжтэй бөгөөд дүн шинжилгээ, судалгаа, сурталчилгаанд ашиглагддаг.
- ОУИТБС-ын хэрэгжилсэнээр нь олборлох салбарын бодлого, практикт гарсан өөрчлөлтийг мэдээлэлдэг.


Баталгаажуулах үед тухайн улсын үзүүлэлт тус бүрд 0, 0.5 эсвэл 1 оноо өгнө. Үр ашиг, тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн үнэлгээг хийхэд шаардагдах нотлох баримтын төрлүүдийн талаар нарийвчилсан зааврыг Баталгаажуулалтын гарын авлагад тусгасан.

3. Ерөнхий үнэлгээ

Ерөнхий үнэлгээ нь бүрэлдэхүүн хэсгийн оноонуудаас бүрдэх ба эдгээр нь нийлээд нийт тоон оноог бүрдүүлдэг.

Бүрэлдэхүүн хэсгүүдийн оноог “Оролцогч талуудын оролцоо” (ОУИТБС-ын 1.1-1.4-р шаардлага), “Ил тод

байдал” (ОУИТБС-ын 2-6-р шаардлага) болон “Үр дүн ба нөлөөлөл” (ОУИТБС-ын 1.5 ба 7-р шаардлага) тус бүрээр тус тусад нь үзүүлэв. Бүрэлдэхүүн хэсгийн оноо нь холбогдох шаардлага тус бүрээр олгосон онооны дундажийг илэрхийлнэ. Үр ашиг, тогтвортой байдлын үзүүлэлтээр өгсөн оноог "Үр дүн ба нөлөө" гэсэн бүрэлдэхүүн хэсгийн оноон дээр нэмнэ.



Нийт оноо нь гурван бүрэлдэхүүн хэсгийн онооны дундаж юм. Ерөнхий үнэлгээг дараах хуваарийн дагуу чанарын тодорхойлолт дагалдуулсан тоон оноо хэлбэрээр үзүүлэв.



- **Маш өндөр:** Дундаж оноо 93 ба түүнээс дээш
- **Өндөр:** Дунджаар 85-92 оноо
- **Дунд зэрэг:** Дунджаар 70-84 оноо
- **Нэлээд бага:** Дунджаар 50-69 оноо
- **Бага:** 50- доош оноо

Баталгаажуулалт нь шаардлага, ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, тогтвортой байдлын үнэлгээнээс гадна дараахь зүйлийг баримтжуулна.

- **ОУИТБС-ын шаардлагаас давах хүчин чармайлт.** Үүнд ОУИТБС-ын стандартын “Хөхиүлэн дэмжсэн” эсхүл “Зөвлөмж болгосон” хэсгүүдэд анхаарлаа хандуулах Олон талт оролцогчдын бүлгийн хүчин чармайлт орно. Түүнчлэн, ОУИТБС-ын стандартын хамрах хүрээнээс гадуурх аливаа ажлын төлөвлөгөөний зорилгыг амжилттай хэрэгжүүлэх Олон талт оролцогчдын бүлгийн хүчин чармайлт орох ч гэхдээ Олон талт оролцогчдын бүлэг нь олборлох салбарын хувьд үндэсний нэн тэргүүний асуудалд анхаарахад ОУИТБС-д хэрэгтэй зорилго хэмээн тодорхойлоогүй байна. Эдгээр хүчин чармайлтын зорилго, бодит болон хүлээгдэж буй үр дүн, үр нөлөөг баримтжуулахыг олон талт бүлэгт уриалж байна.

Эдгээр хүчин чармайлт болон тэдгээрийн үр дүнг Баталгаажуулах үйл явцад баримтжуулах боловч Баталгаажуулалтын нэг хэсэг болгон үнэлэхгүй. Олон талын оролцогчдын бүлгээс өгсөн мэдээллийг үр ашиг, тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглаж болно.

- Ахиц дэвшлийн чиглэл нь ОУИТБС-ын шаардлагуудтай нийцсэн тухайн улсын өмнөх Баталгаажуулалттай харьцуулсан харьцуулалтаар хэрэгжилт сайжирч эсвэл муудаж байгааг харуулж байна. Үнэлгээний үр дүнг онооны хуудас болон үнэлгээний нотлох баримт, оролцогч талуудын үзэл бодол, лавлагаа, дүгнэлтийг харуулсан Баталгаажуулалтын тайланд баримтжуулна.

5 дугаар зүйл. Харгалзан үзэх

Хэрэв тухайн улс оролцогч талуудын оролцоотой холбоотой аливаа шаардлагыг (1.1, 1.2, 1.3-д заасан) хангасан эсвэл хангаагүй бол ОУИТБС-ын Удирдах зөвлөл 8 дугаар зүйлд заасны дагуу тус улсын үйл ажиллагааг түдгэлзүүлнэ.

Эхний баталгаажуулалтад тухайн улс Иргэний нийгмийн оролцооны талаарх Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Протоколтой холбоотой дутагдалтай байдлаас үүдэн иргэний нийгмийн оролцооны талаарх 1.3-т заасан шаардлагыг үндсэндээ дагаж мөрдвөл тухайн улс түдгэлзүүлэхгүй бөгөөд харин Удирдах зөвлөлөөс шаардсан засан залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр ахиц дэвшил гаргах боломжийг хангана. Дараагийн Баталгаажуулалтын явцад засч залруулах арга хэмжээний талаар ахиц дэвшил гаргахгүй бол 8 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлнэ.

6 дугаар зүйл. Баталгаажуулалтын үр дагавар

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн улсын дараагийн Баталгаажуулалт эхлэх өдрийг тогтооно. Баталгаажуулалтын үр дүн нь тухайн улсын дараагийн Баталгаажуулалтын огноог дараах байдлаар тодорхойлно.

- **Маш өндөр.** "Маш өндөр" оноо авсан бүрэлдэхүүн хэсгүүдийг 36 сарын дараа дахин баталгаажуулна.
- **Өндөр.** "Өндөр" оноо авсан бүрэлдэхүүн хэсгүүдийг 12-36 сарын дотор баталгаажуулдаг. Дараагийн Баталгаажуулалт эхлэх огноог тогтоохдоо ОУИТБС-ын Удирдах зөвлөл засч залруулах арга хэмжээний мөн чанар болон орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- **Дунд зэрэг эсвэл нэлээд бага.** "Дунд" эсвэл "Нээрээ бага" оноотой бүрэлдэхүүн хэсгүүдийг 12-24 сарын дотор баталгаажуулдаг. Дараагийн Баталгаажуулалт эхлэх огноог тогтоохдоо ОУИТБС-ын Удирдах зөвлөл засч залруулах арга хэмжээний мөн чанар болон орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- **Бага.** Баталгаажуулалтаар "бага" гэсэн ерөнхий үнэлгээтэй А улсын аль нэг бүрэлдэхүүн хэсгийн оноо "Бага" байвал түр түдгэлзүүлнэ. Тус улс бүх бүрэлдэхүүн хэсгийн оноог дор хаяж "Нилээн бага" болгож сайжруулсны дараа түдгэлзүүлэлтийг цуцална. "Бага" оноотой бүрэлдэхүүн хэсгүүдийг 12-24 сарын дотор баталгаажуулдаг. Дараагийн Баталгаажуулалт эхлэх огноог тогтоохдоо ОУИТБС-ын Удирдах зөвлөл засч залруулах арга хэмжээний мөн чанар болон орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

Хэрэгжүүлэгч орон 7 дугаар зүйлд заасны дагуу энэ хугацааг сунгах хүсэлт гаргаж болно. Мөн аливаа улс ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс төлөвлөсөн хугацаанаас өмнө Баталгаажуулалтыг эхлүүлэх хүсэлт гаргаж болно.

Хэрэгжилтийн түвшин мэдэгдэхүйц муудсанд санаа зовж буй оролцогч талууд мөн ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс 8 дугаар зүйлийн дагуу эрт баталгаажуулалт эсвэл зорилтот хяналтыг хийлгэх хүсэлт гаргаж болно. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь нөхцөл байдлыг хянаж үзээд нэг буюу хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгүүдийн эрт Баталгаажуулалт хийх эсэх талаар өөрийн үзэмжээр ажиллана.

Хэрэгжүүлэгч орнууд Баталгаажуулалтын хооронд бүрэлдэхүүн хэсэг болон нийт оноогоо сайжруулах хүлээлттэй ажиллана. Хэрэв тухайн улс гурван бүрэлдэхүүн хэсгээс дор хаяж нэгээр нь оноогоо ахиулаагүй эсвэл аль нэг бүрэлдэхүүн хэсэг нь мэдэгдэхүйц муудсан бол ОУИТБС-ын Удирдах зөвлөл ахиц дэвшил гаргах хүртэл тухайн улсыг түр хугацаагаар түдгэлзүүлж болно. Хэрэв тухайн улс удаа дараа ахиц дэвшил гаргаж чадахгүй бол жагсаалтаас хасагдана.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл хэрэгжүүлэгч орныг түдгэлзүүлэх эсвэл жагсаалтаас хасах эсэхийг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

- Нийт тоон оноо болон бүрэлдэхүүн хэсгийн оноо. Бүх бүрэлдэхүүн хэсэг дээр "Өндөр" эсвэл "Маш

өндөр" оноо авсан улсууд өмнөх Баталгаажуулалтаас хойш ахиц дэвшил гаргаж чадаагүйн бол түдгэлзүүлэхгүй.

- Баталгаажуулалтын баг болон Баталгаажуулах хорооны зөвлөгөө, зөвлөмж;
- Хэрэгжүүлээгүй шаардлагын шинж чанар, шаардлага хангахад хэр ойрхон байгаа;
- Тус улсын олборлох салбарын цар хүрээ, нарийн төвөгтэй байдал;
- Төрийн тогтворгүй байдал, сүүлийн үед эсвэл үргэлжилж буй улс төрийн өөрчлөлт, олон талын оролцогчдын бүлэг тулгарсан саад бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээ авсан зэрэг шаардлагуудыг биелүүлэхэд тулгарч буй бусад саад бэрхшээлүүд, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.
- Шаардлагуудыг биелүүлэхийн тулд олон талт оролцоот бүлгийн сайн санааны хүчин чармайлт гаргасан байдал
- Шаардлагыг биелүүлээгүй шалтгаан, үндэслэл; болон
- Олон талын оролцоот бүлгйн Ирээдүйд тавигдах шаардлагуудыг шийдвэрлэхийн тулд тохиролцсон аливаа төлөвлөгөө

7 дугаар зүйл. Сунгалт.

Хэрэгжүүлэгч орон нь дээр заасан эцсийн хугацааны аль нэгийг тухайн хугацаанд нь багтаан хангаж чадахгүй бол хугацааг сунгуулахаар хүсэлт гаргаж болно. ОУИТБС-ын Удирдах зөвлөл аливаа хугацаа сунгуулах хүсэлтийг хянан үзэхдээ дараах сорилыг хэрэглэнэ. Үүнд:

1. Хүсэлтийг тухайн эцсийн хугацаа дуусахаас өмнө гаргасан байх ёстой бөгөөд Олон талт оролцогчдын бүлгээр батлагдсан байх;
2. Олон талт оролцогчдын бүлэг нь хугацаанд нь биелүүлэхийн тулд тодорхой хэмжээний дэвшил гаргасан хэдий ч онцгойлон хүндэтгэх шалтгааны улмаас саад бэрхшээл учраад байгааг батлан харуулсан байх шаардлагатай. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тодорхой хэмжээний ахиц дэвшил гаргасан эсэхийг хянан шалгахдаа доорх хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
 - (i) ОУИТБС-ын үйл явц, ялангуяа Олон талт оролцогчдын бүлгийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа болон төрийн зүгээс санаачилгыг хэрэгжүүлэх тодорхой, хүчтэй хүсэл эрмэлзэл байгаа эсэх;
 - (ii) ОУИТБС-ын тайлангийн нөхцөл байдал, чанарын тухай асуудал ялангуяа 4.8 дугаар шаардлагын дагуу тайланг цаг хугацаанд нь багтаан хэвлэн нийтлүүлж байгаа эсэх, түүнчлэн ОУИТБС-ын тайлангийн ажлыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж буй байдал.
3. Олон талт оролцогчдын бүлгээс гаргасан хүсэлтдээ онцгойлон хүндэтгэх шалтгааныг тайлбарласан байх; Эдгээр нь жишээлбэл, онцгой улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой байж болно

8 дугаар зүйл. Түдгэлзүүлэх.

1. ОУИТБС-ын зарчим, ОУИТБС-ын шаардлагуудыг зөрчсөний улмаас түдгэлзүүлэх

Хэрэгжүүлэгч орон нь ОУИТБС-ын үндсэн зарчим, ОУИТБС шаардлагын ач холбогдол бүхий талыг даган мөрдөөгүй болох нь тодорхой болсон тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн орныг эрхийг түдгэлзүүлэх эсвэл хасна. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн орны хувьд санаачилгын зарчим, ОУИТБС-ын шаардлагыг даган мөрдөх дээр асуудал үүссэн хэмээн үзвэл ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь Олон улсын нарийн бичгийн газарт тухайн орны хэрэгжилтийн нөхцөл байдлын тухай мэдээлэл цуглуулан, тайлагнахыг даалгаж болно.

Хэрэгжүүлэгч орны статусыг түдгэлзүүлэх нь түр хугацаагаар авч буй арга хэмжээ юм. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь хэрэгжүүлэгч оронд санаачилгын стандартыг зөрчсөн байдлаа засах, сайжруулах арга хэмжээ авах хугацаа өгнө. Түдгэлзүүлсэн хугацаанд тухайн орон нь “түдгэлзүүлсэн” гэх статустай байна. Энэхүү хугацаанд асуудлыг ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд шийдвэрлэсэн тохиолдолд тухайн орны статусыг дахин сэргээнэ. Харин тухайн орон энэхүү хугацаанд үүссэн зөрчлийг ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс хангалттай гэж үзэх хүртэл засаж сайжруулах арга хэмжээг аваагүй бол түс үлсыг жагсаалтаас хасна.

2. Улс төрийн тогтворгүй байдал, мөргөлдөөнөөс үүдэн түдгэлзүүлэх:

Тухайн оронд улс төрийн тогтворгүй байдал, мөргөлдөөн үүссэний улмаас ОУИТБС-ын зарчим, шаардлагыг даган мөрдөхөд ихээхэн хэмжээний саад бэрхшээл учирсан тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөл тухайн орны статусыг түдгэлзүүлж болно. Улс төрийн тогтворгүй байдал, мөргөлдөөн үүсээд буй орон нь өөрийн сайн дураар статусаа түдгэлзүүлэх хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн орны Засгийн газар ОУИТБС-ын Удирдах зөвлөлд уг хүсэлтээ гаргана. Засгийн газраас гаргаж буй хүсэлт нь Олон талт оролцогчдын бүлгийн байр суурийн илэрхийлэлтэй байх шаардлагатай.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн улс орны нөхцөл байдлыг байнга хянан, судлан үзэх бөгөөд түдгэлзүүлсэн хугацаа болон тухайн орныг хасах хугацааг сунгах эрхтэй.

3. Түдгэлзсэнийг зогсоох

Тухайн улсын Засгийн газрын зүгээс түдгэлзсэн байдлыг зогсоох хүсэлтийг ямар ч үед гаргаж болно. Энэхүү хүсэлтэд оролцогч талууд ОУИТБС-ыг дахин эхлүүлэх, хэрэгжүүлэх, Баталгаажуулалт хийлгэх талаар авах арга хэмжээ, хийх ажлын төлөвлөгөөг ОУИТБС-ын стандартын дагуу оруулсан байх ёстой. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь түдгэлзүүлсэн үндсэн шалтгааныг шийдэх арга хэмжээг хангалттай авсан гэж үзвэл түдгэлзүүлсэн байдлыг зогсооно. Түдгэлзүүлснийг зогсоохдоо ОУИТБС-ын Удирдах зөвлөл шаардлагатай гэж үзсэнийхээ дагуу тайлангийн болон Баталгаажуулалтын шинэ эцсийн хугацааг тогтоох талаар авч хэлэлцэнэ. Энэхүү үйл явцын бүх үе шатанд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь өөрийн байр суурь болон гаргасан шийдвэрийн талаар тухайн оронд ил тод, ойлгомжтой байдлаар мэдээлж байна.

9 дүгээр зүйл. Хасах.

Дор дурдсан тохиолдолд тухайн орныг хасах буюу ОУИТБС-ын хэрэгжүүлэгч орон хэмээх статусыг цуцална. Үүнд:

- (1) Тухайн улсын ОУИТБС-ын хэрэгжүүлэгч статусыг түдгэлзүүлсэн байсан бөгөөд тухайн улс асуудлыг ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс заасан хугацаанд хангалттай хэмжээнд хүртэл шийдээгүй бол;
- (2) ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тухайн улс Баталгаажуулалтын явцад удаа дараа ахиц дэвшлийг харуулж чадаагүй гэж дүгнэсэн бол.

Санаачилгыг хэрэгжүүлэгч орон нь ОУИТБС-ын зарчимүүд болон ОУИТБС-ын шаардлагуудыг даган мөрдөөгүй нь тогтоогдвол ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн улсыг хасах эрхтэй. Хасагдсан улс нь ОУИТБС-д дахин нэр дэвших өргөдлөө ямар ч үед гаргах боломжтой. Удирдах зөвлөл нь ОУИТБС-д нэр дэвшигчийн өргөдлийг холбогдох журмын дагуу хянан үзнэ. Хүсэлтийг хянан үзэхдээ тухайн орон ОУИТБС-ыг хэрэгжүүлж байсан өмнөх түршлага, санаачилгыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд тулгарч байсан саад бэрхшээл, хэрэгжилтийг сайжруулах талаар авч байсан засан залруулах арга хэмжээг зэргийг харгалзан үзнэ.

10 дугаар зүйл. Давж заалдах.

Санаачилгыг хэрэгжүүлэгч орон нь өөрийнх нь статусыг түдгэлзүүлсэн, хасагдсан, Баталгаажуулалтын дараагаар нэр дэвшигч эсвэл ОУИТБС-ын шаардлага хангасан орны статус олгосон зэрэг шийдвэрээ эргэн харахыг хүсэж ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хандан хүсэлт гаргаж болно. Ийнхүү гаргасан хүсэлтэд хариу өгөхдөө Удирдах зөвлөл нь тухайн асуудлын талаарх баримтууд, ОУИТБС-ын шударга байх зарчим, улс орнуудад адил тэгш байдлаар хандах зарчим зэргийг харгалзан үзнэ. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гаргах шийдвэр нь эцсийнх байна. Тухайн орон нь Санаачилгад нэгдэн орох заалтын 7 дугаар зүйлд заасны дагуу ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг мэдэгдлийн хугацаанаас өмнө Гишүүдийн нэгдсэн хуралд хандан давж заалдаж болно.

БҮЛЭГ 2

Баталгаажуулалтын тойм

Энэ хэсэгт ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тухайн улсын ОУИТБС-ын Стандартыг хангахад гарсан ахиц дэвшлийг үнэлэхэд ашигладаг зорилго, арга зүй, журмыг тодорхойлсон.

1-р зүйл: Баталгаажуулалтын зорилго

Баталгаажуулалт нь ОУИТБС-ын нэгэн чухал элемент юм. Үүнийг гүйцэтгэлийг үнэлэх болон тухайн улс орны хэмжээнд хэлэлцүүлэг ба сургамжийг хөхиүлэн дэмжихэд ашигладаг. Түүнчлэн, бүх ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнуудыг дэлхийн стандартад тогтоон барьж, ОУИТБС-ын шударга байдлыг хамгаалдаг. Энэ нь бүх оролцогчдыг улс орны ОУИТБС-ын хэрэгжилт нь ОУИТБС-ын стандартын шаардлагуудтай нийцэж байгаа эсэхийг үнэлэх хараат бус үнэлгээгээр хангах зорилготой.

Баталгаажуулалтын тайланд баталгаажуулах ажиллагаа явагдсан улс орны ОУИТБС-ын үр нөлөө түүнчлэн, ОУИТБС-ын стандартаар дэмжсэн үйл ажиллагааны хэрэгжилт, ОУИТБС-ын хэрэгжилтээс авсан сургамж, цаашдын ОУИТБС-ын хэрэгжилтийн талаарх оролцогчдын санал бодол, зөвлөмж, болон ОУИТБС-ыг цаашид хэрэгжүүлэх зөвлөмж зэргийг дурдана.

2-р зүйл: Баталгаажуулалтын аргачлал

Баталгаажуулалтын үнэлэх үйл явц нь ОУИТБС-ын шаардлагын дагуу хийгддэг. Аргачлалыг ОУИТБС-ын шаардлага бүрийг үнэлэх удирдамжийн хамт Баталгаажуулалтын гарын авлагад тусгасан болно. Зарим тохиолдолд Баталгаажуулагч шаардлагыг хангасан болохыг баталгаажуулахдаа ашиглах ёстой нотолгоог Баталгаажуулалтын гарын авлагад тусгайлан заадаг. Өөр бусад тохиолдолд улс орон ОУИТБС-ын шаардлагад анхаарахдаа ашиглаж болох олон янзын хандлага байдаг бөгөөд Баталгаажуулалтын гарын авлагад Баталгаажуулагч анхааралдаа авч болох нотолгооны төрлийн жишээг дурдсан байдаг.

3-р зүйл: Баталгаажуулалтын журам

Баталгаажуулалт нь ОУИТБС-ын стандартын “Оролцогч талуудын оролцоо” (Шаардлага 1.1-1.4), “Ил тод байдал” (Шаардлага 2-6) болон “Үр дүн ба нөлөөлөл” (Шаардлага 1.5 ба 7) гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг буюу хэд хэдэн хэсгийг хэрэгжүүлэх үйл явцыг үнэлнэ. Баталгаажуулалтад үнэлэгдсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх Баталгаажуулалтын үр дүн болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тогтоосон Баталгаажуулалтын хуваарийн дагуу тодорхойлно.

1. Баталгаажуулалтад бэлтгэх.

Баталгаажуулалт эхлэхээс өмнө олон талт оролцогчдын бүлэг нь Удирдах зөвлөлөөс зөвшөөрөгдсөн загваруудыг ашиглан үнэлгээ хийгдэж буй бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд ОУИТБС-ын шаардлага бүрийг авч үзсэнийг нотлох баримтыг харуулсан өгөгдөл, баримт бичгийн нэгтгэлийг хянадаг. Энэ ажлыг жишээлбэл, үндэсний ажлын алба, зөвлөх эсвэл бие даасан администраторын дэмжлэгтэйгээр хийж болно. Улс орнууд Баталгаажуулалтад бэлтгэх талаар ОУИТБС-ын удирдамжтай танилцахыг хүсч болно.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газрын тухай улсыг хариуцсан баг зааварчилгаа өгнө. Энэхүү дэмжлэгт тухайн орон уруу төлөөлөгч илгээх байж болох бөгөөд Баталгаажуулалтын багийн гишүүн оролцогч талуудад Баталгаажуулалтын үйл явцын талаар танилцуулга өгөх зорилгоор очиж болно. Аливаа зөвлөлдөх үүлзалтад оролцогч талуудын төлөөлөгчдийн саналыг тэнцвэртэй авч үзэх ёстой. Ахиц дэвшлийг харуулах, нотлох баримт бүрдүүлэх үүрэг нь хэрэгжүүлэгч орнуудад байна. Үндэсний ажлын алба нь нь ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газраас гаргасан Удирдах зөвлөлөөс баталсан загваруудыг ашиглан ОУИТБС-ын шаардлагыг дагаж мөрдөж байгааг нотлох баримт бичиг болон бусад эх сурвалжийг нэгтгэх ёстой. Хоёр дахь болон дараагийн Баталгаажуулалтад олон талт оролцогчдын бүлгийг ахиц дэвшлийг харуулах залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

Олон талын оролцогчдын бүлгээс ирүүлсэн материал нь олон нийтэд нээлттэй баримт бичгийн лавлагаа, тэдгээрт хэрхэн хандах талаарх мэдээллийг агуулсан байх ёстой. Эх сурвалж бичиг баримтыг олон нийтэд нээлттэй болгох боломжгүй тохиолдолд (жишээлбэл, олон оролцогч талуудын бүлгийн хурлын тэмдэглэл, Ажлын даалгавар) тэдгээрийг хавсралт болгон өгөх ёстой.

Оролцогч талуудыг өөрт хамааралтай ОУИТБС-ын стандартад зааснаас илүү хүчин чармайлт шаардсан агуулга бүхий баримт бичгийг бэлтгэхийг урьж болно.

Олон талт оролцогчдын бүлгүүд баталгаажуулалт эхлэхээс өмнө бөглөсөн мэдээлэл цуглуулах, баримт бичгийн загваруудыг ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газарт ирүүлэх ёстой. Баталгаажуулалт эхлэхээс өмнө ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газар ОУИТБС-д оролцогч талуудын оролцооны талаар асуулга авна. Асуулга нь олон нийт, олон талын оролцоот бүлэг болон бусад холбогдох талуудад нээлттэй байна.

Баталгаажуулалтын хороо нь сонгосон баталгаажуулалтын талаар ОУИТБС-ын стандартын дагуу аливаа асуудлаар санал оруулах зорилгоор хөндлөнгийн шинжээчийг татан оролцуулж болно.

2. Мэдээллийг хянах, урьдчилсан үнэлгээ хийх

ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газрын Баталгаажуулах баг нь олон талт бүлгээс ирүүлсэн мэдээлэл, мөн оролцогч талуудын оролцооны талаар асуулганд өгсөн хариуг хянадаг. Баталгаажуулах багийн бүрэлдэхүүнийг олон талын оролцоот бүлэг болон үндэсний албанд мэдэгдэнэ.

Баталгаажуулалтын баг нь ОУИТБС-ын шаардлага нэг бүрийн дагуу, үр нөлөө, тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт бүхий Баталгаажуулалтын удирдамжийг удирдлага болгосон урьдчилсан үнэлгээг санал болгодог. Баталгаажуулалтын баг дутагдлыг арилгах олон нийтэд нээлттэй эх сурвалжийг мэддэг бол үнэлгээний төсөлд үүнийг онцлон харуулах болно.

Хоёр дахь болон дараагийн Баталгаажуулалтын үнэлгээнд өмнөх Баталгаажуулалтын үед тодорхойлсон залруулах үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлнэ. Үүнд: ямар нэгэн ухрах шинж тэмдэг байгаа бол, инноваци, ОУИТБС-ын шаардлагуудын хэрэгжүүлэх хүчин чармайлт, хэрэгжилтийн үр ашиг, тогтвортой байдал зэрэг байна.

Баталгаажуулалтын баг нь олон талын оролцогчдын бүлэгт теле хурлаар урьдчилсан дүгнэлтийг хэлэлцэх боломжийг санал болгоно. Баталгаажуулалтын баг энэ үе шатанд оролцогч талуудын зорилтот виртуал зөвлөлдөх уулзалтыг хийж, ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газрын улс орны багтай зөвлөлдөх эсвэл нэмэлт мэдээлэл авахын тулд хөндлөнгийн шинжээчдээс зөвлөгөө авах боломжтой. Онцгой тохиолдолд, ялангуяа оролцогч талуудын оролцоотой холбоотой ноцтой асуудал байгаа тохиолдолд Баталгаажуулалтын баг тус улсад очиж биечлэн зөвлөлдөж, нэмэлт мэдээлэл авах боломжтой.

Баталгаажуулалтын баг нь үнэлж буй бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой ОУИТБС-ын шаардлагуудыг хэрэгжүүлэх явцыг нэгтгэн дүгнэсэн үнэлгээний төслийг боловсруулдаг. Үнэлгээний төсөл, үндсэн баримт бичиг болон оролцогч талуудын оролцоотой холбоотой санал хүсэлт зэргийг олон талт бүлэг болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн Баталгаажуулах хороо хоорондоо мэдээлэл солилцох зорилгоор хуваалцдаг.

3. Оролцогч талуудын санал

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газрын хийсэн урьдчилсан үнэлгээг тухайн улсын хэл дээр бэлтгэн олон талын оролцоот бүлэг хүлээн авснаас хойш дөрвөн долоо хоногийн дотор нэмэлт нотлох баримт болон бусад санал хүсэлт зэргийг хүргүүлнэ. Үндэсний зохицуулагч (ҮЗ) олон талт бүлгийн санал, нэмэлт нотлох баримтыг нэгтгэж, Олон улсын нарийн бичгийн газарт хүргүүлэх ёстой. Үндэсний зохицуулагч санал хүсэлтийг хэлэлцсэн олон талт бүлгийн хуралдааны тэмдэглэлийг саналд хавсаргана. Онцгой тохиолдолд сонирхогч талууд Олон улсын нарийн бичгийн газартай шууд холбогдож саналаа хэлж болно.

ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газрын Баталгаажуулах баг дөрвөн долоо хоногийн дотор оролцогч талуудаас ирүүлсэн бүх материалыг хянан үзэж, олон талын оролцогчдын бүлэгт хариу өгөх ёстой. Олон улсын Нарийн бичгийн газар нь дан оролцогч талууд эсвэл оролцогч талын тойргуудын санал хүсэлтээс илүү олон талын оролцоот бүлгийн тохиролцсон санал хүсэлтийг чухалчлах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч олон талт бүлгийн санал хүсэлтэд оролцогч талуудын байр сууриа тусгах боломжийн хязгаарлалтыг анхаарч үзэх хэрэгтэй. Олон улсын нарийн бичгийн газар шаардлагатай гэж үзвэл оролцогч талуудаас нэмэлт мэдээлэл авахыг хүсч болно.

Баталгаажуулалт эхэлсний дараа гарсан ил тод байдал, хөгжлийн талаарх аливаа мэдээллийг олон талт оролцогчдын санал хүсэлтэд дурдсан бөгөөд үнэлгээнд чухал нөлөө үзүүлж байвал ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газрын эцсийн үнэлгээнд авч үзнэ. Хэрэв хувь оролцогч талууд эсвэл оролцогч талын

тойргууд ахиц дэвшилийн тухай шинэ нэмэлт мэдээлэл ирүүлбэл Баталгаажуулах хороонд хүргүүлэх боловч Олон улсын нарийн бичгийн газрын үнэлгээнд харгалзахгүй. Олон талын оролцогчдын бүлэг эцсийн саналаа өгсний дараа ирүүлэх янз бүрийн тайлбарыг хүлээн авахгүй.

4. Удирдах зөвлөл хянан шалгах нь.

Эцсийн үнэлгээ болон үндсэн бүх баримт бичгийг Баталгаажуулах хороонд шалгуулахаар хүргүүлнэ. Баталгаажуулах хороо нь томилогдсон хөндлөнгийн шинжээчийн саналыг авч үзэх бөгөөд ОУИТБС-ын Олон улсын Нарийн бичгийн газарт цаашид зөвлөлдөх талаар санал оруулж болно.

Дараа нь Баталгаажуулалтын хороо тухайн орны ОУИТБС-ын шаардлагуудын хангалтын талаар ОУИТБС-ын Удирдах зөвлөлд зөвлөмж гаргах ба үүнд боломжтой бол засан залруулах арга хэмжээг заасан байна. ОУИТБС-ын Удирдах зөвлөл шаардлагуудыг хангасан, хангаагүй эсэх болон ОУИТБС-ын хэрэгжилт дэх Удирдах зөвлөлийн хяналтын журмын 8 дугаар зүйлийн дагуу тухайн улс орны ерөнхий үнэлгээний талаар эцсийн шийдвэрийг гаргана. Удирдах зөвлөл эцсийн шийдвэр гаргах хүртэл анхдагч үнэлгээ, Баталгаажуулалтын тайлан болон хамаарах Олон талын оролцоот бүлгийн тайлбар зэргийг нууцлалтай баримт бичиг хэмээн тооцно.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл Баталгаажуулалт эхэлснээс хойш олон талт оролцогчдын бүлгээс нэмэлтээр ирүүлсэн материалд ороогүй бөгөөд оролцогч талуудын оролцоотой холбоотой шаардлагуудыг (Шаардлага 1.1, 1.2 ба 1.3) сайжирсан мүүдсан тухай нотлох баримтуудыг үнэлгээнд авч үзэхгүй.

Баталгаажуулах хороо нь ОУИТБС-ын шаардлагуудыг шийдвэрлэх талаар улс орны ахиц дэвшлийн талаар ОУИТБС-ын Удирдах зөвлөлд зөвлөмж хүргүүлнэ. Үүнд тогтвортой байдал, үр дүнтэй байдлын үзүүлэлтүүдийн гүйцэтгэл; дараагийн баталгаажуулалтын хугацаа; мөн шаардлагатай бол засах шаардлагатай аливаа арга хэмжээ хамаарна. . ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Стандартын 1-р хэсгийн 4, 5-р зүйлийн дагуу ОУИТБС-ын шаардлага бүрийн үнэлгээ болон Баталгаажуулалтын үр дагаврыг тодорхойлно.

Баталгаажуулалттай холбоотой баримт бичгийг ОУИТБС-ын Удирдах зөвлөл шийдвэрт хүрэх хүртэл нууц гэж үзнэ. Удирдах зөвлөлийн гишүүдийг ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн нууц баримт бичгүүдийг хуваалцахгүйгээр тойргийнхоо орон нутгийн оролцогч талуудтай холбогдож санал бодлыг нь авахыг зөвлөж байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөл шийдвэрээ гаргасны дараа баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгоно. Баталгаажуулах хороо нь оролцогч талуудын санал хүсэлтийг нууцаар авч хэлэлцэнэ. ОУИТБС-ын Стандартын 2-р хэсгийн 1-р бүлгийн 10-р зүйлийн дагуу хэрэгжүүлэгч улс ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хандаж Баталгаажуулалттай холбоотой шийдвэрээ хянан үзэх хүсэлт гаргаж болно.





Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга

Улс орны байгалийн баялаг иргэдийнх гэдэгт
бид итгэдэг.

Бидний эрхэм зорилго бол байгалийн баялгийн
менежментийн талаарх ойлголтыг сурталчлах, төрийн
болон компанийн засаглалыг бэхжүүлэх, олборлох
салбарын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд
шаардлагатай мэдээллээр хангах явдал юм.

eiti.org



Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга

Газрын тос, байгалийн хий
болон ашигт малтмалын
баялгийн сайн засаглалын
дэлхий нийтийн стандарт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН СТАНДАРТ 2023

3-р хэсэг: ОҮИТБС-ЫН ЗАСАГЛАЛ БА УДИРДЛАГА

2023 оны 6-р сар

2023 ОҮИТБС-ын стандарт (Хэсэг 2)

2023 оны 6-р сарын 12-нд нийтлэгдсэн

© ОҮИТБС 2023

Энэ баримт бичгийг Үнэн зөвөөр, буруу мэдээлэл өгөлгүйгээр (логоноос бусад) ямар нэгэн формат хэлбэр эсвэл хэрэгслээр, үнэ төлбөргүйгээр хуулбарлан хэрэглэж, нийтлэн гаргаж болно. Тухайн материалын зохиогчийн эрхийг ОҮИТБС эзэмшдэг болохыг тусгаж, гарчиг болон эх сурвалжийг заавал дурдсан байна.

Хэвлэлийн эх болон дизайны зохиогчийн эрхийг ОҮИТБС эзэмшинэ.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН СТАНДАРТ 2023

Газрын тос, байгалийн хий болон ашигт
малтмалын баялгийн сайн засаглалын
Дэлхий нийтийн стандарт

АГУУЛГА

Оршил

БҮЛЭГ 1: ОУИТБС-ын дүрэм

- 1 дүгээр зүйл: Нэр
- 2 дугаар зүйл: Үндсэн мэдээлэл ба зорилго
- 3 дугаар зүйл: Хуулийн этгээд, хязгаарлагдмал хариуцлага
- 4 дүгээр зүйл: Бүтэц, зохион байгуулалт
- 5 дугаар зүйл: Гишүүнчлэл ба сонгуулийн тойрог
- 6 дугаар зүйл: ОУИТБС-ын Дэлхийн бага хурал
- 7 дугаар зүйл: ОУИТБС-ын гишүүдийн хурал
- 8 дугаар зүйл: ОУИТБС-ын гишүүдийн хурлын чиг үүрэг
- 9 дүгээр зүйл: ОУИТБС-ын удирдах зөвлөл
- 10 дугаар зүйл: Ажиглагчид
- 11 дүгээр зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн дарга
- 12 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн чиг үүрэг
- 13 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн хороод
- 14 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн үйл ажиллагаа ба хурал
- 15 дугаар зүйл. ОУИТБС-ын Олон Улсын Нарийн Бичгийн Газар
- 16 дугаар зүйл. ОУИТБС-ын Гүйцэтгэх Захирал
- 17 дугаар зүйл. Санхүүжилт
- 18 дугаар зүйл. ОУИТБС-ын данс, санхүүжилтийн менежмент ба төлбөр
- 19 дугаар зүйл. Нэмэлт, өөрчлөлт
- 20 дугаар зүйл. Гишүүнчлэлээс татгалзах, татан буулгах
- 21 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

БҮЛЭГ 2: ОУИТБС-ын сонгуулийн тойргийн удирдамж

Оршил

Энэхүү баримт бичиг нь ОУИТБС-ын Стандартын 3-р хэсэг ("ОУИТБС-ын засаглал ба удирдлага") бөгөөд ОУИТБС-ын дүрэм болон ОУИТБС-ын сонгуулийн тойргийн удирдамжаас бүрдэнэ.

ОУИТБС нь хэрэгжүүлэгч болон дэмжигч орнуудын Засгийн газар, компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудаас бүрдсэн олон талын оролцоот байгууллага юм. ОУИТБС-ын Холбоо нь Гишүүдийн хурал, ОУИТБС-ын Удирдах зөвлөл, ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газар гэсэн гурван институцийн байгууллагаас бүрдэнэ. Энэ байгууллага нь Норвегийн хуулийн дагуу ашгийн бүс холбоогоор бүртгэгдсэн бөгөөд ОУИТБС-ын стандартын нэг хэсэг болох ОУИТБС-ын дүрэмд захирагддаг. Гишүүдийн хурал нь ОУИТБС-ын удирдах дээд байгууллага бөгөөд ОУИТБС-ын Удирдах зөвлөлийг гурван жил тутамд ОУИТБС-ын Дэлхийн бага хурлаар сонгодог. Энэ нь улс орон (хэрэгжүүлж, дэмжиж байгаа), дэмжигч компаниуд болон иргэний нийгмийн байгууллагууд гэсэн гурван тойргийн төлөөлөгчдөөс бүрддэг. Тойргууд нь Гишүүдийн хуралд төлөөлөгч томилох, ОУИТБС-ын Удирдах зөвлөлд гишүүн санал болгодог өөрийгөө удирдах ёсны байгууллага юм. Тойрог, дэд тойрог нь нэр дэвшүүлэх удирдамжийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаа болон хариуцлагыг сайжруулж бүлэг дотроо мэдээллээ солилцоно.

Олон улсын ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын гол шийдвэр гаргах байгууллага бөгөөд Удирдах зөвлөлийн хурал, хорооны хурал, Удирдах зөвлөлийн танилцуулгаар дамжуулан ОУИТБС-ын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьдаг. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь хэрэгжүүлж байгаа болон дэмжигч орнуудын төлөөллөөс бүрдсэн дэмжигч компаниуд болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл бүхий 20 гишүүн болон тэдэн дээр тэднийг орлогч болон дарга нэмэгдэнэ.

ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газар нь ОУИТБС-ын Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна. ОУИТБС-н Олон Улсын Нарийн бичгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа улс орнуудад техникийн тусламж болон зөвлөгөөг бусад олон талын болон хоёр талын харилцаат төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр үзүүлдэг.

ОУИТБС-ын стандартын **1-р хэсэг** ("Зарчмууд ба шаардлага") нь ОУИТБС-ын үндсэн зарчмууд, түүнчлэн ОУИТБС-д оролцогч талуудад тавигдах шаардлага, хүлээлтийг тодорхойлсон.

ОУИТБС-ын стандартын **2-р хэсэгт** ("ОУИТБС-ын Зөвлөлийн хяналт ба баталгаажуулалт") ОУИТБС-ын стандартын хэрэгжилтэд Олон улсын Удирдах зөвлөл хэрхэн хяналт тавьж, үнэлдэгийг тодорхойлдог журам, шалгуурыг тодорхойлсон.

ОУИТБС-ын төрөл бүрийн асуудлуудыг хэрэгжүүлэх удирдамжийн хамт ОУИТБС-ын стандартыг бүрэн эхээр нь авахын тулд ОУИТБС-ын вэбсайтыг (www.eiti.org) ашиглаж болно.

БҮЛЭГ 1

ОУИТБС-ын дүрэм

ОУИТБС-ын дүрэмээр ОУИТБС-ын холбооны үйл ажиллагаа удирдана. 2023 оны 6-р сарын 12-13-ны өдрийн ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар шинэчилсэн.

9 дүгээр зүйл: Нэр

1. Холбооны нэр нь “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (“ОУИТБС”) холбоо” (цаашид “ОУИТБС-ын Холбоо” гэх) болно.

10 дугаар зүйл. Үндсэн мэдээлэл ба зорилго

1. ОУИТБС-ын Холбоо нь Засгийн газар болон түүний агентлагууд, эрчим хүч, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд, орон нутгийн иргэний нийгмийн бүлгүүд болон олон улсын төрийн бүс байгууллагуудын төлөөлөл орсон дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг сүлжээ бүхий холбоо бөгөөд олон улсын олон талт оролцогчдын санаачилга юм.
2. ОУИТБС-ын Холбооны зорилго нь ОУИТБС-ын Зарчмууд болон ОУИТБС-ын шаардлагуудыг газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарын ил тод байдлын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болгон баримтлах явдал юм. Олборлох үйлдвэрлэлийн өртгийн гинжин хэлхээг ил тод болгон бэхжүүлэх нь авлигыг бууруулж, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, эрчим хүчний хариуцлагатай шилжилтэд хувь нэмэр оруулах, олборлох аж үйлдвэрээс олсон орлогыг эдийн засгийг сайжруулах, ядуурлыг бууруулах, байгалийн баялаг ихтэй орнуудын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломжийг олгох болно.

11 дугаар зүйл. Хуулийн этгээд, хязгаарлагдмал хариуцлага

1. ОУИТБС-ын холбоо нь Норвег Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн бүс холбоо юм.
2. ОУИТБС-ын холбооны гишүүд нь, хамтдаа эсхүл тус тусдаа, ОУИТБС-ын холбооны өр, төлбөрийн үүрэг эсхүл өр төлбөрийг хариуцахгүй.

12 дүгээр зүйл. Бүтэц, зохион байгуулалт

- 1) ОУИТБС-ын Холбооны байнгын байгууллагын бүтцийн хэсэг нь дараах болно:
 - i) ОУИТБС-ын Олон улсын бага хуралтай холбоотой хуралддаг ОУИТБС-ын Бүх гишүүдийн хурал;
 - ii) ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Даргаар ахлуулсан ОУИТБС-ын Удирдах зөвлөл;
 - iii) Гүйцэтгэх захирлаар удирдуулсан ОУИТБС-ын Ажлын алба/ Нарийн бичгийн газар.
- 2) ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь 13 дүгээр зүйлийн дагуу хороодыг байгуулж болно;
- 3) ОУИТБС-ын холбооны захиргаа нь үйл ажиллагаагаа ил тод явуулж, жендер, үндэстэн болон соёлын хувьд олон талт байдлыг хөхиүлэн дэмжинэ.

13 дугаар зүйл. Гишүүнчлэл ба сонгуулийн тойрог

1. ОУИТБС-ын холбооны гишүүн нь 5 (2) болон (3) дугаар зүйлд заасны дагуу Оролцогч талын тойргоос томилсон улс орон (төр), компани, байгууллага эсхүл аж ахуйн нэгжийн төлөөлөгч байна.
2. Гишүүд нь дараах 3 тойрогт хуваагдана:
 - a. Улс орнуудын тойрог нь:
 - I. ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс Даган мөрдөгч орны статус олгосон санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд;
 - II. ОУИТБС-ын Холбооны зорилтыг дэмждэг Дэмжигч улс орнууд буюу нэгдсэн, эсхүл холбооны улсуудаас тус тус бүрдэнэ.
 - b. ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тодорхойлсон ОУИТБС-ын Холбооны зорилгыг дэмжих үүрэг хүлээсэн эрчим хүч, олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг компани, санхүүгийн байгууллага, сан, холбоодоос бүрдсэн Компаниудын тойрог.
 - c. ОУИТБС-ын Холбооны зорилгыг дэмждэг ОУИТБС-н Удирдах зөвлөлөөс тодорхойлсон төрийн бүс байгууллага, дэлхийн олон улсад үйл ажиллагаа явуулдаг төрийн бүс байгууллагын сүлжээ,

эвслээс бүрдэх Иргэний нийгмийн байгууллагуудын тойрог.

3. Бүх Тойргууд нь ОУИТБС-ын Холбооны Гишүүдийн томилгоог зохицуулж байгаа дүрэм журмаа тохиролцоно. Гишүүнчлэл нь дараахаар хязгаарлагдана. Үүнд:
 - a. Улс орнуудын тойргоос Санаачилгыг хэрэгжүүлэгч бүх улс орон болон Дэмжигч улс орон (эсхүл тэдний хэсэг) тус бүрийн нэг хүртэлх төлөөлөл;
 - b. Компаниудын тойргоос тэднийг төлөөлж байгаа бүх компани болон холбоо тус бүрийн нэг хүртэлх төлөөлөл ;
 - c. Иргэний нийгмийн байгууллагуудын тойргоос бүх Иргэний нийгмийн байгууллага тус бүрийн нэг хүртэлх төлөөлөл.
4. Тойрог нь өөрийн томилсон аль ч гишүүнээ хэдийд ч сольж болно. Тус тойрог нь ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт томилогдсон гишүүдэд гарсан аливаа өөрчлөлтийн талаар мэдээлэх бөгөөд ингэснээр Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар гишүүдийн шинэчилсэн бүртгэл хөтлөх боломжтой болно.
5. ОУИТБС-ын холбооны гишүүн нас барснаар эрх нь дуусгавар болно; гишүүний төлөөлж буй аж ахуйн нэгжийг хасах; гишүүний төлөөлж буй хэрэгжүүлэгч орны жагсаалтаас хасах; тухайн тойргийн шаардлагын дагуу гишүүнчлэлийн татвар авахгүй, мөн тойргийн шаардлагын дагуу гишүүнээс хасна.
6. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Холбооны Гишүүний гишүүнчлэлийг дараах тохиолдолд дуусгавар болгож болно:
 - a) Гишүүн, улс орон эсхүл тухайн Гишүүний төлөөлдөг бусад аж ахуйн нэгж нь эдгээр Дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдолд; эсвэл
 - b) Гишүүн, улс орон эсхүл тухайн Гишүүний төлөөлдөг бусад аж ахуйн нэгж нь өөрсдийн хэргийг ОУИТБС-ын зарчмуудад хохирол учруулах байдлаар эсхүл эсрэгээр явуулсан.
 - c) ОУИТБС-ын ажилтан нь ОУИТБС-ын Холбооны Ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн.
7. Гишүүн нь Гишүүдийн хурлаар эцэслэн шийдвэрлүүлэхээр ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн шийдвэрийг 5 (5) дугаар зүйлийн дагуу шийдвэр гарснаас хойш дөрвөн долоо хоногийн дотор ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Даргад бичгээр давж заалдаж болно.

14 дугаар зүйл. ОУИТБС-ын Дэлхийн бага хурал

- 1) ОУИТБС-ын Холбооны ашиг сонирхолд нийцүүлэн ОУИТБС-ын оролцогчдыг форумгаар хангах, ОУИТБС-ын Холбооны зорилгыг хөхиүлэн дэмжих болон ОУИТБС-ын Холбооны бодлого, стратегийн талаар өөрсдийн санал бодлоо илэрхийлэхийн тулд ОУИТБС-ын Дэлхийн Бага хурлыг багадаа 3 жил тутамд хуралдуулна. ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Дарга тухайн Бага хурлын даргын үүргийг гүйцэтгэнэ. ОУИТБС-ын Дэлхийн Бага хурал нь ОУИТБС-ын Холбооны гүйцэтгэх бус дээд байгууллага юм.
- 2) ОУИТБС-ын Гишүүд, Удирдах зөвлөл болон Ажлын алба нь ОУИТБС-ын Дэлхийн Бага хуралд оролцох эсхүл төлөөлөх эрхтэй. Түүнчлэн, ОУИТБС-ын бусад оролцогчдыг оролцохыг урих бөгөөд аль ч тохиолдолд ОУИТБС-ын Удирдах зөвлөлгөөр тийнхүү батлуулахын тулд зохицуулалт хийх нь үндэслэлтэй практик юм.
- 3) ОУИТБС-ын Дэлхийн Бага хурлыг ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь багадаа 4 долоон хоногийн өмнө Гишүүд болон тойргуудад бичгээр мэдэгдэл хүргүүлэн ОУИТБС-ын вэбсайтад байршуулан зарлан хуралдуулж болно. Бичгээр гаргах мэдэгдэлд ОУИТБС-ын Дэлхийн Бага хурлаар хэлэлцэх асуудлуудыг оруулна.
- 4) ОУИТБС-ын Дэлхийн Бага хурал нь:
 - a) Хэлэлцүүлэг, сурталчилгаа/нөлөөлөл, хөрөнгө босголт болон ОУИТБС-ын шинэ оролцогчдын хамрагдалтыг чухал, харагдахуйц бодлогоор хангах;
 - b) Өмнөх Гишүүдийн ердийн хурлаас хойших хугацааны үйл ажиллагааны тайланг үндэслэн явцыг хянан шалгах;
 - c) Дараагийн Гишүүдийн ердийн хурал хүртэл ОУИТБС-ын Холбооны үйл ажиллагаатай холбогдуулан ОУИТБС-ын Удирдах зөвлөлд санал гаргах;
 - d) ОУИТБС-ын Холбооны зорилгыг хангах өндөр түвшний хамтын ажиллагаа, улс төрийн үүрэг амлалт болон хөдөлгөөнийг дайчлах, дэмжлэг үзүүлэх;
 - e) ОУИТБС-ын Холбооны засаглалын бүтцэд албан бус төлөөлөлттэй тэдгээр ОУИТБС-ын оролцогчдыг албан бус харилцаа холбооны сувгаар хангах.

15 дугаар зүйл. ОУИТБС-ын гишүүдийн хурал

1. ОУИТБС-ын Холбооны гүйцэтгэх дээд удирдлага нь ОУИТБС-ын Гишүүдийн хурал байна.
2. ОУИТБС-ын Гишүүдийн хурал нь ОУИТБС-ын Холбооны гишүүдээс бүрдэнэ.
3. ОУИТБС-ын Гишүүдийн ээлжит хурлыг ОУИТБС-ын Дэлхийн Бага хуралтай уялдуулан багадаа 3 жил тутамд хуралдуулна. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь багадаа дөрвөн 7 хоногийн өмнө Гишүүдэд бичгээр мэдэгдэл хүргүүлэн ОУИТБС-ын Гишүүдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулна.

4. Гишүүдийн ээлжит бүс хурлыг ОУИТБС-ын Удирдах зөвлөл багадаа 3 долоон хоногийн өмнө Гишүүдэд бичгээр мэдэгдэл хүргүүлэн зарлан хуралдуулж болно. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Дарга Гишүүдийн ердийн бүс хурлыг хуралдуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 8 долоон хоногийн дотор хуралдуулна.
5. ОУИТБС-ын Гишүүдийн хуралд оролцох хүсэлтэй гишүүд нь ОУИТБС-ын Ажлын албанд зарлан дуудах хуудсанд заасан хугацааны дотор мэдэгдэл өгөх ёстой. Гишүүн нь ОУИТБС-ын Гишүүдийн хуралд бичгээр үйлдсэн итгэмжлэлээр оролцож болно. Түүнчлэн, итгэмжлэлд санал өгөх тусгай зааврыг дурдана. Зохио ёсоор гарын үсэг зурсан итгэмжлэлийг зарлан дуудах хуудсанд заасан хугацааны дотор ОУИТБС-ын Ажлын албанд хүргүүлэх ёстой.
6. ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Дарга нь ОУИТБС-ын Гишүүдийн хурлын даргын үүргийг гүйцэтгэнэ.
7. Гишүүдийн хурлын ирц нь багадаа Гишүүдийн гуравны нэг нь хуралд оролцсоноор бүрдэх бөгөөд тойрог бүрээс сонгогдсон Гишүүдийн багадаа 1/3-г оруулах ёстой.
8. Гишүүдийн хурал нь санал нэгтгэйгээр зөвшилцөн шийдвэрүүдийг батлахад бүх хүчин чармайлтаа дайчилна. Санал өгөх шаардлагатай бол гаргасан нийт саналын багадаа 2/3-н дэмжлэгийг шаардаж байгаа шаардлага хангасан олонх шийдвэрүүдийг батлах бөгөөд тойрог бүрийг төлөөлж буй Гишүүдийн гаргасан саналын багадаа 1/3-н дэмжлэгийг оруулах ёстой. Тойрог бүрийн Гишүүдийн нийт саналын тоо нь тэнцүү байх бөгөөд дараах байдлаар тодорхойлно:
 - a) Улс орнуудын тойргоос сонгогдон ирсэн Гишүүд тус бүрдээ нэг саналын эрхтэй байна;
 - b) Компаниудын тойрог болон Иргэний нийгмийн байгууллагуудын тойргоос сонгогдсон гишүүдийн саналыг улс орны нийт саналыг Компанийн гишүүдийн болон Иргэний нийгмийн тойргуудын тоонд тус тус хуваан тодорхойлно.
 - c) ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Дарга санал хураалтын өмнө өөр өөр тойргоос ирсэн Гишүүн тус бүрийн саналын тоог зарлана.

16 дугаар зүйл. ОУИТБС-ын гишүүдийн хурлын чиг үүрэг

- 1) ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар:
 - a) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, ажлын төлөвлөгөө, ОУИТБС-ын гишүүдийн сүүлчийн ээлжит хурлаас хойшхи жилийн тайлан, аудитын тайланг батлах;
 - b) Тойргийн нэр дэвшүүлэлтийг үндэслэн ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн Гишүүд болон Гишүүн тус бүрийн орлох этгээдийг сонгох;
 - c) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн ОУИТБС-ын Даргыг сонгох;
 - d) Гишүүнээс ирүүлсэн санал хүсэлтийн дагуу аливаа бусад асуудлыг авч хэлэлцэх. Тэрхүү санал хүсэлтийг зарлан дуудах хуудсанд дурдсан ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудалд оруулах тэрхүү асуудлын хугацаанд ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Даргад бичгээр хүргүүлнэ.

9 дүгээр зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөл

1. ОУИТБС-ын Холбооны гүйцэтгэх удирдлага нь ОУИТБС-ын Гишүүдийн хурлаас сонгогдсон, Гишүүдийн хурлын удирдамжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа ОУИТБС-ын Удирдах зөвлөл байна.
2. ОУИТБС-ын Холбооны Олон талт оролцогчдын бүлгийн үндсэн шинжийг тусгахын тулд ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн 20 гишүүн ("Удирдах зөвлөлийн гишүүд")-ээс бүрдэх бөгөөд үүнд дараах гишүүд орно:
 - a) Удирдах Зөвлөлийн Дарга;
 - b) ОУИТБС-ын Холбооны гишүүд болох Улс орнуудын тойргоос сонгогдсон Удирдах зөвлөлийн 9 гишүүн. Тэдний хамгийн ихдээ 3 нь Дэмжигч орны төлөөлөл байх бөгөөд үлдсэн нь Санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнуудын төлөөлөл байна.
 - c) ОУИТБС-ын Холбооны гишүүд болох Компаниудын тойргоос сонгогдсон Удирдах зөвлөлийн 6 гишүүн. Тэдний хамгийн ихдээ 1 нь санхүүгийн байгууллагыг төлөөлөх ёстой.
 - d) ОУИТБС-ын Холбооны гишүүд болох Иргэний нийгмийн байгууллагуудын тойргоос сонгогдсон Удирдах зөвлөлийн 5 гишүүн.
3. Тэдгээрийн нэр дэвшүүлэлтийн дараа хуралдсан ОУИТБС-ын Гишүүдийн ердийн хурлаас шийдвэр гаргасан өдрөөс эхлэн Удирдах зөвлөлийн бүх гишүүд огцорно. Гэхдээ тэдгээр гишүүд нь тэрхүү ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар хэлэлцэх дахин нэр дэвшүүлэлтэд оролцох эрхтэй.
4. Тухайн тойрог нэр дэвшүүлсэн Удирдах зөвлөлийн гишүүн бүрийн нэг орлогчийг ("Орлогч") тойргууд нэр дэвшүүлэх бөгөөд ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар сонгож болно. Орлогч гишүүн тухайн Удирдах зөвлөлийн гишүүнийг төлөөлнө. Хэрэв орлогч байхгүй бол холбогдох тойрог шинэ Удирдах зөвлөлийн гишүүн болон орлогчийг нэр дэвшүүлнэ.

5. Удирдах зөвлөлийн гишүүн нь Удирдах зөвлөлийн хуралд оролцоогүй тохиолдолд тухайн Удирдах зөвлөлийн гишүүний орлогч Удирдах зөвлөлийн хуралд оролцох, хэлэлцүүлэгт оролцох, санал өгөх ба тухайн Удирдах зөвлөлийн бүх чиг үүргийг хэрэгжүүлж болно.
6. ОУИТБС-ын Гишүүдийн хурал хооронд ОУИТБС-ын Удирдах зөвлөлд сул орон тоо гарсан тохиолдолд, энэхүү сул орон тоон дээр Удирдах зөвлөлөөс сонгох холбогдох тойргоос санал болгож байгаа шинэ Орлогчийн хамтаар ажлаа өгсөн Удирдах зөвлөлийн гишүүний орлогч ажиллана.
7. ОУИТБС-ын Холбоо нь Удирдах зөвлөлийн гишүүдийг хариуцлагын даатгалд даатгуулна. Даатгалын гэрээний болзол, нөхцөлийг ОУИТБС-ын Удирдах зөвлөл батална.
8. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь бүрэн эрхийн хугацаанд статусыг нь түдгэлзүүлсэн хэрэгжүүлэгч улс орныг төлөөлж байгаа Удирдах зөвлөлийн гишүүний Удирдах зөвлөлийн гишүүний статусыг хэвээр хадгалахаар шийдэж болно. Гэхдээ түдгэлзүүлсэн хугацаанд Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийнэ. Түдгэлзүүлсэн нь нэг жилээс дээш хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд ОУИТБС-ын Удирдах зөвлөл тухайн Удирдах зөвлөлийн гишүүнчлэлийг дуусгавар болгохоор шийдэж болно.

10 дугаар зүйл. Ажиглагчид

1. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан болон бусад холбогдох оролцогчид зэрэг Олон улсын холбогдох байгууллагуудын төлөөлөгчдийг ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн болон Гишүүдийн хуралд ажиглагчаар оролцохыг урина. Тэдгээр ажиглагчид нь саналын эрхгүй хэдий ч тусгай асуудлаар өөрсдийн санал бодлоо илэрхийлж болно. ОУИТБС-ын Удирдах хороо нь ажиглагчдын оролцоогүйгээр шийдэж болох зарим нэг асуудал байна гэж үзэж болно.

11 дүгээр зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн дарга

- 1) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргыг ОУИТБС-ын Гишүүдийн ээлжит хурлаар сонгоно. ОУИТБС-ын Гишүүдийн ээлжит хурал бүрийн өмнө ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь тухайн ОУИТБС-ын Гишүүдийн хурлын дараа тодорхой хугацаанд ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргад нэр дэвшигчийг санал болгоно. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацааг нэг удаа сунгаж болно.
- 2) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн дарга нь:
 - i) ОУИТБС-ын Гишүүдийн хурлын даргын үүргийг гүйцэтгэх;
 - ii) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурлын даргын үүргийг гүйцэтгэх;
 - iii) ОУИТБС-ын Бага хурал болон ОУИТБС-ын Гишүүдийн хуралд ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн тайланг танилцуулах;
 - iv) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийг гадаад асуудлуудад төлөөлөх;
 - v) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн шийдвэрүүдийн хэрэгжилтийн асуудлаар ОУИТБС-ын Ажлын албатай эргэх холбоо тогтоох;
 - vi) ОУИТБС-ын оролцогчид хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэх.
- 3) ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн дарга Удирдах зөвлөлийн хурлыг даргалж чадахгүй болсон тохиолдолд хуралд оролцож байгаа Удирдах зөвлөлийн гишүүд тухайн хурлыг даргалах Удирдах зөвлөлийн өөр нэг гишүүнийг томилж болно.

12 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн чиг үүрэг

- 1) ОУИТБС-ын Удирдах хороо нь цаг ямагт ОУИТБС-ын Холбооны эрх ашгийг дээдэлнэ. ОУИТБС-ын Удирдах хороо нь дараах үндсэн чиг үүргийг оруулаад ОУИТБС-ын Гишүүдийн хурлын шийдвэрт хамаарах ОУИТБС-ын Холбооны гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - a) ОУИТБС-ын Холбоонд сөргөөр нөлөөлж буй ерөнхий болон тусгай бодлогын асуудлуудыг авч хэлэлцэх;
 - b) ОУИТБС-ын Холбооны ажлын төлөвлөгөө болон төсвийг зөвшөөрөх;
 - c) ОУИТБС-ын Дэлхийн Бага хурал болон ОУИТБС-ын Гишүүдийн хурал зохион байгуулахыг зөвшөөрөх;
 - d) ОУИТБС-ын Бага хуралд (ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн даргаар дамжуулан) үйл ажиллагааны тайлан болон төлөвлөгөөг танилцуулах, ОУИТБС-ын Гишүүдийн хурлаар тэдгээрийг батлуулах;
 - e) ОУИТБС-ын Гишүүдийн сүүлийн ердийн хурлаас хойших санхүүгийн жилийн жилийн данс тооцоо болон аудитын тайланг (ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргаар дамжуулан) танилцуулах ;
 - f) ОУИТБС-н Гүйцэтгэх Захиралыг томилох;
 - g) ОУИТБС-ын Олон Улсын Нарийн Бичгийн Газрын ажилд (ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Даргаар дамжуулан) хяналт тавих, удирдан чиглүүлэх;
 - h) ОУИТБС-ын Холбооны Олон талт оролцогчдын шинжийг бүх түвшинд ОУИТБС-ын Холбоо болон

- түүний Хороодод байлгах, бүрэн тусгах;
- i) ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлж буй орнуудад хяналт-шинжилгээ, дэмжлэг үзүүлэх, Баталгаажуулалтын үйл явц, тухайлбал гомдол, санал зөрөлдөөнийг шийдвэрлэх, улс орны жагсаалтаас хасах асуудал, давж заалдах журам зэргийг багтаасан ОУИТБС-ын стандартыг баталж мөрдүүлэх;
 - j) ОУИТБС-ын Холбоо нь улс орны болон компанийн ажлын төлөвлөгөөний агуулга, баталгаажуулах ажиллагаа, санхүүжилтийн менежмент, төсөл, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр, аудит, төслүүдийг тайлагнах, батлахыг орсон менежмент болон үйл ажиллагааны илүү дэлгэрэнгүй журам, дүрмийг батлах;
 - k) ОУИТБС-ын Гишүүдийн ердийн хурал бүрийн өмнө ОУИТБС-ын Удирдах Зөвлөлийн Даргад нэр дэвшигчийг санал болгох;
 - l) Ёс зүйн дүрмийг батлах.

13 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн хороод

ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь цаашид үүсэх тусгай асуудлаар хороод байгуулж болно. Тэрхүү хороонд Удирдах зөвлөлийн 2 буюу түүнээс дээш тооны гишүүд эсхүл тэдгээрийн орлогчид орох бөгөөд хороодын бүрэлдэхүүн нь үндэслэлтэй бол ОУИТБС-ын Холбооны Олон талт оролцогчдын шинжийг тусгана. Тэрхүү хорооны мөрдөж ажиллах нөхцөлийг Хурлын тэмдэглэлийн бүртгэлд тэмдэглэнэ.

14 дугаар зүйл. ОУИТБС-ын удирдах зөвлөлийн үйл ажиллагаа ба хурал

1. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь жилд наад зах нь 2 удаа хуралдана. Жил бүр ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурлыг багадаа нэг удаа биечлэн хийнэ. Шаардлагатай бол ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурлыг виртуал байдлаар хийх боломжтой.
2. Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах зарыг наад зах нь 14 хоногийн өмнө ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргаар бичгээр хүргүүлэн хуралдуулна. Тэрнээс богино хугацаанд зарыг хүргүүлэх бол Удирдах зөвлөлийн бүх гишүүдийн зөвшөөрлийг бичгээр авна.
3. Удирдах зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр шийдвэрийг батлахад бүх хүчин чармайлтаа дайчилна. Удирдах зөвлөлийн гишүүдийн санаа бодлыг харгалзан ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн дарга санал хураах шаардлагатай эсэхийг шийднэ. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүн тус бүр нэг саналын эрхтэй. Саналыг бичгээр үйлдсэн итгэмжлэлээр өгөх боломжтой.
4. Шийдвэрийг батлах үед хурлын ирц бүрдсэн байхаас бусад тохиолдолд Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэр гаргахгүй. Удирдах зөвлөлийн гишүүдийн багадаа 2/3 нь хуралд оролцсоноор хурлын ирц бүрдэнэ. Үүнд Улс орнуудын тойргоос багадаа Удирдах зөвлөлийн 2 гишүүн (Санаачилгыг хэрэгжүүлж улс болон Дэмжигч улсаас тус бүр нэг), Иргэний нийгмийн байгууллагуудын тойргоос Удирдах зөвлөлийн нэг гишүүн, Компаниудын тойргоос Удирдах зөвлөлийн нэг гишүүн тус тус байна.
5. Санал өгөх шаардлагатай бол тухайн шийдвэрийн зорилгоор 13 санал шаардаж байгаа шаардлага хангасан олонх шийдвэрүүдийг батлах бөгөөд хэрэгжүүлэгч улс орнуудын сонгуулийн дэд тойргоос авсан 1/3-ыг оролцуулаад тойрог тус бүрээс сонгогдсон Удирдах зөвлөлийн гишүүний багадаа 1/3-н саналын дэмжлэгийг оруулах ёстой.
6. Удирдах зөвлөлийн гишүүн нь тэрээр шууд болон хувийн ашиг сонирхол бүхий аливаа асуудал эсхүл зохицуулалттай холбогдуулан эсхүл түүний үнэнч байдалдаа итгэлтэй байхад нөлөөлөх аливаа бусад тусгай нөхцөл байдал үүссэн тохиолдолд санал өгөхгүй. Удирдах зөвлөлийн гишүүн нь тэр талаар олж мэдсэн даруйдаа аль болох хурдан тэрхүү ашиг сонирхлыг ОУИТБС-ын Удирдах хороонд танилцуулах бөгөөд Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ. Удирдах зөвлөлийн гишүүн санал өгөх эрхгүй асуудлаар шийдвэр гаргах үед хуралд оролцсон Удирдах зөвлөлийн гишүүний ирцийг тооцохгүй. Энэ нь Удирдах гишүүний орлогчийг тухайн асуудалд санал өгөхөөс түдгэлзүүлэхгүй.
7. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь Удирдах зөвлөлийн хурлаас гадуур шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой журам тогтоож болно. Тэрхүү журмын дагуу Удирдах зөвлөлийн хурлаас гадуур гаргасан аливаа шийдвэрийг тухайн шийдвэрийг гаргаснаас хойш Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд бүртгэнэ.
8. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлыг дангаар нь сонгох, эсхүл гарын үсэг зурах эрх бүхий хоёр буюу хэд хэдэн Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож болох бөгөөд тэдгээрийн аль нэг нь хамтран гарын үсэг зурж болно.

15 дугаар зүйл. ОУИТБС-ын Олон Улсын Нарийн Бичгийн Газар

1. ОУИТБС-ын Олон Улсын Нарийн Бичгийн Газар нь Гүйцэтгэх Захирал болон бусад шаардлагатай ажилтнуудаас бүрдэнэ. Ажлын албаны гишүүд нь ОУИТБС-ын Гишүүдтэй шууд эсхүл шууд бусаар гэрээ байгуулсан гишүүд байна.
2. Ажлын алба нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу Тэргүүнээрээ дамжуулан ОУИТБС-ын Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллана.
3. Ажлын албаны Гишүүдийн шинэчилсэн бүртгэлийг ямагт хөтөлнө.
4. Ажлын албаны эдгээр Дүрмүүд болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлийг хөтөлнө.
5. Ажлын албаны бүх ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурал, Гишүүдийн хурал болон ОУИТБС-ын бага хурлын тэмдэглэлийг “Хурлын тэмдэглэл”-ийн бүртгэлд хөтөлнө. Тэрхүү бүх хурлын тэмдэглэлийг ОУИТБС-ын веб сайтад хэвлэн нийтэлнэ. Тэрхүү хурлын тэмдэглэлүүдэд хуралд оролцсон этгээдүүдийн нэрс, хурлаас гаргасан шийдвэрүүд, боломжтой бол шийдвэрийн үндэслэлийг дурдана.

16 дугаар зүйл. ОУИТБС-ын Гүйцэтгэх Захирал

1. Гүйцэтгэх захирал нь ОУИТБС-ын холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, шаардлагатай боловсон хүчнийг сонгон шалгаруулах, ОУИТБС-ын холбооны хөгжилд хяналт тавих, Удирдах зөвлөлд дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллана. Гүйцэтгэх захирал нь ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн даргаар дамжуулан Удирдах зөвлөлд ажлаа тайлагнах бөгөөд Нарийн бичгийн газрын үйл ажиллагааг хариуцна.
2. Гүйцэтгэх захирал эсвэл Нарийн бичгийн газраас томилсон түүний орлогч нь бүх ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн хурал, Гишүүдийн хурал болон Бага хуралд нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэнэ.
3. Гүйцэтгэх захирал нь Гүйцэтгэх захирлын орлогчийг томилж ОУИТБС-ын холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, Гүйцэтгэх захирлын эзгүйд орон ажилуулна.

17 дугаар зүйл. Санхүүжилт

- 1) ОУИТБС-ын холбоо нь ашгийн бус холбоо юм. Тус холбооны санхүүжилт нь дэмжигч улс орнууд, хэрэгжүүлэгч орнууд, компаниуд, санхүүгийн байгууллага, сангуудын хандив, хоёр болон олон талт хандивлагчдын буцалтгүй тусламж, ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс тогтоосон бусад агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн оруулсан хувь нэмэр мөн төслийн шинжтэй санхүүжилт зэргээс бүрдэнэ.
- 2) Түүнчлэн, ОУИТБС-ын холбоо нь мөнгөн бус сайн дурын хандив тусламжаар санхүүжиж болно.

18 дугаар зүйл. ОУИТБС-ын данс, санхүүжилтийн менежмент ба төлбөр

1. ОУИТБС-ын Холбоо нь Нарийн бичгийг газраар дамжуулан ОУИТБС нэр дээр нээсэн хэд хэдэн данс эзэмшинэ. Эдгээр дансыг ОУИТБС-ын Холбооны зорилго болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс баталсан ажлын төлөвлөгөөнд хамаарах аливаа үйл ажиллагаанд ашиглаж болно. Уг санхүүжилтийг захиргаа болон засаглалын зардал, улс орны тусгай ба олон талт үйл ажиллагаануудад ашиглаж болно.
2. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын данс бүртгэл, тооцоонд жил тутам аудит хийх үүрэгтэй хөндлөнгийн, хараат бус аудиторыг томилж ОУИТБС-ын Удирдах зөвлөлд бичгээр үйлдсэн аудитын тайланг танилцуулуулна.
3. ОУИТБС-ын Удирдах зөвлөл нь ОУИТБС-ын данс бүртгэл, тооцоотой холбоотой тайлан болон аудитын төлөвлөгөөг боловсруулан, ОУИТБС-ын үйл ажиллагааны дүрэм журамд нэмэлтээр оруулна.

19 дугаар зүйл. Нэмэлт, өөрчлөлт

1. 8 дугаар зүйлийн дагуу зарлагдсан, ОУИТБС-ын Гишүүдийн Хуралд нийт гишүүдийн 2/3 нь оролцон хуралдсан хурлаар эдгээр Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг холбогдох шийдвэрээс дөрвөн 7 хоногийн өмнө ОУИТБС-ын бүх гишүүдэд бичгээр хүргүүлнэ.

20 дугаар зүйл. Гишүүнчлэлээс татгалзах, татан буулгах

1. Гишүүн нь ОУИТБС-ын Холбооноос хэдийд ч гарч болно. Гүйцэтгэх захирал гишүүнчлэлээс татгалзах тухай хүсэлтийг бичгээр хүлээн авснаар тэрхүү татгалзал хүчин төгөлдөр болно.
2. ОУИТБС-ын Холбоог 8 дугаар зүйлийн заалтын дагуу Гишүүдийн хурлаар татан буулгаж болно. Татан буулгах саналыг холбогдох шийдвэрээс дөрвөн 7 хоногийн өмнө ОУИТБС-ын бүх гишүүдэд бичгээр танилцуулна.
3. Татан буугдах тохиолдолд ОУИТБС-ын Холбооны өмч хөрөнгийг ОУИТБС-ын Холбооны ижил төстэй зорилгод болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн тодорхойлсноор ашиглана. Ингэж хийхдээ ОУИТБС-ын Гишүүдийн хурлын зөвшөөрлийг авна.

21 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Эдгээр дүрэм нь ОУИТБС-ын Холбооны үндсэн дүрмийн дагуу хүчин төгөлдөр болох бөгөөд ОУИТБС-ын Холбоо татан буугдах хүртэл хүчинтэй байна.

БҮЛЭГ 2

ОУИТБС-ЫН СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН УДИРДАМЖ

Энэ хэсэгт тойрогт нэр дэвшүүлэх, гишүүнчлэл, удирдлагын үйл явцыг тоймлон харуулсан ОУИТБС-ын тойргийн удирдамжийг тайлбарласан болно.

2006 оны 10 дугаар сард Ослогийн бага хурлаар баталсан Олон улсын зөвлөх бүлгийн тайланд “Оролцогч талуудын тойргууд нь Удирдах зөвлөлд хэрхэн өөрсдийгөө төлөөлөх тухайгаа хэлэлцэн тохиролцсон байх ёстой. Энэ нь тойрог тус бүрээс (i) төлөөлөгчөөр сонгогдох; (ii) сонгон шалгаруулах ажиллагаанд оролцох шаардлагыг хангасан этгээдүүдийг хэрхэн тодорхойлох тухайгаа урьдчилан тохирсон байхыг шаардах хэрэгтэй” хэмээн зөвлөжээ.

Оролцогч талын тойргийг мөн тойргийн Холбоон дахь гишүүнчлэлийн хэмжээ болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн суудлын тоог тогтоодог ОУИТБС-ын Дүрэмд тодорхойлсон болно. ОУИТБС-ын зарим нэг тойргийг албан бусаар дэд хэсгүүдэд хуваасан.

Тойрог болон дэд тойргийн удирдамжийг ОУИТБС-ын eiti.org/constituencies вэб сайтаас авах боломжтой. ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гишүүд, орлогчид болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн жагсаалтыг eiti.org/eiti-board хаягаас авах боломжтой.





Олборлох Үйлдвэрлэлийн
Ил Тод Байдлын Санаачилга

Улс орны байгалийн баялаг иргэдийнх гэдэгт
бид итгэдэг.

Бидний эрхэм зорилго бол байгалийн баялгийн
менежментийн талаарх ойлголтыг сурталчлах, төрийн
болон компанийн засаглалыг бэхжүүлэх, олборлох
салбарын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд
шаардлагатай мэдээллээр хангах явдал юм.

eiti.org